

**АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БОЛОН ГАДААД ОРНЫ ТУРШЛАГЫГ СУДЛАХ АЖЛЫН ТАЙЛАН**

2018 он

АГУУЛГА

1. АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУРШЛАГА, ЧИГ
ХАНДЛАГА.....2
2. АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН....51
3. АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ,
ХИЙДЛИЙГ ОЛЖ ИЛРҮҮЛЭХ, ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХООРОНДЫН УЯЛДАА
ХОЛБООНЫ ТАЛААР.....80

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУРШЛАГА, ЧИГ ХАНДЛАГА

НЭГ. ДЭЛХИЙ НИЙТИЙН ЧИГ ХАНДЛАГА

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаанд согтууруулах ундааны хор хөнөөлийг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор таван үндсэн чиглэлийг санал болгосон нь:¹

1. Архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд тусгай зөвшөөрлийн арга хэрэгслээр хяналт тавих, эсхүл төрийн зүгээс уг аж ахуйн үйл ажиллагаанд монополь хэлбэрээр оролцох;

2. Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх газруудын байршил болон тоо хэмжээг зохистой байдлаар хязгаарлах;

3. Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх цэгүүдийн ажиллах цагийн хуваарьт хязгаарлалт тогтоох;

4. Архи, согтууруулах ундааг худалдан авах, түүнийг хэрэглэж болох насны доод хязгаарыг тогтоож, мөрдүүлэх;

5. Олон нийтийн газарт архи, согтууруулах ундаа хэрэглэх бодлого, журмыг тодорхой болгон мөрдүүлж хэвшүүлэх зэрэг байна.

Ерөнхийдөө согтууруулах ундааны талаар баримтлах баримтлах 4 төрлийн бодлогын хэлбэр байдаг гэж үздэг бөгөөд энэ нь:

- Бүрэн хориглох;
- Нийлүүлэлтийг хязгаарлах;
- Эрэлтийг хязгаарлах;
- Хор нөлөөг багасгах гэсэн бөгөөд эдгээр 4 төрлийн бодлогыг **татвар, тусгай зөвшөөрөл, хориглолт, хязгаарлалт гэсэн 3 төрлийн арга хэрэгслийг ашиглан хэрэгжүүлдэг** байна. ²

Улс орнуудын туршлагаас харахад нийтлэг байдлаар дээрхи бодлогын чиглэлүүдийг бүгдийг хослуулан хэрэгжүүлдэг бөгөөд согтууруулах ундааны хэрэглээний соёлоос шалтгаалан согтууруулах ундааны хэрэглээг бууруулах талаар төрөөс баримтлах бодлогоо тодорхойлдог байна. Жишээлбэл, согтууруулах ундааны зохисгүй буюу хэтрүүлэн хэрэглээ ихтэй орнуудын хувьд төрөөс согтууруулах ундаатай холбоотой бүхий л үйл ажиллагаанд хуулийн тусламжтайгаар хатуу хяналт тавих хандлагатай байна.

Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдаалах, үйлчлэх ажиллагааны үндэсний хяналт

Архи, согтууруулах ундааны олдоцыг хязгаарлах, түүнийг хэн дуртай нь хүссэн үедээ олох, хэрэглэх боломжийг хязгаарлах чухал механизмуудын нэг нь архи, согтууруулах ундааны эргэлтэд

¹ Global status report on alcohol and health. 2016. World Health Organization
http://www.who.int/substance_abuse/publications/global_alcohol_report/msbgsruprofiles.pdf

² Joel Frube, "Alcohol Regulation and Traffic Safety", on "Traffic Safety and Alcohol Regulation" symposium, June 5-6, California.

тавих үндэсний хяналтын тогтолцоо бөгөөд “монополь” болон “зөвшөөрөл” гэсэн хоёр үндсэн загвартай байна.³

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн дийлэнхи орон буюу 126 орон нь архи, согтууруулах ундааг үйлдвэрлэхэд зөвшөөрлийн системийг ашигладаг бол 26 улс нь ийм төрлийн систем байхгүй гэсэн байна. Түүнчлэн 136 орон нь архи, согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхэд тусгай зөвшөөрөл шаарддаг системтэй байна.⁴

Дэлхийн зарим улс орнууд архи, согтууруулах ундааны зах зээлд үйлдвэрлэх, тараах болон жижиглэн худалдан борлуулах зэрэг үе шатуудад нь “монополь” хэлбэртэйгээр оролцож хяналтыг хэрэгжүүлдэг туршлагатай бөгөөд шар айрагны тухайд 32 орон үйлдвэрлэлд нь “монополь” хэлбэрээр оролцдог бол дарсны тухайд 34 орон жижиглэн худалдан борлуулах үйл ажиллагаанд “монополь” хэлбэрээр оролцдог байна.

Зарим орнуудын хувьд зөвшөөрлийн хэлбэр болон “монополь” хэлбэрийн аль алийг нь хослуулан хамтад нь ашигладаг бөгөөд 32 улсад шар айрагны үйлдвэрлэлд улс нь “монополь” хэлбэрээр оролцож, худалдаалах, үйлчлэх үйл ажиллагаанд нь тусгай зөвшөөрлийн дагуу хяналт тавьдаг байна.

Улс орнуудын хувьд зөвшөөрлийн системийг хэрэгжүүлэхдээ харилцан адилгүй, төрөл бүрийн шалгуур шаардлагыг хуульчлан тогтоосон байдаг ба жишээлбэл, **АНУ-д** согтууруулах ундааны эргэлттэй холбоотой аливаа зөвшөөрөл авах тохиолдолд хүсэлт гаргагч этгээд нь хуулийн этгээд, эсхүл түүний удирдах албан тушаалтан нь хүсэлт гаргахаас өмнөх 5 жилийн хугацаанд хүнд гэмт хэрэгт холбогдох байгаагүй, 3 жилийн хугацаанд татварын ямар нэгэн зөрчил, гэмт хэрэг үйлдэж байгаагүй гэх шаардлагыг тавьдаг байна. Түүнчлэн явуулах үйл ажиллагааны төрлөөс хамааран тус бүрд тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулсан байдаг байна. Жишээлбэл, шар айрагны үйлдвэрлэлийн хувьд хуульд түүхий эд, үйлдвэрлэлийн техник технологи, аж ахуйн нэгжид тавигдах санхүү, эдийн засгийн шалгуур үзүүлэлт, үйл ажиллагаа явуулах байршил зэргийн талаархи шаардлага хангасан баримт бичгүүдийг гаргаж өгөх үүрэгтэй байна.

Япон Улсад согтууруулах ундааны зүйлийн үйлдвэрлэл явуулахад бүтээгдэхүүн тус бүр дээр үйлдвэрлэх доод хэмжээг тогтоож өгдөг бөгөөд хуулиар тогтоосон доод хэмжээ нь тухайбал, цагаан будааны архинд 60 000 литр, пиво 60 000 литр гэх мэт байдаг байна. Ийнхүү хуулиар доод хэмжээг тогтоож өгөх нь согтууруулах ундааны олон жижиг үйлдвэр бий болох, чанаргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрсдэлээс сэргийлэх бодлоготой холбоотой гэж үзэж байна.

Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх, үйлдвэрлэх цэгүүдийн тоонд хязгаарлалт тогтоох

Литва Улсын хувьд согтууруулах ундааг импортлох үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр хязгаарлалт тавьсан байдаг нь тус улсын хуулиар согтууруулах ундааг импортлох зөвшөөрлийг Засгийн газраас нь олгох бөгөөд зөвшөөрлийн тоо нь улс орны тухайн жилийн согтууруулах ундааны хэрэглээ, түүний эрүүл мэнд, эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөг тооцон 10-аас илүүгүй байхаар заасан байна.

Харин согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах цэгийн хувьд тухайн нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа хүн амын тооноос хамааран мөн хязгаарлах бодлогыг улс орнууд хэрэгжүүлдэг байна. Зарим орны хувьд хүн амын тоонд бус харин газар нутгийн хэмжээнд үндэслэн хязгаарлалтыг тогтоодог жишг ч байдаг байна. Жишээлбэл, Исланди Улсад 1 км кв нутаг дэвсгэрт 1-5 цэг байхыг зөвшөөрдөг бол Франци улсад 450 хүнд 1 цэг байхыг зөвшөөрдөг бөгөөд том хотуудад энэ нь 3000 хүн тутамд болж өсдөг байна. Согтууруулах ундааны төрлөөс хамааран уг хязгаарлалтыг мөн тогтоож болох бөгөөд жишээлбэл, Испани, Швед гэх зэрэг улсуудад зөвхөн спиртийн өндөр агууламж

³ Global status report on alcohol and health. 2016. World Health Organization

⁴ Global status report on alcohol and health. 2016. World Health Organization

бүхий согтууруулах ундааг худалдаалах, үйлчлэх цэгүүдэд тавих хязгаарлалт нь бусад төрлийн согтууруулах ундаанаас өөр байна.⁵

Харин зарим улс орнуудын хувьд:

- Тухайн нутаг дэвсгэрт байх ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг цэгийн тоо, байршил;
- Замын хөдөлгөөний байдал;
- Тухайн газар нутагт байрлах аж ахуйн нэгжүүд нь ямар төрлийн үйл ажиллагаа явуулдаг;
- Сүм болон сургууль, эмнэлгийн зай;
- Бүсчлэх хуульд нийцэж байгаа эсэх;
- Тухайн газар нутагт гарсан гэмт хэрэг зөрчлийн тоо зэргийг харгалзан зөвшөөрөл олгох зохицуулалттай байна.

Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх цэгүүдийн ажиллах цагийн хуваарьт хязгаарлалт тогтоох

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн орнуудаас 30 хүрэхгүй хувь нь буюу 39-47 орон нь архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг газар болон согтууруулах ундааны төрлөөс хамааран ажиллах цагийн хуваарь болон уг үйл ажиллагааг эрхлэх цэгийн тоонд хязгаарлалт тавьдаг гэж мэдээлсэн байхад 50 орчим хувь нь /73-90 улс/ тухайн цэгүүдийн нээх цагийн талаар ямар нэгэн зохицуулалттай гэж мэдэгдсэн байна.⁶

Архи, согтууруулах ундааг худалдан авах, түүнийг хэрэглэж болох насны доод хязгаарыг тогтоож, мөрдүүлэх

2012 онд 15 улс шар айрагны төрлийн, 16 улс дарс, архины төрлийн согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүдээр үйлчлүүлж болох насны доод хязгаарын талаар ямар нэгэн зохицуулалтгүй гэж мэдээлсэн бол 21 улс бүх төрлийн согтууруулах ундааг худалдаалдаг цэгүүдээр үйлчлүүлж болох насны доод хязгаар байхгүй гэж мэдээлсэн байна.⁷

Хуулиар согтууруулах ундаа худалдан авч болох насны доод хязгаарыг тогтоосон улс орнуудын зохицуулалтаас харахад насыг 10-25 насны хооронд зохицуулсан байгаа ч хамгийн түгээмэл зохицуулалт нь 18 нас байгаа бөгөөд 115 улс ийм зохицуулалттай байна. Харин 15 улс согтууруулах ундааг худалдан авч болох насны доод хязгаарыг 16 нас гэж, 7 улсад 20 нас, 14 улсад 21 нас гэж тус тус заасан байна.⁸

Олон нийтийн газарт архи, согтууруулах ундаа хэрэглэх бодлого, журмыг тодорхой болгон мөрдүүлж хэвшүүлэх

Согтууруулах ундааны хэрэглээг багасгах зорилгоор дэлхийн улс орнууд олон нийтийн газарт согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон эрх зүйн зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлж байгаа бөгөөд 129 улс бүх төрлийн боловсролын байгууллага, түүний ойр орчинд, 119 улс эрүүл мэндийн байгууллага, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дээр, харин 58 улс ямар нэгэн баяр цэнгээн, нийтийг хамарсан арга хэмжээ болж байгаа газарт согтууруулах ундааг хэрэглэхийг хориглосон зохицуулалттай байна.⁹

Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газруудыг нийтлэг байдлаар нь бүлэглэн авч үзвэл:

- Эрүүл мэндийн байгууллага;
- Боловсролын байгууллага;
- Засгийн газрын байгууллага;

⁵ Regulations of Alcohol Marketing in 24 European Countries, National Foundation for Alcohol Prevention.

⁶ Global status report on alcohol and health. 2016. World Health Organization

⁷ State Laws to Reduce the Impact of Alcohol Marketing on Youth: Current Status and Model Policies

⁸ Underage drinking, Jan 2016, National Institute on Alcohol Abuse and Alcoholism

<https://pubs.niaaa.nih.gov/publications/aa67/aa67.htm>

⁹ Global status report on alcohol and health. 2016. World Health Organization

- Нийтийн тээврийн хэрэгсэл;
- Цэцэрлэгт хүрээлэн, гудамж, талбай;
- Спортын арга хэмжээ, тэмцээн уралдаан;
- Нийтийг хамарсан соёл амралтын арга хэмжээ;
- Ажлын байр;
- Шашны зан үйл үйлддэг газар зэрэг байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн зарим улс, орнууд согтууруулах ундааны хэрэглээг багасгах, тэр дундаа жолооч нарыг согтууруулах ундааны хор хөнөөлөөс сэргийлэх зорилгоор шатахуун түгээх станцуудад согтууруулах ундаа худалдаалахыг хориглож эхэлсэн ба энэхүү зохицуулалт нь 2008-2012 оны хооронд эрчимтэй нэвтэрсэн байна.

Одоогийн байдлаар шар айрагны худалдааны талаар 37 хувь буюу 61 улсад энэ төрлийн хориглолт үйлчилдэг бөгөөд энэ үзүүлэлт 2008 онд 31 хувь буюу 46 улс байсан байна. Дарсыг 64 улс, архины төрлийн согтууруулах ундааг 65 улсад шатахуун түгээх станцын орчим худалдаалахыг хориглосон байна.

Тээврийн хэрэгсэл жолоодож байгаа этгээдийн цусан дахь спиртын хэмжээний талаархи зохицуулалтыг судлахад ДЭМБ-ын гишүүн орнуудаас 61 орон нь 0.05-0.07%, 46 орон нь 0.08-0.15% ВАС, 18 орон нь ямар нэгэн хязгаарлалт байхгүй, 25 орон нь ямар ч хэмжээгээр цусан дахь спиртийг хууль бус гэж үздэг байна.¹⁰

Архи, согтууруулах ундаа маркетингийн үйл ажиллагаанд хяналт тавих

Архи, согтууруулах ундаа маркетингийн үйл ажиллагаанд тавих хяналт нь архи, согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэхгүй байх, түүний хор хөнөөлийг олон нийтэд таниулахад чухал ач холбогдолтой бөгөөд дэлхийн дийлэнхи улс орнууд энэ талаар тодорхой төрлийн зохицуулалт боловсруулан хэрэгжүүлдэг байна. Зарим судалгаагаар согтууруулах ундааны ямар нэгэн хязгаарлалтгүй маркетингийн үйл ажиллагаа нь архины хэрэглээг нэмэгдүүлэх гол хүчин зүйлсийн нэг болдог төдийгүй, залуу болон өсвөр насныхан уг маркетингийн улмаас архи, согтууруулах ундааг хэрэглэж эхлэх өндөр магадлалтай гэдэг нь тогтоогджээ. Энэ нь ялангуяа бага болон дунд орлоготой улс орнуудад түлхүү ажиглагдаж байгаа бөгөөд эдгээр улс орнуудын хүн амын дундаж насжилт нь ихэвчлэн залуу болон дунд үеийхэн зонхилдог ажээ.¹¹

Архи, согтууруулах ундааны маркетингийн үйл ажиллагаан дахь хязгаарлалт нь шууд болон шууд бус зар сурталчилгаа, зар сурталчилгааны агуулга, аливаа арга хэмжээ, үйл ажиллагааг ивээн тэтгэх, залуу үеийхэнд чиглэсэн сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа болон шинэ төрлийн маркетингийн үйл ажиллагааг зэргийг хамаардаг байна.

Зар сурталчилгаанаас гадна дэлхийн зарим улс орнууд телевизийн нэвтрүүлэг болон спортын тэмцээн уралдааны үед согтууруулах ундааны маркетингийн үйл ажиллагааг, согтууруулах ундааны реклам, сурталчилгааг байршуулахыг хориглох хэлбэрээр хязгаарладаг байна. Тухайлбал, 2012 онд нийт 168 улс орноос 66 нь телевизийн нэвтрүүлгийн үед шар айраг, түүний реклам сурталчилгааг байршуулах үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хориглосон байна. Эдгээр хязгаарлалт нь цаг хугацааны болон агуулгын хэлбэртэй байх бөгөөд эдгээр улсуудын тэн хагас нь согтууруулах ундаа үйлдвэрлэгч болон худалдан борлуулагч этгээдээс спортын арга хэмжээ, тэмцээн уралдааныг ивээн тэтгэхийг хориглосон байна.

Аливаа хязгаарлалт, хориглолт тогтоосон хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлэх, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох механизм байгаа эсэхийг судлан үзэхэд нийт 98 орон энэ талаар тогтоосон арга хэрэгсэл ашигладаг гэсэн бөгөөд зарим нь нэгээс илүү олон арга хэрэгсэл ашигладаг байна. 60 улс нь засгийн газрын харьяа асуудал хариуцсан байгууллага, төрийн бус байгууллага, бие даасан нэгж, байгууллагаар дамжуулан хянадаг, 61 орон нь гомдол гаргах-хяналт шалгалтын механизмыг хэрэглэдэг, 45 улс нь илэрсэн зөрчил тус бүрийг шалгах замаар хяналт тавьдаг байна.

¹⁰ Global status report on alcohol and health. 2016. World Health Organization

¹¹ Eyes on Ages, A research on alcohol age limit policies in European Member States. Legislation, enforcement and research. 2012

Маркетингийн үйл ажиллагаанд тавьсан хязгаарлалт, хориглолтыг зөрчсөний төлөөх хариуцлага нь улс орон бүрт харилцан адилгүй бөгөөд тодорхой хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах буюу шоронд суулгахаас эхлүүлэн торгох, тусгай зөвшөөрлийг нь цуцлах хүртэл арга хэмжээ авдаг байна.¹²

Архи, согтууруулах ундааны үнийг зохицуулах

Олон тооны нийтлэл, судалгааны ажлуудад дурдсанаар согтууруулах ундааны үнийг зохицуулах нь согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхээс болон залуу, өсвөр насныхныг согтууруулах ундааны хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой гэж үздэг байна. Үүний тод жишээ нь 2009, 2010 онд хэвлэгдсэн судалгааны ажлуудад архи, согтууруулах ундааны үнэ өссөнөөр архи, согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой хүний амь нас эрсдэх болон эрүүл мэндэд нь хохирол учирах явдал багасдаг байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжөөс харахад тус байгууллага гишүүн орнууддаа согтууруулах ундааны спиртын агууламжаас шалтгаалан татварыг ялгамжтай ногдуулах, ногдуулах татварын хэмжээг зохистой тогтоох, үүнтэй зэрэгцүүлэн хуулийг зохистой хэмжээнд хэрэгжүүлдэг механизмыг бүрдүүлэхийг зөвлөсөн байна. Мөн үүнээс гадна хүн амын амьдралын түвшин болон бодит орлогын түвшингээс хамааран архи, согтууруулах ундааны үнийг байнга хянаж, шинэчлэн тогтоож байх болон тогтоосон үнээс доогуур үнээр архи, согтууруулах ундааг худалдах, үнийн хямдрал зарлахыг хориглох, боломжтой тохиолдолд архи, согтууруулах ундааг худалдаалах доод үнийг тогтоохыг зөвлөсөн байна.

Архи, согтууруулах ундааны хор хөнөөлийг багасгах

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн 167 орноос 45 орон нь согтууруулах ундаагаар хариуцлагатай үйлчлэх /responsible beverage service/ сургалтыг согтууруулах ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн ажилтнууд /үйлчлэгч, бармен/ -д зориулан зохион байгуулдаг, заавал хамрагддаг байх шаардлагыг тавьдаг байна. Уг сургалтыг 17 улсад нь архи, согтууруулах ундааны үйлчилгээг хянах, зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, 18 улсад нь хувийн хэвшлийн байгууллагууд зохион байгуулдаг байна.¹³

Согтууруулах ундаа сав, баглаа, боодол дээр төрөл бүрийн анхааруулга, сэрэмжлүүлэг байршуулах нь дэлхийн дийлэнх улс орнуудын хувьд согтууруулах ундааны хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх гол арга хэрэгслийн нэг болсон байна. Нийт 116 улс архи, согтууруулах ундааны сав, баглаа, боодол дээр хатуулгын хэмжээний талаар мэдээллийг байршуулахыг шаардсан зохицуулалттай бөгөөд харин согтууруулах ундааны сурталчилгааны материал дээр согтууруулах ундааг хэтрүүлсэн хэрэглэсний улмаас үүсэх хор хөнөөлийн талаархи сэрэмжлүүлгийг байршуулах шаардлагыг зөвхөн 41 улсад тавьдаг бол 31 улсад согтууруулах ундааны сав боглоо боодол дээр энэ төрлийн сэрэмжлүүлэг, анхааруулгыг байршуулахыг шаарддаг байна.¹⁴

Архи, согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэлтэй тэмцэх

Хууль бусаар буюу зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуульд заасан шаардлагыг зөрчин үйлдвэрлэсэн согтууруулах ундаа нь нийт дэлхийн зах зээл дээр эргэлдэж байгаа согтууруулах ундааны 25 хувийг эзэлдэг гэсэн судалгаа байдаг бөгөөд тийнхүү үйлдвэрлэгдэж байгаа согтууруулах ундаа нь өртөг багатай тул үүнийг дагаад үнэ хямдтай байдаг байна. Үүний улмаас хууль бусаар үйлдвэрлэсэн согтууруулах ундааг нийгмийн доогуур түвшний ядуу, бага орлоготой бүлэг түлхүү хэрэглэдэг бөгөөд энэ нь мөн согтууруулах ундааны хэрэглээг өсгөх нэг шалтгаан болдог байна.

¹² Addressing the harmful use of alcohol. A guide to developing effective alcohol legislation. 2011. World Health Organization. Western Pacific Region.

¹³ Addressing the harmful use of alcohol. A guide to developing effective alcohol legislation. 2011. World Health Organization. Western Pacific Region.

¹⁴ Best Practice in Prevention,

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гишүүн орнууддаа өгсөн зөвлөмжид согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэлтэй тэмцэх, хууль бусаар үйлдвэрлэсэн согтууруулах ундааг олж илрүүлэх, устгах, тэдгээрийг татварын тоо бүртгэл, системд бүрэн хамруулах талаар идэвхитэй үйл ажиллагаа явуулах талаар зөвлөмж өгсөн байдаг.

2011 онд ОХУ-ын хууль тогтоох дээд байгууллага согтууруулах ундааг үйлдвэрлэх болон худалдах тухай холбооны улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг нэмэлт, өөрчлөлт нь зах зээл дэх согтууруулах ундааны хэмжээг багасгах зорилготой байна. Тухайлбал, энгийн иргэд болон албан тушаалтан, аж ахуйн нэгжүүд насанд хүрээгүй хүнд архи, согтууруулах ундааны зүйлийг худалдаалахгүй байх, хэрэглэх боломж олгохгүй байх талаар тодорхой үүрэг болгосон зохицуулалтыг нэмж, хэрэв зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгосон бөгөөд үүний зэрэгцээгээр согтууруулах ундааны хор хөнөөлийг багасгах багц арга хэмжээнүүдийг санал болгосны дотор согтууруулах ундааны савлагааг багасгах, сав, баглаа боодол дээр заавал тэмдэглэгээ хийх зэрэг байна. Үүнээс гадна, уг хуульд согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэлтэй тэмцэх тодорхой зохицуулалтуудыг агуулсан байна.¹⁵

Дэлхийн улс орнуудын хувьд хууль бусаар үйлдвэрлэсэн согтууруулах ундааны хэмжээг мэргэжилтнүүд, шинжээчдийн судалгаан дээр тулгуурладаг бол, зарим нь хураан авсан, илрүүлсэн хууль бус согтууруулах ундааны хэмжээ болон санал асуулгын тусламжтайгаар тодорхойлж, хууль бус согтууруулах ундаатай тэмцэх асуудлыг үндэсний хөтөлбөр, бодлогодоо тусган хэрэгжүүлж байна.

Мониторинг

Нөхцөл байдлын байнгын мониторинг болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт нь согтууруулах ундааны хор хөнөөлийг бодитойгоор тооцоолох, түүнтэй хийх тэмцлийг үр дүнтэй болгоход маш чухал ач холбогдолтой бөгөөд энэхүү системийг нэвтрүүлэхийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гишүүн орнууддаа зөвлөсөн байдаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн орнуудаас 109 орон нь 2000 оноос хойш нэг, буюу түүнээс удаа насанд хүрсэн иргэдийнхээ дунд согтууруулах ундааны хэрэглээний талаар үндэсний хэмжээний судалгаа хийсэн бөгөөд үүнээс 93 нь мөн насанд хүрээгүй буюу залуу насны иргэдийн дунд ижил төрлийн судалгааг хийсэн байна.

Мониторинг болон тасралтгүй хяналт тавих үйл ажиллагаанд яг юуг согтууруулах ундаа гэж тодорхойлох, уг тодорхойлолт нь ойлгомжтой, тодорхой, нэг мөр ойлгогдохуйц байх нь чухал ач холбогдолтой бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн 106 орон энэ төрлийн тодорхойлолтыг хууль тогтоомжиндоо тусгаснаас 45 нь согтууруулах ундааг 0-1 хувь спирт агуулсан бүтээгдэхүүнийг, 1 орон буюу Беларусь Улс согтууруулах ундаа гэж 7 хувиас дээш хэмжээний спирт агуулсан бүтээгдэхүүнийг ойлгохоор тодорхойлсон байна. Бусад улс орнуудын хувьд 0.8 - 1.3, түүнээс дээш хувийн спирт агуулсан бүтээгдэхүүнийг согтууруулах ундаанд тооцохоор харилцан адилгүй зохицуулалттай байна.¹⁶

Судалгаанд оролцсон улс орнуудас 71 нь согтууруулах ундааны хэрэглээ, түүний хор хөнөөлийг судлах үндэсний хэмжээний мониторинг, хяналтын механизмтай гэсэн бөгөөд үүнээс 55 улс нь согтууруулах ундааны хэрэглээний талаархи мэдээллийг цуглуулдаг, 54 улс нь хэрэглээнээс үүсэх үр дагаврын талаар мэдээлэл цуглуулдаг гэсэн бол маш бага буюу 25 улс нь нийгмийн үр дагаврыг, 11 улс нь бодлогын хэмжээний хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийг цуглуулдаг гэсэн байна.

15

Федеральный закон от 22.11.1995 N 171-ФЗ (ред. от 29.07.2017) "О государственном регулировании производства и оборота этилового спирта, алкогольной и спиртосодержащей продукции и об ограничении потребления (распития) алкогольной продукции" http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8368/

¹⁶ Global Status Report: Alcohol Policy, 2014. World Health Organization. Department of Mental Health and Substance Abuse, Geneva

Татвар

Согтууруулах ундаанд татвар ногдуулах нь аливаа улс орны согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлах бодлогын салшгүй нэг хэсэг байна. Дэлхийн улс орнууд согтууруулах ундааны үнийг өсгөх нь согтууруулах ундааны хэрэглээ болон түүнээс үүдэн гарах хор хөнөөлийг бууруулдаг гэж үздэг бөгөөд зарим судалгаанд согтууруулах ундааны үнэ 10 хувиар өсөхөд түүний хэрэглээ дунджаар 5 хувиар буурдаг гэж дүгнэжээ.¹⁷

Дэлхийн дийлэнхи улс орнуудад согтууруулах ундаанд ногдуулах татварын хэмжээ тухайн согтууруулах ундааны төрлийн спиртийн агууламжаас шууд хамааралтай байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд тухайлбал, **Норвеги** Улсад 2010 оны байдлаар спиртэд литр тутамд 6,18 крон, дарсанд 4,3 крон байна. Түүнчлэн **Швед** улсад 2,25-4,5 хувийн хатуулагтай дарсанд ногдуулах татвар 7,58 крон байхад, 4,5-7 хувийн хатуулагтай дарсанд ногдуулах татвар 11,20 крон байна. Энэмэтчилэн улс орнуудын хувьд ногдуулах татварын хэмжээ нь харилцан адилгүй байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд улс орнууд онцгой албан татвараас гадна бусад шууд бус татварыг ногдуулах туршлагыг нэвтрүүлж байна. Тухайлбал, **Бельги** улс 2004 оны 4 сараас эхлэн сав, баглаа, боодлын татвар ногдуулж эхэлсэн бөгөөд **Болгар, Финлянд, Хорват, Латви** зэрэг улсуудууд энэ төрлийн татварыг нэвтрүүлсэн байна. Үүнээс гадна байгаль орчны татвар, нийгмийн аюулгүй байдлын таввар зэрэг нэмэлт татвар, хураамжуудыг ногдуулж байгаа нь харагдаж байна.¹⁸

Нэгдсэн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий субъектын талаар

Согтууруулах ундааны хэрэглээг багасгах, түүнийг хянах асуудлаар улсын хэмжээнд хэрэгжүүлэх нэгдсэн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллын хувьд улс бүр өөр өөрийн онцлогоос хамааран харилцан адилгүй дараахь хэлбэртэй байна:

- Чиг үүргийн буюу тухайн асуудлыг дагнан хариуцсан төрийн захиргааны байгууллагатай;
- Засгийн газраас байгуулагдсан хороо, зөвлөл;
- Салбарын мэргэжлийн нийгэмлэг, холбоод, төрийн бус байгууллага.

Дээрхи хэлбэрүүдээс нийтлэг байдлаараа чиг үүргийн буюу уг асуудлыг дагнан эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний нэгжээр дамжуулан удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд хамгийн түгээмэл арга нь тусгай зөвшөөрлийн тогтолцоог ашиглан зохицуулалт хийж буй хандлага дийлэнхи хувийг эзэлж байна.

Цаашдын чиг хандлага

2008-2012 оны хооронд Дэлхийн эрүүл мэндий байгууллагын гишүүн орнууд өөрийн улсын бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг согтууруулах ундааны хэрэглээг багасгах, хор хөнөөлийг багасгах чиглэлээр дараахь 5 чиглэлээр өөрчилсөн нь ажиглагдаж байна:

- Манлайлал, хор хөнөөлийн талаар нийтэд таниулах, уг үйл ажиллагаанд олон нийтийг татан оруулах;
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдалтай тэмцэх;
- Согтууруулах ундааны олдоц, зах зээл дээрх тоо хэмжээг багасгах;
- Маркетингийн үйл ажиллагааг хязгаарлах;
- Согтууруулах ундааны хэрэглээний хор хөнөөлийг бууруулах.

ХОЁР.ТОДОРХОЙ УЛС ОРНУУДЫН ЖИШЭЭ

Өмнөд Африк Улсын Засгийн газар 2010 оноос эхлэн согтууруулах ундааны хор хөнөөлийг багасгах зорилго бүхий үндэсний хөтөлбөр, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий өндөр түвшний албан тушаалтнуудыг оролцуулсан Хороог байгуулан ажиллаж байна. Уг хороо нь архи, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, түүний хор хөнөөлийн талаар бүх нийтийг

¹⁷ Fogarty J, The Nature of the Demand for Alcohol; understanding elasticity, British food journal, 2006.

¹⁸ Regulations of Alcohol Marketing in 24 European Countries, National Foundation for Alcohol Prevention.

соён гэгээрүүлэх үндсэн чиг үүрэг бүхий засгийн газрын яам, агентлагуудын удирдлагуудаас /Эрүүл мэндийн яам, Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, Зам тээврийн яам, Сангийн яам, Спорт, аялал жуулчлалын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Дэд бүтэц, худалдааны яам, Хууль зүйн яам, Цагдаагийн байгууллага зэрэг / бүрддэг байна. Хороог хүн амын хөгжил, нийгмийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь ахлан ажилладаг бөгөөд Хорооны ахлагчийн үүрэг нь дээрхи байгууллагуудын архи, согтууруулах ундааны эргэлтийг бууруулах, насанд хүрээгүй этгээдэд архи, согтууруулах ундааг хэрэглүүлэхгүй байх, түүний хөр аюулыг бууруулах талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах явдал юм.

Хорооны бүрэлдэхүүнд багтсан яам, бусад байгууллагууд нь бүгд өөр өөрийн чиг үүргийн хүрээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт доор төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ба үүний нэг жишээ нь Өмнөд Африкийн Цагдаагийн байгууллага нь зохих зөвшөөрөлгүй дэлгүүрүүд болон согтууруулах ундаагаар үйлчилдэг, зарж борлуулдаг бусад цэгүүдийг олж илрүүлэх, үйл ажиллагааг нь таслан зогсоох арга хэмжээ авч, үйл ажиллагаагаа идэвхижүүлсэн; Зам тээврийн яам нь цагдаагийн цагдаагийн байгууллагатай хамтран согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдалтай хийх тэмцлээ идэвхижүүлсэн; нийгмийн хамгааллын байгууллагууд нь согтууруулах ундаанд донтох эмгэгтэй хүмүүст үзүүлэх туслалцааг илүү хүртээмжтэй, нээлттэй, иргэдэд ойр болгох талаар үр дүнтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн зэрэг арга хэмжээнүүдийг авсан бөгөөд Хорооны үйл ажиллагааны үр дүн жилээс жилд тодорхой харагдаж байгаа гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас үзсэн байна.

Белорусь Улс 2011 онд 2015 он хүртэл хэрэгжүүлэх согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх, түүний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилтууд нь согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсний улмаас үйлдэгддэг гэмт хэрэг, зам тээврийн осол хэрэг, үйлдвэрлэлийн осол, хордолтын улмаас үүссэн нас баралт, согтууруулах ундаанд донтох эмгэг болон согтууруулах ундаанаас хамаарал бүхий залуучуудын тоог бууруулах ажээ.

Энэхүү хөтөлбөрийг баталж хэрэгжүүлснээр Беларусь Улс шинэ бодлого, шинэ арга хэмжээ, шинэ санаачлага дэвшүүлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү бодлогын хүрээнд архи, согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг чангатгах, 07-22 цагийн хооронд архи, согтууруулах ундааны зар сурталчилгааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, цацахыг хориглох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр бодитой үр дүнд хүрсэн байна.¹⁹

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн орнуудын 39.5 хувь нь буюу 66 нь архи, согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлах, түүний хор аюулыг бууруулах зорилготой үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Үүнээс 30 нь үндэсний Засгийн газар, 18 нь хууль тогтоох дээд байгууллага, 13 нь Засгийн газрын харьяа тодорхой яам болон бусад байгууллагуудын хамтарсан шийдвэрээр хөтөлбөрөө баталжээ. 62 орон нь хөтөлбөрөө салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулсан агуулгатай буюу боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, хууль сахиулах салбарын үйл ажиллагааг уг хөтөлбөрөөр уялдуулан зохицуулсан байх бөгөөд 44 оронд нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн зохион байгуулах чиг үүрэгтэй байна.

Түүнчлэн **Австрали Улсад** 1989 оноос “Согтууруулах ундааны хэрэглээний талаар баримтлах үндэсний эрүүл мэндийн бодлого”, 1995 оноос “Согтууруулах ундаатай холбоотой арга хэмжээний үндэсний хөтөлбөр”, 1998 оноос “Донтохтой тэмцэх үндэсний стратеги хөтөлбөр”, 2003 оноос “Согтууруулах ундааны үндэсний стратеги хөтөлбөр”-үүдийг тус тус баталж, хэрэгжүүлсэн байна.

Архи, согтууруулах ундааг олж авч болох боломж, олдоцыг бууруулах талаар төрөл бүрийн аргыг дэлхийн улс орнууд хэрэглэж байгаа бөгөөд хамгийн түгээмэл нь архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг газрын тоог газар зүйн байршил болон хүн амын нягтаршилаас хамааран

¹⁹ Addressing the harmful use of alcohol. A guide to developing effective alcohol legislation. 2011. World Health Organization. Western Pacific Region.

тодорхой стандарттай байхаар зохицуулах, тэдгээрийн үйл ажиллагаа явуулах өдөр, цагийн хуваарийг хязгаарлах болон архи, согтууруулах ундааны зүйлийг худалдаж авч болох болон хэрэглэж болох насны хязгаар тогтоох зэрэг байна.

Жишээлбэл, **Перу** Улсын Ла Викториа ин Лима хотын нэг дүүргийн захиргаа 2007 оны 1 дүгээр сард, Ням гарагаас Лхагва гарагын шөнө дунд хүртэл болон Пүрэв гарагаас Ням гарагын өглөөний 3 цаг хүртэл архи, согтууруулах ундааны зүйлийг худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон шийдвэр гаргасан байна. Хоёр жилийн дараа тухайн дүүргийг согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээг хязгаарлаагүй бусад дүүргүүдтэй харьцуулан судлахад хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн тоо бараг хоёр дахин багассан байсан бөгөөд энэ нь тухайн дүүргүүдэд мөрдөгдөж байгаа архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах цагийн зохицуулалттай шууд хамааралтай байсан байна. 2011 оны 12 дугаар сард Ла Викториа ин Лима хотын Төв дүүрэгт мөн дээрхтэй ижил хориглолт, хязгаарлалтыг тогтоож, үүний хажуугаар цагдаагийн байгууллагын зүгээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилтэй хийх тэмцэлээ идэвхижүүлсэн байна. Жилийн дараа хийсэн судалгаанаас харахад тухайн дүүрэгт хүчирхийллийн улмаас амь насаа алдах явдал 11 хувиар, хүнийг алах гэмт хэргийн тоо 19 хувиар, согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас хохирсон хүний тоо 28 хувиар тус тус буурсан байна.

Литва улс 1995 онд “Согтууруулах ундааны хяналтын тухай” хуулиа 2004 онд шинэчлэн баталж, тус хуулийн дагуу согтууруулах ундааны хэрэглээтэй тэмцэх чиглэлээр дараахь зарчмуудыг тусгажээ:²⁰

- Татварын нөлөө, хөшүүргийг ашиглан согтууруулах ундааны үнийг өсгөх замаар олдоцыг бууруулах;
- Насанд хүрээгүйчүүдэд зориулсан боловсролын хөтөлбөрийг ашиглах;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэлд байгалийн буюу органик бүтээгдэхүүн ашиглах зарчмыг баримтлах;
- Согтууруулах ундааны худалдаа, хэрэглээг хязгаарлах;
- Залуу үеийн, өсвөр насныханд чиглэсэн согтууруулах ундааны маркетингийн үйл ажиллагааг хориглох;
- Согтууруулах ундааны хэрэглээнээс үүдэн эрүүл мэндэд учирч болзошгүй хор хөнөөл, тэдгээртэй холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих зэрэг байна.

Өмнөд Африк Улсад шинээр үүсгэн байгуулагдсан Хороо нь согтууруулах ундааны маркетингийн үйл ажиллагаанд судалгаа хийсний үндсэн дээр Эрүүл мэндийн яамандаа согтууруулах ундааны зар сурталчилгаа болон түүнтэй холбоотой ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг этгээдүүдээс аливаа арга хэмжээ, үйл ажиллагааг ивээн тэтгэх зэрэг үйлдлийг хориглосон хуулийг боловсруулж батлуулах чиглэл өгсний дагуу хуулийн төсөл боловсруулагдаж батлагдсан байна.

Архи, согтууруулах ундааг сурталчлахыг хориглосон зохицуулалт нь бүх төрлийн сурталчилгааг бүрмөсөн хориглохоос эхлэн согтууруулах ундааны төрөл болон сурталчлах арга хэлбэрээс хамааран харилцан адилгүй улс орнуудын хууль тогтоомжид туссан байна. 2012 онд 159 улс орон бүх төрлийн согтууруулах ундааг бүх төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлахыг хориглосон зохицуулалттай тухай мэдээлсэн байна.

Турк Улсад сүүлийн жилүүдэд хатуулаг өндөртэй согтууруулах ундааг үйлдвэрлэх монополь эрхийг Засгийн газар эдэлж байна. Турк улсад согтууруулах ундааг үйлдвэрлэх болон түүний эргэлтийг 1942 онд батлагдсан “Спирт болон спирт агуулсан бүтээгдэхүүний тухай” хуулиар зохицуулдаг. Энэхүү хуулийн дагуу согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдааг “ТЕКЕЛЬ” нэртэй төрийн байгууллага гүйцэтгэдэг бөгөөд зөвхөн бусад иргэд, байгууллагад Турк Улсад үйлдвэрлэгддэггүй согтууруулах ундааны зүйлийг энэхүү байгууллагын зөвшөөрөлтэйгээр гадаад улсаас импортлохыг зөвшөөрдөг байна.

2013 оноос эхлэн Турк улсад 22 цагаас 6 цаг хүртэл хугацаанд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах болон бусад хязгаарлалт, хориглолтыг бий болгосон шинэ хууль үйлчилж

²⁰ Regulations of Alcohol Marketing in 24 European Countries, National Foundation for Alcohol Prevention.

эхэлсэн байна. Тэрхүү хууль нь олон нийтийн зүгээс багагүй хэмжээний эсэргүүцэлтэй тулгарсан бөгөөд энэхүү хуулиар боловсролын байгууллагууд болон оюутан сурагчдын дотуур байрнаас 100 метрээс дотогш зайнд согтууруулах ундаагаар үйлчлэх болон худалдаалахыг мөн хориглосон байна. Түүнчлэн согтууруулах ундааг нийтийн хоолны газар, шатахуун түгээс газар, цэнгэлдэх хүрээлэн, спортын байгууламжууд, номын сан, мах махан бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг газруудад согтууруулах ундаа худалдаалахыг хоригложээ. Харин эдгээр хязгаарлалтыг аялал жуулчлалын байгууламжуудад үйлчлэхгүй байхаар зохицуулсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний дийлэнх хувийг бүрдүүлдэг аялал жуулчлалын салбарт сөрөг нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлжээ.

Дээрхийн зэрэгцээгээр согтууруулах ундааг олон нийтийн газар, парк, ногоон байгууламжууд, иргэдийн амралтаа өнгөрүүлэх газар болон далайн эрэг-наран шарлагын газруудад хэрэглэхийг хориглосон хэдий ч тусгай зөвшөөрөл бүхий бар, кафе зэрэг газруудад цагийн хязгааргүйгээр согтууруулах ундаа худалдаалахыг зөвшөөрсөн байдаг байна. Хэдийгээр бар, кафе зэрэгт согтууруулах ундааг худалдаалахыг зөвшөөрсөн хэдий ч тэдгээрт согтууруулах ундааг хүний нүдэнд ил харагдахаар өрж тавих, ил тодоор сурталчлахыг хориглосон бөгөөд бүх төрлийн согтууруулах ундааны хаяг, шошго дээр согтууруулах ундааны хор хөнөөлийн талаархи сэрэмжлүүлэг, анхааруулгыг байршуулах шаардлагыг нэмжээ. Мөн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр бүхий л төрлийн согтууруулах ундааг ил болон далд хэлбэрээр сурталчлахыг хориглож, радио телевизээр нэвтрүүлж байгаа дүрснээс согтууруулах ундаа хэрэглэж байгаа хэсгийг хасаж нэвтрүүлэх шаардлагыг бий болгосон байна. Түүнчлэн согтууруулах ундааны хэрэглээг дэмжсэн маркетингийн бүхий л үйл ажиллагааг мөн хоригложээ.

Үүнээс гадна замын хөдөлгөөний тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулан хэрэв жолоочийн цусанд 1,0 ВАС –с илүү хэмжээний алкоголь илэрсэн тохиолдолд 2 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах ял шийтгэхээр тусгасан бөгөөд бусад тохиолдолд жолоочийн цусанд согтууруулах ундаа ямар нэгэн хэмжээгээр илэрсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал болохоор хуульд тусгажээ. Түүнчлэн согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхээ шалгуулахаас зайлсхийсэн тохиолдолд 1000 ам доллартэй тэнцэхүйц хэмжээний мөнгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 2 жилийн хугацаагаар хасах шийтгэл оногдуулахаар тусгажээ.

Дээрхи авсан арга хэмжээнүүд болон согтууруулах ундааны эсрэг төрийн бодлогын үр дүнд согтууруулах ундааны хэрэглээг 15 хувиар багасгаж, хууль бус согтууруулах ундааны зах зээлийн хэмжээг 2 дахин багасгасан тухай мэдээлэл гарсан байна.

Иран Улсын хувьд 1979 онд Исламын хувьсгал ялснаас хойш лалын шаны шариатын дүрмийн дагуу “хуурай хууль” үйлчилж байгаа хэдий ч согтууруулах ундааны хар зах зээл байгаа гэдгийг үгүйсгэдэггүй байна.

Тус улсад согтууруулах ундаа үйлдвэрлэсэн, худалдаалсан, хэрэглэсэн тохиолдолд торгох, эсхүл эрх чөлөөг нь хязгаарлах хүртэл шийтгэл оногдуулдаг бөгөөд зөвхөн христийн шашинтай болон армян үндэстнүүдийн амьдардаг бүс нутгуудад хуульд заасан хязгаарлалттайгаар согтууруулах ундааг үйлдвэрлэхийг зөвшөөрсөн байдаг байна.

2008 онд Иран Улсын парламент согтууруулах ундааны хууль бус эргэлтэд хүлээлгэх хариуцлагыг чангатгаж хууль бусаар согтууруулах ундаа үйлдвэрлэсэн, худалдаалсан, хэрэглэсэн тохиолдолд 1 жилээс 6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх, 74 удаа ташуурдах болон согтууруулах ундааны үнийг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох шийтгэл оногдуулна гэж заажээ. Хэрвээ хууль бусаар үйлдвэрлэсэн, худалдаалсан, эсхүл хэрэглэсэн согтууруулах ундааны хэмжээ 20 литрээс их тохиолдолд түүнийг тээвэрлэж байсан тээврийн хэрэгслийг хурааж, улсын орлого болгохоор заасан байна.

Хэдийгээр дээр дурдсанчлан маш хатуу чанга хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн ч согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдсээр байгаа бөгөөд зөвхөн 2012 онд гэхэд хураагдсан согтууруулах ундааны хэмжээ 69 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн жил бүр 80 хүртэлх сая тонн согтууруулах ундаа хууль бусаар Иран улсруу нэвтрэдэг бөгөөд үүний зөвхөн 30 хувийг нь л илрүүлж, хураан авч чаддаг байна. Мөн гар аргаар гэрийн нөхцөлд үйлдвэрлэсэн согтууруулах ундаа болон армян, франц дарс хууль бус эргэлтэд ихээр байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд хар зах буюу хууль

бус зах зээлээс худалдан авсан согтууруулах ундааны хэрэглээний улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирсон иргэдийн тоо өсөж байгаа гэсэн мэдээлэл байна.

Сүүлийн жилүүдэд **Азербайджан** Улсын зах зээл дээр хууль бус согтууруулах ундааны эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэ нь чанаргүй согтууруулах ундааны хэрэглээний улмаас хордох, эрүүл мэндээрээ хохирох явдал нэмэгдэж байгаагаар нотлогдож байна.

2005 оноос эхлэн Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу согтууруулах ундааг үйлдвэрлэх, импортлох болон худалдаалах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэлдэг болсон бөгөөд энэхүү зөвшөөрлийг тус улсын хөдөө аж ахуйн яам хариуцан олгодог байна. Тус улсын хууль тогтоомжид согтууруулах ундааг худалдан борлуулахад тодорхой хязгаарлалт тогтоосон зохицуулалтууд байдаг боловч хэрэгжилтийн байдал нь хангалтгүй байсаар байна. Тухайлбал, хуульд зааснаар согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг цэгүүд нь боловсролын байгууллагуудаас тодорхой хэмжээний зайтай байх гэх мэт шаардлагуудыг тавьдаг байна.

Гүрж улсын хувьд сүүлийн үед согтууруулах ундааны хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр эрчимтэй арга хэмжээ авч байгаа бөгөөд энэ төрлийн хууль бус үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай нэмэлт, өөрчлөлтүүдийг эрүүгийн хууль тогтоомждоо тусгасан байна.

ГУРАВ. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС²¹

АНУ-ын хувьд Холбооны, Муж улсын болон муж улсын доторхи засаг захиргааны нэгжүүдээс гаргасан хууль, эрх зүйн актууд нь нийтдээ АНУ дахь архи, согтууруулах ундааны зүйлийн эргэлт, хэрэглээг зохицуулж байдаг нэгдсэн бодлогыг бий болгодог. Уг бодлого нь:

- Архи, согтууруулах ундааг үйлдвэрлэх;
- Архи, согтууруулах ундааг худалдах;
- Архи, согтууруулах ундааг хэрэглэх буюу уух эрх бүхий этгээдийг тогтоох;
- Архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй, түүнтэй хамааралтай сөрөг үр дагаварт хариу үзүүлэх гэсэн үндсэн 4 төрлийн багц асуудлыг хамаардаг байна.

Холбооны түвшинд архи, согтууруулах ундааны зүйлийн талаархи гол зохицуулалт нь АНУ-ын Үндсэн хуулийн 21 дэх нэмэлт, өөрчлөлт юм. Энхүү нэмэлт, өөрчлөлт нь 1933 оны 12 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан бөгөөд улс даяар архи, согтууруулах ундааны зүйлийг хориглосон агуулгатай 1919 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр батлагдсан АНУ-ын Үндсэн хуулийн 19 дэх нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосон. Энэ нэмэлт, өөрчлөлт нь АНУ-ын түүхэнд Үндсэн хуульд орсон 27 нэмэлт, өөрчлөлтийн дундаас ганцаараа урьд өмнө Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосон юм. Түүнчлэн уг нэмэлт, өөрчлөлт нь архи, согтууруулах ундааны бодлогыг муж улсын засгийн газарт буюу эрх барих байгууллагад:

- Тухайн муж улсын нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундааны зүйлийг худалдах эсэх;
- Тухайн муж улсын нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундааны зүйлийг оруулах, импортлох эсэх;
- Тухайн муж улсын дэвсгэрт архи, согтууруулах ундааны зүйлийг хэрхэн эргэлтэд оруулах;
- Тухайн муж улсын нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундааны зүйлийг эзэмших асуудлыг шийдвэрлэх эрхийг олгосон байна.

Дээрхи эрхийн хүрээнд зарим муж улсууд түүний доторхи засаг захиргааны нэгжүүдэд тус тусын нутаг дэвсгэр дээрхи зохицуулалтыг бий болгох эрхийг олгосон байдаг хэдий ч зарим нь энэхүү эрхийг гагцхүү муж улсын засгийн газар буюу эрх барих дээд байгууллагад хадгалан хэрэгжүүлдэг байна.

²¹ A project of the National Institute on Alcohol Abuse and Alcoholism, Alcohol Policy Information System, <https://alcoholpolicy.niaaa.nih.gov/>

АНУ-ын нутаг дэвсгэрт дээр дурдсанчлан муж улсууд тус бүрт нь тодорхой зохицуулалтыг бий болгох, түүнийгээ хэрэгжүүлэх нь муж тус бүрээс хамааран уян хатан зохицуулалттай боловч АНУ-ын Конгресс буюу хууль тогтоох дээд байгууллага нь санхүүгийн болон татварын арга хэрэгсэл ашиглан муж улсуудын архи, согтууруулах ундааны талаархи зарим бодлогод нөлөөлөх эрхтэй байх ба тэдгээрийн нэг нь архи, согтууруулах ундааг хэрэглэх, биедээ авч явж болох насны доод хязгаарыг тогтоох юм. 1984 оны Холбооны улсын хуулиар архи, согтууруулах ундаа хэрэглэж болох насны доод хязгаарыг муж бүрт адил буюу 21 нас байхаар тогтоосон бөгөөд өдгөө бүх муж уг стандартыг дагаж мөрдөж байна.

Дээр дурдсан хуулийн дагуу хэрвээ муж улсууд уг хуулиар тогтоосон 21 нас хүрээгүй хүн бүх төрлийн архи, согтууруулах ундааг худалдан авах, эзэмшихийг хориглосон нийтлэг стандартыг дагаж мөрдөөгүй тохиолдолд Холбооны төсвөөс тухайн муж улсын хурдны замд зориулах санхүүжилтийн 10 хувийг хасах эрхийн Холбооны засгийн газарт олгосон байна. Бүх муж улсуудын хувьд энэхүү стандартыг дагаж мөрдөж байгаа хэдий ч зарим муж улсууд нийтлэг стандартад хамаарахгүй тохиолдлуудыг тусгайлан зохицуулсан байдаг.

2015 онд хийсэн судалгаагаар АНУ-ын 18 буюу түүнээс дээш насны иргэдийн 86.4 хувь нь бүхий л амьдралынхаа туршид, 70.1 хувь нь сүүлийн нэг жилд, 56.0 хувь нь сүүлийн нэг сарын хугацаанд архи, согтууруулах ундааны зүйлийг хэрэглэсэн гэсэн байна. Түүнчлэн 26.9 хувь нь сүүлийн нэг сарын хугацаанд архи, согтууруулах ундааг тогтмол хэрэглэсэн, 7.0 хувь нь хэтрүүлэн хэрэглэсэн гэжээ.

Дээр дурдсан судалгаагаар АНУ-ын 18 буюу түүнээс дээш насны иргэдийн 6.2 хувь буюу 15.1 сая хүн нь архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх зуршилтай бөгөөд үүнээс 6.7 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэгэн хэлбэрийн эмчилгээнд хамрагдсан гэжээ. Мөн судалгаагаар 12-17 насны нийт иргэдийн 2.5 хувь буюу 623 000 нь архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх зуршилтай бөгөөд үүнээс 5.2 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэгэн эмчилгээнд хамрагдсан байна.²²

Дээрхи судалгааны үр дүнгээс харахад нийт 15 настай иргэдийн 33.1 хувь нь амьдралдаа нэг ч болтугай удаа архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэж байсан, 12-20 нас 7.7 сая иргэд буюу 20.3 хувь нь сүүлийн нэг сарын хугацаанд архи, согтууруулах ундааг хэрэглэсэн гэж мэдээлсэн байна.

АНУ-д архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй үхлийн тоо жил бүр ойролцоогоор 88 000 /62 000 нь эрэгтэй, 26 000 нь эмэгтэй/ байгаа нь АНУ дахь үхлийн 3 дахь том шалтгаан болж байна /1-рт тамхи, 2-рт хоолны чанар, хөдөлгөөний дутагдал/.

3.1.НАСНЫ ХЯЗГААР²³

АНУ-д жил бүр 21-ээс доош насны 5000 хүн архи, согтууруулах ундааны хэрэглээнээс шалтгаалан нас бардаг. ²⁴ Хуульд заасан насанд хүрээгүй хүмүүсийн архи, согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлах, тэдгээрт архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглох тухай зохицуулалт муж улсуудын хууль тогтоомжид 20 дугаар зууны эхэн үеээс эхлэн бий болж эхэлсэн бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хирээр уг зохицуулалт илүү нарийвчилсан, илүү чанга болсоор иржээ. Анхлан АНУ-ын Үндсэн хуулийн 18 дахь нэмэлт, өөрчлөлтөөр АНУ-ын нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундааны зүйлийг хориглосон бөгөөд 1933 онд уг нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосонтой зэрэгцэн 21 насанд хүрээгүй хүнд архи, согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон эрх зүйн зохицуулалт нь муж улсуудын хувьд энгийн жишиг болсон байна.

1970-1975 оны хооронд 29 муж улс архи согтууруулах ундааг хэрэглэж болох насны доод хязгаарыг 21 байсныг 18, 19, эсхүл 20 болгон өөрчилсөн бөгөөд 1980-д оны үеээр дахин 21 нас болгож өөрчилсөн байна. Энэ нь тухайн үед насанд хүрээгүй хүмүүсийн архи, согтууруулах ундааны

²² <https://www.niaaa.nih.gov/alcohol-health/overview-alcohol-consumption/alcohol-facts-and-statistics>

²³ Underage drinking,

[https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Underage Possession Consumption Internal Possession of Alcohol.html](https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Underage%20Possession%20Consumption%20Internal%20Possession%20of%20Alcohol.html)

²⁴ <https://alcoholpolicy.niaaa.nih.gov/UnderageDrinking.html>

хэрэглээний талаархи олон нийтийн болгоомжлол болон архи, согтууруулах ундаа хэрэглэх насыг доошлуулснаар автотээврийн ослын тоо нэмэгдсэнтэй холбоотой байсан гэж үздэг.

1984 онд Конгрессоос муж улсууд архи согтууруулах ундааг хэрэглэх, худалдан авах болон олон нийтийн газарт биедээ авч явж болох насны доод хязгаарыг 21 наснаас доогуур тогтоосон тохиолдолд муж улсуудад олгох хурдны замын нөхөн олговроос хасах тухай хууль гарснаар 1988 он гэхэд бүх муж улсууд архи, согтууруулах ундааг 21 нас хүрээгүй этгээдэд хэрэглэхийг хориглосон хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар бүх муж улсууд 21 нас хүрээгүй хүнд архи, согтууруулах ундааны зүйлийг эзэмшихийг хориглосон бөгөөд дийлэнхи муж улсууд 21 нас хүрээгүй хүн архи, согтууруулах ундааны зүйлийг худалдан авах, хэрэглэхийг хориглосон байна. Үүгээр зогсохгүй, дийлэнхи мужууд насанд хүрсэн хүнийг архи согтууруулах ундааг насанд хүрээгүй хүнд шилжүүлэх, түүнийг хэрэглэх боломжоор хангахыг хориглосон бөгөөд энэхүү хориглолт нь муж улсуудаас шалтгаалан зарим онцлог зохицуулалтуудтай байдаг байна.

3.1.1.Биедээ авч явах/Хэрэглэх

Холбооны хууль тогтоомж 21 насанд хүрээгүй иргэн согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хатуу хориглосон хэдий ч уг хуулийг тайлбарласан эрх зүйн бусад актуудад зааснаар “олон нийтийн газарт биедээ авч явах” гэдэгт тогтсон ёс заншлын улмаас биедээ авч явах; эцэг эх, 21 насанд хүрсэн эхнэр, нөхөр, хууль ёсны хамгаалагчийн хамт явах үедээ; эмчийн жорын дагуу эмчилгээний зорилгоор хэрэглэх тохиолдолд; хувийн клуб болон хувийн эзэмшил газарт; хууль ёсны дагуу байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу ажил үүргийн хуваарийн хүрээнд биедээ авч явах зэрэг хамаарахгүй байхаар хуульчилсан байна.²⁵

Сүүлийн жилүүдэд зарим муж улсад “internal possession” буюу насанд хүрээгүй этгээд зөвхөн олон нийтийн газарт архи согтууруулах ундааны зүйлийг биедээ авч явахаар хязгаарлагдахгүйгээр, тэдгээрийн цусанд ямар нэгэн хэмжээгээр согтууруулах ундааны зүйл агуулагдаж байгаа эсэхэд үндэслэн тодорхой арга хэмжээг авч байгаа бөгөөд энэхүү хязгаарлалтын давуу тал нь 21 насанд хүрээгүй хүнийг согтууруулах ундааны зүйл эзэмшиж байсан, биедээ авч явсныг заавал тогтоох шаардлагагүй бөгөөд зөвхөн цус, шээсэнд нь илэрсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх хангалттай үндэслэл болох юм. Өөрөөр хэлбэл, энэ нь хууль сахиулах байгууллагын ажилтнууд насанд хүрээгүй хүмүүс оролцсон, эсхүл тэдгээрийн зохион байгуулж байгаа согтууруулах ундааг ихээр хэрэглэдэг үдэшлэг, нийтийг хамарсан цугларалтын үед насанд хүрээгүй этгээдийг согтууруулах ундааг заавал “барьсан” эсхүл “уусан” байхыг баримтжуулах, нотлох шаардлагагүй бөгөөд зөвхөн цус, эсхүл шээсэнд нь согтууруулах ундаа илэрсэн байх нь хангалттай юм. Энэ төрлийн зохицуулалт одоогийн байдлаар АНУ-ын 9 муж улсад хүчин төгөлдөр үйлчилж байна.

Зарим мужийн хувьд дээр дурдсанчлан хуульд заасан насанд хүрээгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан байхад зарим мужийн хувьд ямар нэгэн хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалт байхгүй байна. Түүнчлэн зарим муж улсууд нь хуульд зааснаар 21 насанд хүрээгүй этгээд 21 насанд хүрсэн гэр бүлийн гишүүний зөвшөөрлөөр, эсхүл тэдгээрийн дэргэд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, биедээ авч явсан тохиолдолд хууль зөрчсөн гэж үзэх ч зохицуулалттай байна. Энэхүү байдлаар тусгайлсан зохицуулалтыг муж улсууд харилцан адилгүй олон хэлбэрээр тогтоосон бөгөөд үүний дотор гэр бүлийн яг ямар гишүүн зөвшөөрөл олгосон байх, эсхүл дэргэд нь байх шаардлагатай болон “гэр бүл”, эсхүл “гэр бүлийн гишүүн” гэх зэргээр харилцан адилгүй байна.

Тухайлбал, 21 насанд хүрээгүй хүн 27 муж улсад “Гэр бүлийн гишүүн”, эсхүл “Гэр бүл”-ийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэж болох, 21 мужид “хувийн эзэмшил, гэр орондоо” согтууруулах ундаа хэрэглэж болох ба 16 муж улсад 21 нас хүрээгүй л бол бүх төрлийн хэрэглээ хориотой байна.

²⁵ https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Minimum_Ages_for_Off-Premises_Sellers.html?tab=maps&date=1%2f1%2f2003&dateStart=1%2f1%2f2003&dateEnd=1%2f1%2f2016&onlyChanges=True

“Олон нийтийн газарт биедээ авч явах” гэдгийг мөн холбооны хуулиар тодорхойлсон байх бөгөөд хуульд зааснаар энэ нь согтууруулах ундааны бүхий л төрлийг ямар ч шалтгаан, зорилгоор олон нийтийн газар, гудамж талбай, хурдны зам, эсхүл нийтэд ил тод бүхий л төрлийн газарт биедээ авч явах, хэрэглэхийг ойлгохоор заасан байна.

Дээр дурдсан зохицуулалтуудтай зэрэгцүүлэн муж улсууд насанд хүрээгүй хүнийг архи, согтууруулах ундааны аюулаас сэргийлэх зорилгоор төрөл бүрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг. Эдгээр бодлогын зарим нь насанд хүрээгүй этгээдүүдэд шууд үйлчлэх агуулгатай бөгөөд тухайлбал, архи, согтууруулах ундаа авах зорилгоор хуурамч бичиг баримт ашиглах, архи, согтууруулах ундаатай холбогдолтой зөрчил гарагсан тохиолдолд авто тээврийн хэрэглэх жолоодох эрхээ хасуулах, 21 насанд хүрээгүй этгээдүүдийн хувьд цусан дахь спиртын хэмжээ ердийн хэмжээнээс бага байхыг шаардах зэрэг юм. Түүнчлэн архи, согтууруулах ундааг борлуулж байгаа этгээд, түүгээр үйлчлэх этгээдийн хувьд насны хязгаарыг бий болгох, насанд хүрээгүй этгээдүүдийг архи, согтууруулах ундаа хэрэглэх боломжоор хангасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэг байна. Зарим мужуудад 21 насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундаагаар үйлчлэх, эсхүл тэдгээрийг худалдах газарт ажиллахыг хориглох, түүнчлэн архи согтууруулах ундааны төрлөөс хамааран уг насыг харилцан адилгүй тогтоох зэрэг хязгаарлалт хийх боломжтой байна.

3.1.2. Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах насны хязгаар²⁶

Муж улсууд согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллах насны доод хязгаарыг өөрийн хууль тогтоомжоор зохицуулсан байдаг бөгөөд энэхүү хязгаарлалт нь зөөгч, бармен /бартендер/, үйлчлэгч, худалдагч зэрэг ажлын байранд нийтэд нь хамаардаг байна.

Жишээлбэл, 2016 оны 1 дүгээр сарын байдлаар АНУ-ын 3 мужид шар айргаар үйлчилж байгаа газарт /бар, ресторан/ ажиллах үйлчлэгчийн насны хязгаарыг 21 нас байхаар, 9 мужид 19-20 нас байхаар заасан байна.²⁷ Тэгвэл, уг газрууд дахь бармен буюу бартендерийн хувьд 18 мужид 21 нас, 5 муж улсад 19-20 нас байх бөгөөд АНУ-ын мужуудын архи, согтууруулах ундааны төрлөөс хамааран тэдгээрээр үйлчлэх эрх үүсэх насны байдлыг харахад Невада, Юта, Аляска гэх 3 муж улсад бүх төрлийн согтууруулах ундаагаар үйлчлэх насны доод хязгаар 21 нас байна.

Харин согтууруулах ундаа худалдах үйл ажиллагаа явуулдаг газруудад /дэлгүүр/ ажиллаж болох насны доод хязгаарын хувьд АНУ-ын 10 мужид 21 нас, 3 мужид 19-20 нас, 19 мужид 18 нас гэж тогтоосон байх бөгөөд 10 муж улс нь бүх төрлийн согтууруулах ундааг худалдахад 21 настай байх шаардлагыг тавьдаг байна. Зарим тохиолдолд буюу АНУ-ын 13 мужид хэдий 21 нас хүрээгүй ч тухайн газрын менежер, эсхүл түүнийг шууд удирдах этгээд нь дэргэд нь байх шаардлагыг тавьдаг байна.

3.1.3. Худалдан авах

Дийлэнхи муж улсуудын хувьд 21 насанд хүрээгүй хүнийг согтууруулах ундааны зүйл худалдан авах, худалдан авах аливаа оролдлого хийхийг хориглодог. АНУ-ын талаархи материалиас харж байхад худалдан авах дээрхи хориглолтыг зөрчсөн тохиолдолд тухайн муж улсад согтууруулах ундааг хууль бусаар эзэмшсэн үйлдэлд нь мөн давхар хариуцлага хүлээлгэдэг бөгөөд энэ нь худалдан авах болон худалдан авсны дараа эзэмших үйлдэл нь хоорондоо салшгүй холбоотой ба ингэснээр согтууруулах ундаа хууль бусаар худалдан авсан насанд хүрээгүй хүн худалдан авсан болон эзэмшсэн үйлдэлдээ давхар хариуцлага хүлээлэхээр байна.

Зарим муж улсын хувьд хуулиндаа 21 насанд хүрээгүй хүн хууль сахиулах нууц ажиллагаа буюу хуулийн хэрэгжилтийг хянах зорилгоор хууль сахиулах байгууллагаас зохион байгуулж байгаа хяналтын худалдан авалтын үед дээрхи насанд хүрээгүй этгээд согтууруулах ундааны зүйл

²⁶

https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Underage_Purchase_of_Alcohol.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True

²⁷ https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Minimum_Ages_for_On-Premises_Servers_and_Bartenders.html?tab=maps

худалдан авч болох тухай хуулийн зохицуулалттай байх бөгөөд энэхүү хуулийн зохицуулалт нь согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаанд шалгалт хийх үед ихэвчлэн хэрэглэгддэг байна.

2016 оны 1 дүгээр сарын байдлаар 4 –өөс бусад бүх муж улсууд 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдаж авахыг хориглосон ба 23 муж улс 21 насанд хүрээгүй хүнийг хууль сахиулах ажиллагааны үед согтууруулах ундаа худалдан авч болох тухай зохицуулалттай байна.

3.1.4.Согтууруулах ундаагаар үйлчлэх²⁸

АНУ-ын бүх муж улсууд 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдах, түүгээр үйлчлэхийг хориглодог бөгөөд тэдгээрээс зарим нь уг хориглолтод хамаарахгүй харилцан адилгүй тохиолдлуудыг өөрийн хууль тогтоомждоо тусгасан байдаг байна. Эдгээр тусгайлан үзэх нөхцөл байдлуудаас авч үзвэл, тухайлбал, хэрвээ 21 насанд хүрээгүй хүнд түүний эцэг, эх, эхнэр, нөхөр, хууль ёсны төлөөлөгч нь архи, согтууруулах ундааг өгсөн бол хууль зөрчсөн гэж үздэггүй байна. Зарим муж улсууд эцэг, эх, эхнэр, нөхөр, хууль ёсны төлөөлөгч нь өөрөө согтууруулах ундаа хэрэглэх хууль ёсны насанд хүрсэн байх ёстой байхыг гол нөхцөл болгон шаарддаг бол зарим нь энэ талаар ямар нэгэн тодорхой шаардлага тавьдаггүй байна. Харин 21 насанд хүрээгүй хүнд архи, согтууруулах ундаагаар үйлчилсэн, хэрэглүүлсэн үйлдэл нь бүхий л муж улсуудын хувьд тэдгээр үйлдэл нь хувийн эзэмшлийн газар дээр болсон эсэхээс үл хамааран хориотой байна.

2016 оны байдлаар 31 муж улс “гэр бүл” –ийн хүрээнд согтууруулах ундаагаар үйлчлэх буюу хэрэглүүлэхийг хориглоогүй бөгөөд 20 муж улс нь ямар нэгэн тусгайлсан зохицуулалтгүй байна.

Түүнчлэн бүхий л муж улсууд 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаагаар үйлчилсэн, эсхүл хэрэглүүлсэн этгээд нь ашгийн төлөө, эсхүл ашгийн төлөө бус эсэхээс үл хамааран хуулиар хориглосон байх бөгөөд өөрийн эзэмшил, өмчлөлд 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа хэрэглэх боломжийг олгосон /хэрэглэх орон байраар хангасан/, эсхүл хэрэглэх согтууруулах ундаагаар хангахыг мөн л бүх муж улсууд хориглодог байна.²⁹

3.1.5.Use/Lose: Driving Privileges³⁰

Зарим муж улсын хувьд хуулиар зөвшөөрсөн 21 насанд хүрээгүй үедээ хууль бусаар согтууруулах ундаа худалдан авсан, эзэмшсэн, биедээ авч явсан, хэрэглэсэн бол хариуцлагын нэг хэлбэр болгож авто тээврийн хэрэгсэл жолоодох давуу эрхийг нь түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох арга хэмжээ авдаг байна.

Энэхүү хариуцлагын арга хэмжээ нь 1980-д оны дунд үеээс эхлэн хөгжсөн бөгөөд 21 насанд хүрээгүй хүний хувьд хүмүүжлийн болон урьдчилан сэргийлэх өндөр ач холбогдолтой арга хэмжээ болж чадсан байна. Шийтгэлийн гол агуулга нь авто тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг тодорхой хугацаагаар хасах, эсхүл жолоодох эрхийн үнэмлэхийг нь хүчингүй болгож тодорхой хугацааны дараа дахин шалгалт авч жолоодох эрхийг нь сэргээх эсэхийг шийдвэрлэхэд оршдог байна.

2016 оны байдлаар 31 муж улсад энэ төрлийн шийтгэл нь заавал оногдуулах шийтгэл бол, 10 муж улсад шүүгч буюу шийтгэл оногдуулах эрхтэй этгээд сонгож хэрэглэхээр зохицуулалттай бөгөөд 12 муж улсад энэ төрлийн шийтгэл байхгүй байна.

28

[https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Furnishing Alcohol to Minors.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True](https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Furnishing_Alcohol_to_Minors.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True)

²⁹ Alcohol Policy, National Institute on Alcohol Abuse and Alcoholism, <https://www.niaaa.nih.gov/alcohol-health/alcohol-policy>

30

https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Loss_of_Driving_Privileges_for_Alcohol_Violations_by_Minors_Use_Lose_Law_s.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True

3.1.6.Хуурамч бичиг баримт ашиглах³¹

Согтууруулах ундаагаар үйлчлэх болон худалдах эрх бүхий этгээд нь зөвхөн согтууруулах ундааг худалдан авахыг нь хуулиар хориглоогүй этгээдэд үйлчлэх үүрэгтэй бөгөөд худалдан авагчийн хууль ёсны бичиг баримтыг шалгах нь уг үүргээ зохих ёсоор биелүүлэх чухал механизм юм. Энэхүү механизмыг тойрон гарахын тулд насанд хүрээгүй этгээд хуурамч бичиг баримт ашиглан согтууруулах ундаа худалдан авахыг завддаг байна.

Бүх муж улсууд согтууруулах ундаа авах зорилгоор хуурамч бичиг баримт ашиглахыг хориглодог бөгөөд энэхүү хориглосон зохицуулалтыг:

- Хуурамч бичиг баримт ашиглах согтууруулах ундаа худалдан авч байгаа этгээдийн эсрэг чиглэсэн;
- Насанд хүрээгүй этгээдэд хуурамч бичиг баримт бэлтгэн өгч байгаа, нийлүүлж байгаа, өөрийн бичиг баримтыг ашиглуулж байгаа этгээдийн эсрэг чиглэсэн;
- Насанд хүрээгүй этгээдэд согтууруулах ундаа худалдан борлуулж байгаа этгээдэд тусалж байгаа этгээдийн эсрэг чиглэсэн гэж үндсэн 3 хэсэгт хуваадаг байна.

2016 оны байдлаар АНУ-ын 4 муж улсад захиргааны журмаар уг төрлийн зөрчилд шийтгэл оногдуулдаг бол 35 мужид шүүхийн журмаар шийтгэлийг оногдуулдаг байна. Түүнчлэн 11 муж улсад согтууруулах ундаа худалдан авах этгээдийн бичиг баримтыг сканердаж авах зохицуулалттай бөгөөд бусад мужийн хувьд энэ төрлийн зохицуулалт байхгүй байна.

3.2.СОГТУУРУУЛАХ УНДААГ ХУДАЛДААЛАХ ҮНЭ³²

3.2.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх үнэ

Согтууруулах ундааны хэрэглээг багасгах зорилгоор АНУ-ын муж улсууд согтууруулах ундаагаар үйлчлэх болон худалдаалах эрх бүхий газар, этгээдүүдийн худалдааны үйл ажиллагаанд тодорхой хэмжээний хязгаарлалт, хориглолтыг тавьдаг бөгөөд энэ нь ерөнхий байдлаараа аж ахуй эрхлэгч нарын архи, согтууруулах ундааны зүйлд төрөл бүрийн хямдрал, урамшуулал зарлах, үнэгүй согтууруулах ундааны зүйлээр үйлчлэх гэх мэт үйл ажиллагааг хориглодог байна.

Тухайлбал, эдгээр хязгаарлалт нь:

1. Үнэгүй үйлчилгээ: зар сурталчилгааны болон бусад зорилгоор үйлчлүүлэгч нарт үнэ төлбөргүйгээр согтууруулах ундаа санал болгох;
2. Олон төрлийн согтууруулах ундаагаар нэгэн зэрэг үйлчлэх: нэг үйлчлүүлэгчид нэгээс илүү төрлийн согтууруулах ундааны зүйлээр нэг зэрэг үйлчлэх;
3. Нэгийн үнээр нэгээс илүү согтууруулах ундаа худалдах: нэг согтууруулах ундааны үнээр дахин нэг ундааг үнэгүй санал болгох, жишээлбэл нэгийн үнээр хоёр, хоёрын үнээр дөрөв гэх мэт урамшуулал;
4. Аз жаргалтай цаг: тодорхой цаг хугацаанд согтууруулах ундааны үнийг бууруулах, хямдрал зарлах, энгийн үеээс доогуур үнээр согтууруулах ундаа тодорхой цаг хугацаанд борлуулах;
5. Тогтоосон хугацаанд, эсхүл тогтоосон нэг үнээр хязгааргүй хэмжээгээр согтууруулах ундааны зүйлээр үйлчлэх;
6. Илүү өндөр хатуулагтай согтууруулах ундааг илүү өндөр үнээр зарах: хатуулгын хувьд харилцан адилгүй согтууруулах ундааг ижил үнээр худалдах зэргээр илэрдэг байна.

2016 оны байдлаар дээрхи жагсаалтын 1 дэх хэсэгт заасан хориглолт 16 муж улсад, 2 дахь хэсэгт заасан хориглолт 4 муж улсад, 3 дахь хэсэгт заасан хориглолт 19 муж улсад, 4 дэх хэсэгт

³¹

https://alcoholpolicy.niaaa.nih.gov/False_Identification_for_Obtaining_Alcohol.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True

³² Alcohol Beverages Pricing, National Institute on Alcohol Abuse and Alcoholism, https://alcoholpolicy.niaaa.nih.gov/False_Identification_for_Obtaining_Alcohol.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True

заасан хориглолт 17 муж улсад, 5 дахь хэсэгт заасан хориглолт 24 муж улсад, 6 дахь хэсэгт заасан хориглолт 10 муж улсад үйлчилж байна.

3.2.2.Согтууруулах ундааг бөөнөөр нь худалдаалах үнэ

Дийлэнхи муж улсуудын хувьд 3 шат дамжлага /үйлдвэрлэгч-бөөнөөр нь борлуулагч-жижиглэн борлуулагч/ бүхий бүтцийг ашигладаг бөгөөд муж улсууд согтууруулах ундааг бөөнөөр нь буюу их хэмжээгээр худалдаалахад тэдгээрийн үнийг тодорхойлоход тодорхой хэмжээний хязгаарлалтыг хуулиар бий болгосон байдаг. Энэ нь дээр дурдсан 3 шат дамжлага бүхий бүтцийг бэхжүүлэх, бөөнөөр болон жижиглэн худалдан борлуулагч нарын дүнд үнийн өрсөлдөөнийг хязгаарлах болон согтууруулах ундааны зах зээл дэх авлига, хээл хахууль, гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой байна.

Ерөнхийд нь авч үзвэл, согтууруулах ундааг бөөнөөр нь худалдан борлуулах үнийн эрх зүйн зохицуулалтыг 4 төрөлд хувааж болох бөгөөд энэ нь:

1. Хатуулгаас хамаарсан хямдрал: худалдан авч байгаа тоо ширхэгээс үл хамаарсан ижил үнэ буюу нэг төрлийн, нэг ижил хатуулагтай согтууруулах ундаа нэг ижил төрлийн үнэтэй байх;
2. Худалдах хамгийн доод хэмжээ/Дээд хямдрал: согтууруулах ундаа тус бүрийг худалдан авч байгаа тоо ширхэгээс хамааран худалдан авах доод хэмжээ, үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг өөрчлөх, харилцан адилгүй байхыг хязгаарласан бөгөөд согтууруулах ундааг худалдах үнэ нь түүний өртөгөөс бага байхыг хориглосон;
3. Үнийг олон нийтэд ил тод байлгах: борлуулж байгаа бүтээгдэхүүний үнийг тодорхой тогтоосон хугацаанд олон нийтэд нээлттэй байлгах. Энэ нь бүх жижиглэнгийн худалдаачдад ижил үнээр согтууруулах ундааг худалдан авах цааш нь дамжуулан борлуулах боломжийг бий болгодог;
4. Зээлээр худалдаалахыг хориглох: Жижгээр худалдан авагч нарт зээл олгох, дараа нөхцөлөөр бараа олгохыг хориглох.

Зарим муж улсууд өөрөө согтууруулах ундааг бөөнөөр нь борлуулдаг бөгөөд энэ нь ихэвчлэн өндөр хатуулаг бүхий согтууруулах ундаанд хамаардаг бөгөөд энэ тохиолдолд муж улсууд өөрсдөө бөөний үнийг тогтоодог байна. Бөөний үнэд хамаарах хязгаарлалт нь зөвхөн архи, согтууруулах ундааг бөөнөөр нь зарж борлуулах зөвшөөрөл бүхий этгээдэд хамаарах бөгөөд үйлдвэрлэгч болон жижиглэн борлуулагч нарын үйл ажиллагаанд хамаардаггүй байна.

2016 оны байдлаар АНУ-ын 14 муж улсад 1 дэх хэсэгт заасан хатуулгаас хамаарсан хямдралыг бүрмөсөн хориглосон, 1 муж улсад хязгаарласан байхад бусад муж улсууд ямар нэгэн хориглолт, хязгаарлалтгүй, эсхүл энэ талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй байна.

2 дахь хэсэгт заасан зохицуулалт нь АНУ-ын 7 мужид байх бөгөөд бусад муж улсуудад энэ талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. 3 дахь хэсэгт заасан зохицуулалтын хувьд АНУ-ын 16 муж улсад энэхүү шаардлагыг заавал дагаж мөрдөх зохицуулалттай байхад, 5 муж улсад зөвхөн үнийг ил тод байлгах, бусад муж улсууд энэ талаар ямар нэгэн зохицуулалтгүй байна.

4 дэх хэсэгт заасан хязгаарлалтын хувьд АНУ-ын 4 муж улсад бөөнөөр худалдаалагч зөвхөн 15 хоног, түүнээс бага хугацаатай зээл олгож болохоор заасан байхад, 13 муж улсад 15 хоног, түүнээс дээш хугацаагаар зээл болгож болох зохицуулалттай байхад, 31 муж улсад согтууруулах ундаа зээлээр худалдан борлуулахыг хориглосон, 1 муж улсад энэ талаар ямар нэгэн зохицуулалтгүй байна.

3.3.ЦУСАН ДАХЬ СПИРТИЙН ХЭМЖЭЭ³³

3.3.1.21 насанд хүрэгчид

³³ Blood Alcohol Concentration, National Institute on Alcohol Abuse and Alcoholism, [https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Blood Alcohol Concentration Limits Adult Operators of Noncommercial Motor Vehicles.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True](https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Blood%20Alcohol%20Concentration%20Limits%20Adult%20Operators%20of%20Noncommercial%20Motor%20Vehicles.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True)

Бүх муж улсуудын хувьд авто тээврийн хэрэгсэл жолоодож буй жолоочийн цусанд хүлээн зөвшөөрөгдөх спиртийн хэмжээг хуульчилсан байдаг ба хуулиар тогтоосон хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хууль зөрчсөн гэж үзэж хариуцлага хүлээлгэх үндэслэл болох юм. Цусан дахь согтууруулах ундаа буюу спиртийн хэмжээг үлээлгэх, эсхүл цус, шээсний дээжээс шинжилгээ авч тогтоодог бөгөөд муж тус бүр энэхүү шинжилгээний аргуудаас алийг нь хэрэглэхээ харилцан адилгүй тогтоосон байна.

Холбооны түвшинд жолоочийн цусан дахь спиртийн хэмжээг тогтоохдоо холбооны эзэмшлийн газар буюу үндэсний цэцэрлэгт хүрээлэнгүүд болон бусад газар дахь зөвшөөрөгдсөн хэмжээг 0,08 ВАС гэж тогтоосон байх бөгөөд энэ нь 2003 оны 9 дүгээр сарын 3-ны өдрөөс өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэхүү зохицуулалтын нэг онцлог нь хэрвээ тухайн үндэсний цэцэрлэгт хүрээлэн буюу холбооны эзэмшлийн газар хил дотор нь байрлаж байгаа муж улсын хуулиар энэ хуульд зааснаас илүү хатуу шаардлагыг тогтоосон бол тухайн шаардлагыг дагаж мөрдөх тухай заасан нь дээрхи зохицуулалт мөн адил муж тус бүрээс хамааран өөрчлөгдөж болохыг харуулж байна.

АНУ-ын мужуудын хувьд 2005 оноос эхлэн 100% бүх мужууд цусанд байж болох спиртийн дээд хэмжээг 0,08 ВАС гэж тогтоосон байх бөгөөд 2005 оноос өмнө буюу 1998 онд 35 муж улс цусанд байж болох спиртийн дээд хэмжээг 0,10 ВАС гэж тогтоосон байсан нь аажмаар өөрчлөгдсөн байна.

3.3.2.21 насанд хүрээгүй хүн

АНУ-ын 34 муж улсад 21 насанд хүрээгүй жолоочийн цусанд зөвшөөрөгдөх спиртийн дээд хязгаарыг 0.02 ВАС³⁴ гэж, 2 муж улсад 0.01 ВАС гэж тогтоосон байхад 15 муж улсад 21 насанд хүрээгүй жолоочийн цусанд спирт байхыг аль ч хэмжээгээр зөвшөөрөөгүй байна.

3.3.3.Завь болон хөлөг онгоц

АНУ-ын дийлэнхи муж улсуудад завь, усан онгоц жолоодож байгаа этгээдийн цусанд байж болох спиртийн дээд хэмжээг тогтоосон байдаг бөгөөд эдгээр муж улсуудад цусан дахь спиртийн хэмжээ нь тухайн этгээдэд хариуцлага оногдуулах ажиллагааны явцад харилцан адилгүй ач холбогдолтой байдаг байна. Зарим муж улсуудад хэрвээ жолоочийн цусанд зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү спирт илэрсэн бол шууд хууль зөрчсөн гэж үзэж хариуцлага хүлээлгэхээр байдаг бөгөөд жолоочийн зүгээс өөрийн буруугүйгээ нотлох ямар нэгэн баримт сэлт хүлээж авдаггүй байна. Харин энэ төрлийн зохицуулалтгүй муж улсуудад цусан дахь спиртийн хэмжээг олон нотлох баримтуудын нэг гэж үздэг бөгөөд дангаараа шууд гэм буруутай гэж үзэх үндэслэл болдоггүй байна.

АНУ-ын 48 мужид цусан дахь спиртийн хэмжээг 0,08 ВАС гэж, 3 муж улсад 0,10 ВАС гэж тогтоосон байна.

3.4.ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ТЭЭВЭРЛЭХ³⁵

Олон муж улсууд авто тээврийн хэрэгсэлд нээлттэй буюу сав, багаа, боодлыг нь онгойлгосон бүх төрлийн согтууруулах ундааг авч явахыг хориглосон хууль баталж мөрдүүлж байгаа бөгөөд энэ тээврийн хэрэгсэл жолоодож явах үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэхээс урьдчилан сэргийлэх зорилготой ажээ.

Муж улсуудын хувьд зохицуулалтын ялгаа нь жолоочоос гадна тухайн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа этгээд сав, баглаа, боодлыг нь задалсан согтууруулах ундааг авч явж болох эсэх, зөвшөөрөх согтууруулах ундааны төрөл болон тухайн хууль нь тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож байх үед үйлчлэх эсэхэд оршиж байна. 2016 оны байдлаар АНУ-ын 46 муж улсад энэ төрлийн хязгаарлалт, хориглолт тогтоосон хууль үйлчилж байна.

³⁴ BLOOD ALCOHOL CONTENT – ЦУСАН ДАХЬ СПИРТИЙН АГУУЛАМЖ

³⁵ Transportation, National Institute on Alcohol Abuse and Alcoholism, https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Open_Containers_of_Alcohol_in_Motor_Vehicles.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True

Дээрхээс гадна АНУ-ын муж улсуудад хэрвээ жолооч архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ авто тээврийн осол гаргасан тохиолдолд даатгагчийн зүгээс ямар нэгэн нөхөн төлбөр олгохгүй тухай хууль үйлчилдэг бөгөөд энэ нь мөн л согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдлыг бууруулах зорилготой.

3.5.СОГТУУРУУЛАХ УНДААГААР ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛЧЛЭХ СУРГАЛТ³⁶

АНУ-ын зарим муж улсууд согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагуудын ажилтнууд тодорхой сургалтад хамрагдсан байх шаардлагыг хуульчилсан байдаг бөгөөд энэхүү сургалтын агуулга нь:

- Насанд хүрээгүй хүн болон согтуу хүмүүст согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх, хөгжүүлэх;
- Зөвшөөрөл эзэмшигч, зохион байгуулагч, үйлчлэг, барменийг архи согтууруулах ундааны талаархи эрх зүйн зохицуулалтыг сахин биелүүлэхэд чиглэсэн байдаг байна.

Зарим муж улсуудын сургалтын хөтөлбөр нь дээрхээс илүү өргөн цар хүрээтэй буюу үйлчлүүлэгч нарыг архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, жирэмсэн эмэгтэй болон жолооч нарт архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байхад чиглэсэн байдаг бөгөөд худалдагч болон үйлчлэгч нарын сургалт нь худалдаалах болон үйлчлэх үйл ажиллагаа-процесс, согтуурсан байдлыг илтгэх шинж тэмдэгүүд, насанд хүрсэн эсэхийг шалгах арга ажиллагаа зэргийг багтаасан байдаг.

Муж улсуудын хэмжээнд мөн согтууруулах ундааг зарж болохгүй өдөр, цагийн талаар харилцан адилгүй зохицуулалттай байдаг. Жишээлбэл, 2016 оны байдлаар АНУ-ын 12 муж улсад бүтэн сайд өдөр буюу ням гарагт архи, согтууруулах ундааны зүйл худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосон байдаг байна.

АНУ-ын 19 мужид согтууруулах ундаагаар үйлчлэгч нар нь зохих сургалтанд заавал хамрагдсан байх шаардлагыг хуульчилсан бөгөөд 26 мужид сайн дурын үндсэн дээр уг сургалтанд хамрагдаж болохоор хуульчилсан байхад 12 муж улс нь энэ талаар ямар нэгэн хууль, зохицуулалтгүй байна.

Зарим муж улсууд нь “KEG REGISTRATION” гэж зохицуулалттай бөгөөд энэхүү зохицуулалтын утга нь бөөнөөр, эсхүл жижиглэнгээр худалдагч тодорхой хэмжээнээс илүү /муж улс бүрээс хамааран 3 литрээс 20 литр/ шар айраг худалдан авах бол тодорхой дугаар, мэдээлэл бүхий наалт, тэмдэглэгээг наах бөгөөд худалдан авагчийн хувийн бичиг баримтын мэдээллийг мөн авдаг байна. Үүний дараа худалдан авагчаас барьцаа авч үлдэх бөгөөд уг худалдан авагч наалт, тэмдэглэлээг ямар нэгэн эвдрэл гэмтэлгүйгээр буцаан авч ирсэн тохиолдолд барьцааг буцаан олгох бөгөөд энэ үйл ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийг хууль сахиулах ажиллагаанд мөн ашиглаж болдог бөгөөд эдгээр мэдээллийн тусламжтайгаар хэн хичнээн хэмжээний шар айраг худалдан авсан болон хаана хэрэглэснийг тогтоох боломжтой байдаг байна.

3.6.СОГТУУРУУЛАХ УНДААНД ХЯНАЛТ ТАВИХ³⁷

Муж улсуудын хувьд согтууруулах ундааны бөөний болон жижиглэнгийн худалдаанд харилцан адилгүй байдлаар хяналт тавьж байгаа байдал ажиглагдаж байна. Зарим муж улсуудад согтууруулах ундааны бөөний худалдааг тухайн муж улс өөрөө эрхлэн явуулж ашгийг нь өөрөө хүртдэг бол зарим муж улсуудын хувьд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр бүхий л үйл ажиллагааг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдээр гүйцэтгүүлдэг байна. Мөн муж улсууд согтууруулах ундааны төрөл, хатуулгаас хамаарч тэдгээрийг ямар төрлийн аж ахуйн нэгж зарж борлуулж болохыг

³⁶Beverage Service Training, National Institute on Alcohol Abuse and Alcoholism, https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Beverage_Service_Training_and_Related_Practices.html?tab=about&date=1/1/1998&dateStart=1/1/1998&dateEnd=1/1/2016&onlyChanges=True

³⁷Alcohol Control Systems, National Institute on Alcohol Abuse and Alcoholism, https://alcoholpolicy.niaaa.nih.gov/Alcohol_Control_Systems_Retail_Distribution_Systems_for_Beer.html?tab=about&date=1/1/2003&dateStart=1/1/2003&dateEnd=1/1/2016&onlyChanges=True

тодорхой зохицуулсан бөгөөд зарим төрлийн дэлгүүр, зоогийн газруудад согтууруулах ундааг зарж борлуулахыг хориглосон байдаг байна.

Тухайлбал, 2016 оны байдлаар 3 муж улсад шар айргийн жижиглэнгийн худалдааг муж улсын эзэмшлийн дэлгүүр, үйлчилгээний газрууд гүйцэтгэдэг бол хатуулаг өндөртэй архи, виски болон түүнтэй адилтгах согтууруулах ундааны хувьд 11 муж улсад тухайн муж улс өөрөө бөөний худалдааг эрхлэн гүйцэтгэдэг байна.

3.6.1.Жирэмслэлт бол согтууруулах ундааны хэрэглээ

АНУ-ын дийлэнх муж улсуудад архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг болон худалдаалдаг газрууд болон жирэмсэн эмэгтэйчүүд үйлчлүүлдэг эмнэлгийн байгууллагуудад жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх архины хор хөнөөлийн талаар анхааруулсан тэмдэглэгээг байршуулахыг шаарддаг бөгөөд 2016 оны байдлаар 24 муж улсад энэ төрлийн хууль үйлчилж байна.

Жирэмсэн үедээ архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн бөгөөд энэ нь эхэс болон хүүхдэд ямар нэгэн хор хөнөөл учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зарим муж улсуудын хуульд заасан байна. Жирэмсний үед архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэх нь эхэс болон хүүхдэд маш их хор хөнөөлтэй бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор муж улсууд тодорхой хэмжээний арга хэмжээ авч байгаагийн илэрхийлэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал гэжээ.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн тулд жирэмсэн эхийн төрөл бүрийн шинжилгээ, түүний хариуг ашиглаж болдог бөгөөд зарим муж улсуудын хувьд энэхүү шинжилгээний хариуг, үр дүнг ямар хэлбэрээр ашиглах, энэхүү мэдээлэл нь ямар ач холбогдолтой болох талаар харилцан адилгүй зохицуулалттай байна. АНУ-ын 7 муж улсаас бусад нь эрүүгийн хариуцлагыг ямар нэгэн хязгаарлалт, хориглолтгүйгээр хүлээлгэж болох зохицуулалттай байна.

Зарим муж улсуудын хувьд эхэс болон хүүхдийн эрүүл мэндэд учирч болох болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор архи, согтууруулах ундаа хэрэглэж байгаа жирэмсэн эмэгтэйг албадан эмчлэх байгууллагад байршуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх хуультай байна. Жишээлбэл, Миннесота муж улсын хуулиар сонирхол бүхий этгээд энэ тухай гомдлыг шүүхэд гаргаж өгч болох бөгөөд сонирхол бүхий этгээд гэдэгт эхэс болон хүүхдийн ойр дотны хүн, эсхүл энэ талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан тушаалтан, хууль ёсны төлөөлөгч, даатгалын болон эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан тушаалтан байж болох юм. Энэ тохиолдолд тухайн жирэмсэн эмэгтэйг эмнэлчилгээний зорилгогүйгээр архи, согтууруулах ундааны зүйлийг тогтмол, хэтрүүлэн хэрэглэдгийг тогтоох шаардлагатай бөгөөд 90 хүртэлх хоногоор албадан эмчлэх байранд байршуулж болох зохицуулалттай байна. 2016 оны байдлаар АНУ-ын 5 муж улсад энэ төрлийн эрх зүйн зохицуулалт байна.

Түүнчлэн жирэмсэн эмэгтэйг архи, согтууруулах ундаа хэрэглэж байгаа талаар мэдсэн хэн боловч энэ талаар хууль сахиулах болон эрүүл мэндийн байгууллагад заавал мэдэгдэх тухай зохицуулалттай 36 муж улс байна.

ДӨРӨВ.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Согтууруулах ундааны зах зээл, түүний эргэлтийг үр дүнтэй зохион байгуулах гурван төрлийн үндсэн шаардлага байдаг нь нэгдүгээрт, архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаанаас улсын төсөвт орох хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хоёрдугаарт, согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлыг сайжруулах, гуравдугаарт, олон нийтийг согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх явдлыг багасгах юм.

ОХУ-д хийсэн сүүлийн үеийн судалгаагаар ОХУ-ын нэг иргэнд ногдох согтууруулах ундааны хэмжээ дэлхийн дунджаар 8 литр байхад ОХУ-д энэ үзүүлэлт 18 литр байна. Харин согтууруулах ундаагаар үйлчлэх болон худалдаалах цэгийн тоог авч үзвэл Исландид энэ тоо 4,75 хувиас дээш хатуулагтай согтууруулах ундаагаар үйлчлэх нэг цэгт 15,9 мянган хүн ногдож байгаа бол Финляндад энэ тоо 6,3 мянга, Швед болон Норвегид тус бүр 4,5 мянга байхад ОХУ-д 518 хүнд энэ төрлийн

үйлчилгээ эрхэлдэг нэг цэг ногдож байгаа нь маш өндөр үзүүлэлт болж байна. ОХУ-ын зарим Субъектуудын хувьд энэ тоо харилцан адилгүй байгаа бөгөөд, жишээлбэл Республика Бурятия – 204, Амурская область – 193, Волгоградская область - 192 байна.³⁸

ОХУ-ын хувьд архи, согтууруулах ундааг үйлдвэрлэх болон түүнийг хэрэглэх харилцааг 1995 оны 7 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан “Этилийн спиртийн эргэлт болон үйлдвэрлэл, алкоголь болон спирт агуулсан бүтээгдэхүүний эргэлтэд хяналт тавих, түүний хэрэглээг хязгаарлах тухай” холбооны улсын хуулиар зохицуулж байгаа бөгөөд энэ хуульд хамгийн сүүлд 2017 оны 7 дугаар сарын 29-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.³⁹

Уг хуулиар архи, согтууруулах ундааны зүйлийг үйлдвэрлэх болон түүнийг зах зээлийн эргэлтэд оруулах, согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлахад чиглэсэн зохицуулалтыг бий болгосон бөгөөд энэ бүхий л үйл ажиллагаа нь хүн амын эрүүл мэнд, эрх, хууль ёсны эрх ашиг, аюулгүй байдал, ОХУ-ын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилготой гэж тодорхойлжээ.⁴⁰

Уг хуулийн зохицуулалт уг хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар дараахь төрлийн бүтээгдэхүүн болон түүнд холбогдох харилцаанд хамаарахгүй гэжээ. Үүнд:

- хувь хүмүүсийн үндэсний уламжлалт аргаар, ашиг олох зорилгогүйгээр, хувийн болон гэр бүлийн хэрэгцээнд ашиглахаар үйлдвэрлэж байгаа этилийн спирт агуулсан бүтээгдэхүүн;
- төрийн эрх бүхий байгууллага болон улсын бүртгэлд бүртгэгдсэн спирт агуулсан эм, эмнэлэгийн хэрэгсэл;
- эмнэлэгийн байгууллагаас гаргасан жор, зааврын дагуу спиртын агууламж бүхий эм, эмчилгээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах үйл ажиллагаа явуулдаг эмийн сан;
- 450 миллилитрээс бага хэмжээгээр савласан хүнсний бус зориулалтын спиртын агууламж бүхий бүтээгдэхүүн;
- Олон улсын болон дипломат байгууллагын хэрэгцээнд зориулан ОХУ-ын нутаг дэвсгэрт оруулж байгаа болон түүнээс гаргасан байгаа спирт агуулсан бүтээгдэхүүн зэрэг байна.

Хуулийн 2 дугаар зүйлд уг хуульд хэрэглэсэн нэр томьёоны тодорхойлолтыг тусгасан байх бөгөөд уг нэр томьёонуудад этилийн спирт, спирт агуулсан бүтээгдэхүүн, спирт агуулсан эмийн бүтээгдэхүүн, спирт агуулсан хүнсний бүтээгдэхүүн, коньяк, архи, пиво, дарс гэх зэрэг нэр томьёонууд байна.

Хуулийн 6, 7 дугаар зүйлүүдэд архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлтэд хяналт тавих талаар холбооны засгийн газар, түүний харьяа байгууллагууд болон харьяа улс, орон нутгийн засаг захиргааны байгууллагын бүрэн эрхийг тусгасан байна.

Хуулийн 8 дугаар зүйлд алкоголь болон спирт агуулсан бүтээгдэхүүн, этилийн спиртийг үйлдвэрлэх болон түүнийг эргэлтэд оруулахад тавигдах шаардлагыг хуульчилсан байна. Энэхүү зүйлд архи, согтууруулах ундааны зүйлийг үйлдвэрлэхэд ашиглагддаг бүхий л тоног төхөөрөмж нь улсын стандарт, шаардлагад нийцсэн байх, энэ тухай сертификатыг уг төхөөрөмжүүд дээр байршуулах, эдгээр төхөөрөмжүүд нь спирт болон алкоголийн агууламж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг автоматаар бүртгэдэг, тодорхойлдог байх үндсэн шаардлагыг тавьсан байна. Энэхүү зүйлд дурдсан нэг онцлог зохицуулалт нь согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглагддаг тоног төхөөрөмжүүдийн мэдээллийн систем, програм хангамж нь эрх бүхий

³⁸ Потребление алкоголя в России,

<http://ruxpert.ru/%D0%9F%D0%BE%D1%82%D1%80%D0%B5%D0%B1%D0%BB%D0%B5%D0%BD%D0%B8%D0%B5%D0%B0%D0%BB%D0%BA%D0%BE%D0%B3%D0%BE%D0%BB%D1%8F%D0%B2%D0%A0%D0%BE%D1%81%D1%81%D0%B8%D0%B8>

39

В законодательство внесены изменения, ужесточающие ответственность за незаконную продажу алкогольной продукции, 2017.08.01 <http://kremlin.ru/acts/news/55267>

⁴⁰ ФЗ “О государственном регулировании производства и оборота этилового спирта, алкогольной и спиртосодержащей продукции и об ограничении потребления /распития/ алкогольной продукции, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8368/

байгууллагаар хянан баталгаажуулагдсан байх шаардлагатай бөгөөд мэдээллийн систем, програм хангамжид тавигдах шаардлагыг мөн хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, архи, согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглаж байгаа үндсэн тоног төхөөрөмжийг ашиглаж эхлэхийн өмнө заавал бүртгүүлэх, тодорхой хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянуулах үүргийг аж ахуй эрхлэгч нар хүлээж байна.

Мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Засгийн газар нь согтууруулах ундааны сав баглаа боодолд тавих ерөнхий шаардлагыг тогтоох бөгөөд сав баглаа боодол нь гаднаас нь харахад нээгдсэн эсэх нь мэдэгдэхүйц байна гэжээ. Хуулийн энэ зүйлийн хүрээнд ОХУ-ын Засгийн газрын 2005 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн тогтоол гарч, одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд хамгийн сүүлд 2010 оны 3 дугаар сарын 4-ний өдөр өөрчлөлт орсон байна.

Мөн сонирхолтой нэг зохицуулалт нь уг зүйлийн 5 дахь хэсэгт: Согтууруулах ундааг экспортлох, импортлохоос бусад худалдан авах, нийлүүлэх болон жижиглэнгээр худалдах доод үнийг Засгийн газар тогтоох бөгөөд үүнээс доогуур үнээр нийлүүлэх, худалдан авах, борлуулахыг хориглосон байна. Энэхүү хуулийн заалтын хүрээнд ОХУ-ын Сангийн яамны 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн тушаал гарсан бөгөөд энэхүү тушаалаар 28 хувиас дээш хатуулагтай согтууруулах ундааны үнийн талаар зохицуулжээ.

2011 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар уг хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт өөрчлөлт оруулж 7 хувиас доош хатуулагтай согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлтэд 330 миллилитрээс ихгүй хэмжээгээр савлах зохицуулалтыг нэмж тусгасан бөгөөд мөн зүйлийн 6.1 дэх хэсгээр 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс согтууруулах ундааны үйлдвэрлэл, жижиглэнгээр худалдаалахаас бус бүх эргэлтэд согтууруулах ундааг 1.5 литрээс илүү хэмжээтэй пластик сав хэрэглэхийг хориглосон байна. Энэхүү зохицуулалт нь ихэвчлэн шар айрагний үйлдвэрлэл эрхлэгчид хамаарна гэж үзэж байгаа бөгөөд учир нь ОХУ-д үйлдвэрлэгдэж байсан шар айрагны 15 хувь нь 1,5 литрээс илүү хэмжээтэй пластик савлагаатай байсан байна.

Хуулийн 12 дугаар зүйлд зааснаар шар айрагнаас бусад төрлийн бүхий л согтууруулах ундаанд тусгайлсан тэмдэглэгээ буюу улсын бүртгэл, тэмдэглэгээ хийгдэж байх тухай шаардлагыг хуульчилсан бөгөөд мөн зүйлд импортоор оруулж ирж байгаа архи, согтууруулах ундааны зүйлд хэрхэн тусгайлсан тэмдэглэгээ хийх журмыг тодорхой тусгажээ.

Хуулийн 13 дугаар зүйлд согтууруулах ундааг импортлох болон экспортлох үйл ажиллагааг эрхлэх журам, түүнд тавигдах шаардлагыг дэлгэрэнгүй тогтоосон байна.

Хуулийн 14 дүгээр зүйлд согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлтийн хэмжээ, этилийн спиртын ашиглалтын байдлын талаархи мэдээ, үйлдвэрлэлийн хүчин чадлын талаархи мэдээллийг цуглуулах, хяналт тавих, бүртгэх ажиллагааны талаархи журмыг хуульчилсан бөгөөд согтууруулах ундааг үйлдвэрлэх, эсхүл түүнийг худалдаалж байгаа бүхий л этгээд эргэлтэд оруулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг тогтмол бүртгэх, заавал мэдээлэх үүргийг тусгасан байна. Энэ зүйлд согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, статистикийн мэдээлэл гаргах эрх бүхий төрийн байгууллага электрон хэлбэрээр мэдээллийн сүлжээ ашиглан мэдээний хуудсыг илгээх харин үйлдвэрлэгч болон худалдаа эрхлэгч уг хуудсын дагуу мэдээллийг бүрэн гүйцэд төрийн байгууллагад хүргүүлж байхаар заасан байна.

Хуулийн 16 дугаар зүйлд согтууруулах ундааг жижиглэнгээр худалдан борлуулах, олон нийтийн үйлчилгээний газарт түүгээр үйлчлэхэд тавигдах дараахь тусгай шаардлагыг хуульчилсан байна:

- Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, болон худалдаалах үйл ажиллагааг зөвхөн хуулийн этгээд эрхлэх эрхтэй байх;
- Архи, согтууруулах ундааг бүх төрөл, хэлбэрийн боловсрол, соёл, спорт болон эмнэлэгийн байгууллага, олон нийтийн худалдааны төв, зах, бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл, цэрэг, батлан хамгаалах салбарын бүхий л объект, байрлал, галт тэрэг болон нисэх онгоцны буудал, аюултай эд зүйл, объект байрлаж байгаа газрын ойр орчинд, нийтийг хамарсан аливаа үйл ажиллагааны үед болон дээр дурьдсан бүхий л

хориглосон газруудын ойр орчин, түүнтэй залгаа объект газар дээр хэрэглэх, худалдаалахыг хориглох;

- Энэ хуульд заасан шаардлага, стандартад нийцээгүй архи, согтууруулах ундааны зүйл худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглох, тусгай зөвшөөрөлгүйгээр дээрхи үйл ажиллагааг эрхлэхийг хориглох;
- Нийтийн үйлчилгээний болон хоолны газрууд нь үйлчүүлэгч нарт үйлчлэх тусгай заалтай тохиолдолд согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл олгох;
- 23,00-08,00 цагийн хооронд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох, орон нутгийн захиргааны байгууллага нь өөрийн нутаг дэвсгэр дээр согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах үүнээс илүү хязгаарлалт, хориглолт тавьж болох эрхтэй байх;
- Согтууруулах ундаа худалдаах эрхтэй этгээд нь өөрийн эзэмшилд тус бүр нь 50 м.кв-аас багагүй хэмжээтэй талбайтай үйлчилгээний хэсэгтэй байх шаардлагатай бөгөөд хэрвээ түрээслэж байгаа буюу түр хугацаагаар эзэмшиж байгаа бол уг эрх нь нэг жилээс илүү хугацаатай байх зэрэг байна.

2017 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж архи, согтууруулах ундааны зүйлийг жижиглэнгээр худалдаа эрхлэгч үйл ажиллагаандаа интернет сүлжээнд холбогдсон кассын машин буюу хянаж, бүртгэх тоног төхөөрөмжийг заавал ашиглах заалтыг нэмж тусгасан байна.

ОХУ-ын Субъектуудын хувьд архи, согтууруулах ундаагаар үйлчилж болох цагийг дараахь байдлаар харилцан адилгүй зохицуулсан байна:

- Москва /23.00-08.00/;
- Подмосковье /21,00-11,00/;
- Санкт-Петербург /22,00-11,00/;
- Астраханская область /21.00-10.00/;
- Псковская область /21,00-10,00/;
- Якутия /20,00-14,00/;
- Чеченская республика /зөвхөн өглөөний 08,00-10,00 цагийн хооронд согтууруулах ундааны зүйл худалдан авч болно/;
- Кировская область /Ажлын өдрүүдэд 23,00-10,00, амралтын өдрүүдэд 17 цагаас хойш согтууруулах ундаа худалдаалахыг хориглосон/;
- Ульяновская область /Ажлын өдрүүдэд 20,00-08,00, харин амралтын өдрүүдэд согтууруулах ундааны зүйл худалдаалахыг хориглосон/;
- Саратов /22,00-10,00/;
- Тульская область /Зөвхөн 14,00-22,00 цагийн хооронд согтууруулах ундааны зүйл худалдан авч болно/.⁴¹

Түүнчлэн мөн хуулиар ОХУ-ын Субъектүүдэд хуулиар тогтоосноос илүү хязгаарлалт, хориглолт тогтоох эрхийг олгосны дагуу Субъектүүд харилцан адилгүй байдлаар согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалахыг хориглосон өдрүүдийг нийтлэгтээ дараахь байдлаар бие даан тогтоосон байна:

- 5 дугаар сарын 25 буюу ЕБС-ийн хичээлийн жил дуусах өдөр;
- ЕБС-ийн төгсөлтийн үдэшлэг болох өдрүүдэд;
- 6 дугаар сарын 1 буюу хүүхдийн эрхийг хамгаалах өдөр;
- 6 дугаар сарын 27 буюу залуучуудын өдөр;
- 9 дүгээр сарын 1 буюу хичээлийн шинэ жилийн нээлтийн өдөр;
- 9 дүгээр сарын 11 буюу эрүүл амьдралын өдөр зэрэг байна.⁴²

⁴¹ Часы продажи алкоголя в России, <http://spirtok.ru/chasy-prodazhi-alkogolya-v-rossii-2/>

⁴² Часы продажи алкоголя в России, <http://spirtok.ru/chasy-prodazhi-alkogolya-v-rossii-2/>

Хуулийн 18, 19 дүгээр зүйлд согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлттэй холбоотой заавал тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааны жагсаалтыг зааж, тусгай зөвшөөрөл олгох, болзол нөхцөлийг тусгасан байна.

ОХУ-ын Захиргааны хариуцлагын тухай хууль болон Эрүүгийн хуульд дээрх хуулийн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагыг тусгасан бөгөөд:

- Худалдан борлуулах зорилгоор согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэлийг санхүүжүүлсэн бол 500 000 рублээр торгож, хууль бус бүтээгдэхүүнийг хураан авах шийтгэл оногдуулах;
- Ахуйн нөхцөлд, эсхүл хуульд заасан шаардлагыг хангаагүй нөхцөлд хууль бусаар согтууруулах ундаа үйлдвэрлэх тоног төхөөрөмж нийлүүлсэн, борлуулсан бол торгох шийтгэл оногдуулах;
- Худалдан борлуулах зорилгоор согтууруулах ундааг их хэмжээгээр хадгалсан бол торгох шийтгэл оногдуулах;
- Хуульд заасан чанар, стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны зүйл үйлдвэрлэсний улмаас хүний амь нас хохирсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх;
- Худалдан борлуулах зорилгоор спиртийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх зэрэг үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Түүнчлэн хуульд худалдан борлуулахыг хориглосон согтууруулах ундааны хатуулгын хэмжээг тодорхой заасан нь 0.5 литр тутамд 45 хувиас илүү хатуулагтай согтууруулах ундаа юм. Учир нь энэ тохиолдолд хүний эрүүл мэндэд өндөр эрсдэл үүсэх ба хэрэглэсэн тохиололд аюултай хор уршиг дагуулж болзошгүй гэж үздэг байна.

2017 оны 7 дугаар сарын 27-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин ОХУ-ын Эрүүгийн хуульд архи, согтууруулах ундааны хууль бус эргэлттэй тэмцэх зорилготой нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болсон бөгөөд уг хуулиар “архи, согтууруулах ундааг хууль бусаар үйлдвэрлэсэн, хууль бусаар эргэлтэд оруулсан буюу хууль бус согтууруулах ундаа үйлдвэрлэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, худалдсан”, “архи, согтууруулах ундааг хууль бусаар худалдаалсан”, “тусгайлсан тэмдэглэгээг хуурамчаар үйлдсэн” үйлдлийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Эхний үйлдэлд нь 2-3 сая рублиэр, эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээдийн 1-3 жилийн хугацааны орлого, эсхүл цалин хөлстэй тэнцэхүйц хэмжээний мөнгөөр торгох, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар албадан ажил хийх, эсхүл тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх эрхийг нь хязгаарлаж 3 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах ял шийтгэхээр заасан байна. Хэрэв уг гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, эсхүл онц их хэмжээгээр үйлдсэн бол шийтгэлийг хүндрүүлэхээр заасан байна.

Хоёр дахь үйлдэл буюу архи, согтууруулах ундааг хууль бусаар худалдаалсан гэмт хэрэгт 50 мянгаас 80 мянга хүртэл хэмжээний рублиэр торгох, эсхүл 3-6 сарын хугацааны цалин хөлс, бусад орлоготой нь тэнцэхүйц хэмжээний мөнгөөр торгох, эсхүл 1 жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэхээр заасан байна.

ОХУ-ын Зар сурталчилгааны тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар согтууруулах зар сурталчилгаа нь дараахь агуулгатай байхыг хориглодог байна:

- Согуутуурлах ундаа нь өөрийн тавьсан үр дүндээ хүрэх, нийгэмд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх, мэргэжлийн, спортын болон хувийн амжилтанд хүрэх, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дээшлүүлдэг гэх;
- Согтууруулах ундаанаас татгалзах үйлдлийг буруушаасан;
- Согтууруулах ундаа нь хүний эрүүл мэндэд сайн нөлөө үзүүлдэг, өвчнийг илааршуулдаг буюу витамин, нэмэлт тэжээл агуулдаг гэх;
- Насанд хүрээгүй хүнд чиглэсэн агуулгатай байх зэрэг байна.

Түүнчлэн мөн хуульд согтууруулах ундааны зар сурталчилгааг байршуулахыг хориглосон хэлбэр, газруудыг тодорхой заасан байна.⁴³

ОХУ-д нэгдсэн автомат бүртгэлийн системийг ашиглаж эхэлсэн бөгөөд энэхүү систем нь спиртийг анх үйлдвэрлэсэн цагаас нь эхлэн түүнийг бэлэн бүтээгдэхүүн болгон хэрэглэгчид хүрэх хүртэлх хугацаанд хянах нэгдсэн, автомат механизм юм. Энэхүү систем нь этилийн спирт, алкоголь, спирт агуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эргэлтийг хянах үндсэн зориулттай бөгөөд спиртийг анх үйлдвэрлэгдснээс эхлэн эцсийн хэрэглэгч дээр бүтээгдэхүүн болж очих хүртэл шат дамжлагад хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

Тухайлбал, энэхүү системийн тоолуур нь спирт үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд дээр байрлах бөгөөд үйлдвэрлэсэн литр бүрийг хянадаг бөгөөд үйлдвэрээс гарсан спирт согтууруулах ундаа үйлдвэрлэх үйлдвэрүүдэд хүргэгддэг ба энэ шат дамжлагийг ч спирт зөөдөг тээврийн хэрэгслүүдэд энэхүү системийн тоолуурыг байршуулах замаар хянадаг байна.

Спирт тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, маршрут ч мөн хянагддаг бөгөөд согтууруулах ундааны үйлдвэр дээр хүлээж авахад мөн хянаж, энэхүү үйлдвэрээс гарч байгаа бэлэн бүтээгдэхүүнийг мөн тоолуурын тусгамжтайгаар хянаж үйлдвэрлэлийн шат дамжлага дунд тусгайлсан тэмдэглэгч сав, баглаа, боодол тус бүр дээр хийдэг бөгөөд энэхүү тусгай тэмдэглэгээнд бүтээгдэхүүний нэр, хэмжээ, хатуулгын хэмжээг заана. Тусгай тэмдэглээний талаархи мэдээлэл мөн нэгдсэн мэдээлэлийн сүлжээнд бүртгэгдэж үйлдвэрлэгчийн агуулахаас согтуурууруулах ундааг худалдан борлуулагчид хүргэх бөгөөд энэхүү процесс ч мөн нэгдсэн системд шат дараатайгаар бүртгэгдэж байдаг байна. Ингээд дэлгүүрийн лангуун дээр очсоны дараа хэрэглэгч тухайн бүтээгдэхүүнийг худалдан авсан бол тухайн дэлгүүрийн мөн л нэгдсэн сүлжээнд холбогдсон кассын машинд уншуулах бөгөөд энэхүү кассын машин бүтээгдэхүүнийг согтууруулах ундаа гэж автоматаар таних бөгөөд үйлдвэрлэгчийн хийсэн тусгайлсан тэмдэглэгээг мөн уншуулахыг шаардах бөгөөд кассын машинд тэмдэглэгээг уншуулсны дараа автоматаар сүлжээн дэх мэдээлэлтэй тулган шалгаж ямар нэгэн зөрчилгүй /хуулийн дагуу үйлдвэрлэгдсэн/ бол баримтыг нь өгөх бөгөөд энэ хүрээд худалдах-худалдан авах ажиллагаа дуусдаг байна. Хэрэв кассын машин тухайн бүтээгдэхүүнийг хууль бус буюу нэгдсэн бүртгэлд бүртгэлгүй, эсхүл хуурамч гэж илрүүлсэн тохиолдолд зөрчлийн талаархи мэдээлэл автоматаар хяналт тавих эрх бүхий байгууллагад дамжуулагдах бөгөөд үүний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулдаг байна.

Шүүмжлэгчид энэхүү системийг ашиглаж эхэлснээр согтууруулах ундааны зах зээлд хямрал үүснэ гэж тооцоолж байсан боловч төрийн байгууллагад, аж ахуй эрхлэгчид энэхүү системийг амжилттай нэвтрүүлж, нийт согтууруулах ундааны зах зээлийн оролцогчдын 95 гаруй хувь нь уг системийг хэвийн ашиглаж байна.

ОХУ-д 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ОХУ-ын Ерөнхийлөгчийн шийдвэрээр Сангийн яамны харьяанд Согтууруулах ундааны зах зээлийг зохицуулах холбооны агентлаг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд түүний зорилго, чиг үүрэг нь:

- Согтууруулах ундааны хэрэглээг багасгах;
- Согтууруулах ундааны хууль бус эргэлтийг багасгах;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлтэд тавих хяналтыг эрчимжүүлэх;
- Согтууруулах ундааны татвар хураамжаас улсын төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх;
- Согтууруулах ундааны зах зээлийг зохицуулах зорилгоор эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Зөвшөөрөл олгох;
- Тусгайлсан тэмдэглэгээг олгох;
- Зөвшөөрлийн бүртгэл хөтлөх;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлтийн нэгдсэн автомат бүртгэлийн системийг хөтлөх;
- Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;
- Үйлдвэрлэлийн үндэн тоног төхөөрөмжийн бүртгэл хөтлөх;
- Согтууруулах ундааны бүртгэлийг хөтлөх;

⁴³ Государственное регулирование оборота алкоголя в России, <https://rg.ru/sujet/2316/>

- Согтууруулах ундаа үйлдвэрлэсэн мэдээг хүлээн авах, бүртгэх, хяналт шалгалт хийх;
- Хураагдсан бүтээгдэхүүнийг хадгалах, устгах зэрэг байна.

ОХУ-д 2009 онд ОХУ дахь архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх явдлыг багасгах, хүн амын эрүүл мэндийг архи, согтууруулах ундааны хор хөнөөлөөс хамгаалах төрийн бодлогын баримт бичиг батлагдсан бөгөөд энэхүү бодлогын баримт бичиг нь дараахь зарчимд үндэслэнэ:

- Хүн амын эрүүл мэнд аюулгүй байдлыг архи, согтууруулах ундааны зах зээлийн эдийн засгийн ашиг сонирхлоос дээгүүр тавих;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлтэд хамааралгүй төрийн байгууллага, төрийн бус байгууллага, шашны байгууллага, олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Архи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хяналт шалгалтын талаархи мэдээллийг нээлттэй, ил тод байлгах зэрэг.

Энэхүү бодлогын баримт бичигт согтууруулах ундааны зах зээлд оролцогч нарын ашиг сонирхлыг хөндсөн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ:

- Согтууруулах ундаагаар үйлчлэх, түүнийг худалдан борлуулах цаг, байршлыг хязгаарлах замаар согтууруулах ундааны олдоц, хэрэглээг бууруулах;
- Хүн амын, тэр дундаа насанд хүрээгүй хүмүүс, залуучуудын сонирхлыг татахуйц согтууруулах ундааны далд зар сурталчилгааг хязгаарлах /хориглох/;
- Согтууруулах ундааг хүний эрүүл мэнд, бие махбодид ашиг тустай гэсэн утгатай мэдээллийг ашиглах, энэ хэлбэрээр сурталчлахыг хориглох;
- Согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх, түүнийг хэрэглэхийг олон түмэнд уриалсан шинжтэй нийтийг хамарсан, нийтэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хязгаарлах, /шар айрагны баяр, дарсны баяр, үүнтэй холбогдсон тэмцээн уралдаан/;
- Согтууруулах ундааг үйлдвэрлэх болон түүнийг эргэлтэд оруулах журмыг зөрсөн тохиолдолд хүлээлгэх захиргааны хариуцлагыг чангатгах;
- Хууль бус согтууруулах ундааны зах зээлийг илрүүлэх, таслан зогсоох, согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлтэд тавих төрийн хяналтыг сайжруулах.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Архи согтууруулах ундааны эргэлтийг хязгаарлах, архи, согтууруулах , ундааг хэтрүүлэн хэрэглэх эмгэгээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хор хөнөөлийг багасгах зорилгоор авч хэрэгжүүлсэн дэлхийн улс орнуудын сайн туршлагаудыг судлахад манай орны хууль тогтоомжид тусгах эсэхийг цаашид судлах, хэрэгжүүлэх боломжтой дараахь сайн туршлага зохицуулалтууд байна гэж үзлээ.

- 1. Архи, согтууруулах ундааг худалдан авах, хэрэглэх насны доод хязгаар болон насанд хүрээгүй этгээдэд согтууруулах ундаа худалдаалах, тэдгээрийг согтууруулах ундаа биедээ авч явж болох насны хязгаарыг харилцан уялдаа холбоотойгоор хуульчлан тогтоох;**

/АНУ-д хийсэн судалгаагаар архи, согтууруулах ундааг хэрэглэж болох, худалдан авч болохыг насныг 21 нас болгох шийдвэр нь олон нийтийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн түүхэн дэх хамгийн оновчтой, үр дүнтэй шийдвэрүүдийн нэг байсан гэж үзсэн бөгөөд энэ нь 1975 оноос хойшхи хугацаанд нийт 24,000 хүний амь насыг аварсан гэж тооцоолсон байна./

Түүнчлэн 21 насанд хүрээгүй хүнд архи, согтууруулах ундааны зүйлийг биедээ авч явах, эзэмшихийг хориглосноор эдгээр насны хүмүүсийн дундан согтууруулах ундааны хэрэглээг 11 хувиар, эдгээр насны хүмүүсийн холбогдсон согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол, хэргийн тоо 7 хувиар буурсан гэжээ.

*Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалт, 7.3.2 дахь заалтаар 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдах, үйлчлэх, түүнд хэрэглэхийг хориглосон **хэдий ч биедээ авч явж болох эсэх талаар***

ямар нэгэн зохицуулалт байхгүй байгаа нь хуулийн эдгээр зохицуулалтыг хэрэглэхэд хүндрэлтэй байдал бий болгож, хууль хэрэгжихгүй байх нөхцөл байдалд хүрч байна. Учир нь хууль тогтоогч зөвхөн хэрэглэх, худалдах, үйлчлэхийг хориглосон нь хууль сахиулагч, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээд хуульд заасан дээрхи үйлдлийг тогтоох шаардлага гарч байгаа бөгөөд аливаа этгээд хэрэглэж амжаагүй, хэрэглэхээр хэн нэгнээс худалдаж аваагүй, бэлгэнд авсан, эсхүл үнэ төлбөргүйгээр дамжуулан авч биедээ авч яваа нь тогтоогдсон тохиолдолд тухайн этгээдийг согтууруулах ундаа хэрэглэхээс өмнө урьдчилан сэргийлэх, согтууруулах ундааг хураан авах, хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй байгаа юм. Иймд хуулийн дээрхи зохицуулалтуудыг бүрэн хэмжээнд, цогцоор нь хэрэгжүүлэх зорилгоор **биедээ авч явах насны хязгаарыг тогтоож, хариуцлага хүлээлгэх** механизмыг бий болгох шаардлагатай.

- 2. Архи, согтууруулах ундааг худалдаалах, түүгээр үйлчлэх насны доод хязгаарыг хуульчлан тогтоосныг /18 нас гэж/ эргэн харах, уг насны хязгаарыг согтууруулах ундаа худалдан авч болох, хэрэглэж болох насны хязгаартай ижил түвшинд байхаар хуульчлан тогтоох;**

/21 насанд хүрээгүй этгээд согтууруулах ундааг худалдаалах түүгээр үйлчлэх цэгүүдэд ажиллах нь хууль зөрчигдөх эрсдлийг нэмэгдүүлэх бөгөөд /тухайлбал, насанд хүрээгүй хүн насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааг худалдаалах/ өөрсдөө согтууруулах ундааг хэрэглэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх юм./

- 3. Архи, согтууруулах ундааг худалдаалах, түүгээр үйлчлэх цагийг хуульчлан тогтоох, ингэхдээ нутгийн захиргааны байгууллага, эсхүл нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хуульд зааснаас гадна цаг, хоног, хугацааны хязгаарыг нэмж тогтоох эрхтэй байхаар хуульчлах;**

Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах цагийн хязгаарыг хуульчлан тогтоосон байсныг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр өөрчилж, нутгийн захиргааны байгууллагуудад тус тусын нутаг дэвсгэр дээр тогтоох бүрэн эрхийг олгосон. Уг бүрэн эрхийг олгоходоо баримтлах ямар нэгэн нийтлэг зарчим, зохицуулалт байхгүй байгаа нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгдмэл тогтолцоотой манай улсад тохирохгүй бөгөөд согтууруулах ундааны хорттой хэрэглээтэй тэмцэх бодлогын нэгдмэл, цогц байдлыг алдагдуулахаар байгааг анхаарах шаардлагатай.

- 4. Нийтийг хамарсан аливаа арга хэмжээний үеэр согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалахыг хориглох;**

/Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад хөгжлийн тоглолт, эсхүл олон нийтийг хамарсан түр хугацааны, эсхүл нэг удаагийн шинжтэй арга хэмжээний үеэр архи, согтууруулах ундааны зүйлээр үйлчлэх, худалдаалах зөвшөөрөл олгох эрхийг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, эсхүл нутгийн захиргааны байгууллагад үлдээсэн байдаг бөгөөд, энэ тохиолдолд зөвшөөрөл олгох шалгуур, хугацааг тодорхой болгож, аль ч үед уг зөвшөөрлийг хэт олноор нь, эсхүл хэт урт хугацаагаар олгохгүй байх талаархи зохицуулалтыг бий болгож, аль болох энэ төрлийн зөвшөөрлийг олгохгүй байх арга хэмжээг авах шаардлагатай байна.

Түүнчлэн энэ төрлийг зөвшөөрлийг залуучууд болон насанд хүрээгүй хүмүүс, гэр бүл, тэдгээрийн хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн олон нийтийн арга хэмжээний үеэр олгохгүй байх, согтууруулах ундааг хэрэглэж болох талбайг, газар, түүний хязгаарыг тогтоож мөрдүүлэх, оролцогч нарын зүгээс олон нийтийн арга хэмжээнд өөрсдөө согтууруулах ундааны зүйлийг авчрахыг хориглох, согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээг нэвтрүүлж, хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үр дүнтэй байдаг талаар судалгаануудад дурдсан байна.

Иймд төрийн зүгээс аливаа олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах зөвшөөрөл олгох зохицуулалтад онцгой анхаарч зохион байгуулагчид тавигдах шаардлагыг тодорхойлж тухайн жилд олгож болох зөвшөөрлийг тоог хязгаарлах арга хэмжээг авахад нь зүйтэй байна./

5. **Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх цэгүүдийн нягтаршлыг бууруулах, тодорхой хүн ам, засаг захиргааны нэгжид ногдох согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх цэгийн тоог хуульчлан тогтоох;**

Уг арга хэмжээтэй холбоотойгоор одоогийн байдлаар нэгэнт олгогдсон тусгай зөвшөөрлүүдийн тоог хэрхэн цөөрүүлэх талаархи буюу шилжилтийн үеийн арга хэмжээний саналыг боловсруулж хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулж тусгах. Жишээлбэл, олгосон зөвшөөрлүүдийн хугацааг сунгахгүй байх, аажмаар аж ахуй эрхлэгчидэд тавигдах шаардлагыг чангатгаснаар согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах цэгийн тоо хэмжээг багасгах бодлого баримтлах, хууль зөрчсөн албан тушаалтнуудад зохих хариуцлага тооцох зэрэг арга хэмжээний саналыг тусгаж болох юм.

/Согтууруулах ундааг олоход хялбар, түүгээр үйлчилдэг, худалдаалдаг цэгүүд нь замбраагүй, олноороо төвлөрсөн байх явдал нь архи, согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлдэг нь гарцаагүй юм. Түүнчлэн эдгээр олон цэгүүд нь хоорондоо үйлчлүүлэгч нараа булаацалдаг, ашиг орлогоороо өрсөлдөх байдал даамжрах бөгөөд үүний үр дүн нь аливаа хууль зөрчсөн үйлдэл, хуулиар хязгаарласан цагуудад үйл ажиллагаа явуулах, хязгаарласан, хориглосон этгээдэд согтууруулах ундааг худалдах, үйлчлэх зэрэг зөрчлүүд түгээмэл болдог байна.

Дэлхийн улс орнуудад хийсэн судалгаагаар согтууруулах ундаагаар үйлчилдэг хэдий олон цэг байх тусам тухайн нутаг дэвсгэрт амьдардаг насанд хүрээгүй иргэдийн согтууруулах ундааны хэрэглээ өндөр байдаг нь тогтоогдсон байна. Мөн энэ төрлийн цэгүүд олноороо, хэт төвлөрсөн хэлбэртэй байх нь тухайн нутаг дэвсгэрийнхээ оршин суугчдад согтууруулах ундааны хэрэглээ бол хэвийн үзэгдэл гэх ойлголтыг төрүүлж байдаг төдийгүй, тухайн нутаг дэвсгэр дэх гэмт хэргийн гаралт, ялагуяа хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлдэг байна.

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад сургууль болон боловсролын байгууллага болон согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүдийн хооронд ямар хэмжээний зайтай байх, ямар хэмжээний газар нутаг, хүн амд хичнээн хэмжээний үйлчилгээ, худалдааны цэг байж болохыг хуульчлан тогтоосон байдаг бөгөөд эдгээр нь харилцан адилгүй байдаг байна.

АНУ-ын дийлэнхи муж улсуудын хувьд эдгээр зай, хэмжээг тогтоох шийдвэр гаргах эрхийг нутгийн захиргааны байгууллагуудад шилжүүлсэн байдаг хэдий ч холбооны бус тогтолцоотой манай улсын хувьд нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдсэн нэг зохицуулалттай байх нь хууль, шударга ёсны зарчимд нийцэх тул хуульчлан тогтоох нь зүйтэй гэж үзэж байна/

Ялангуяа сургууль, боловсролын байгууллагууд болон согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээний цэгүүд хооронд тодорхой хэмжээний зай, хэмжээ тогтоосноороо сургуулийн орчин болон согтууруулах ундааны хэрэглээний орчин 2-ын хоорондоо тусгаарлах орон зайг бий болгож байгаагаараа ач холбогдолтой юм.

Нягтаршлыг бууруулах 3 төрлийн аргыг хэрэглэж болох бөгөөд энэ нь:

- *Согтууруулах ундаа худалдаалах зөвшөөрлийг зөвхөн худалдаа, үйлчилгээний бүсэд олгох /хот, суурин газруудыг тодорхой бүсүүдэд хувааж, эдгээр бүсүүдэд эрхэлж болох үйл ажиллагааг хот суурины тухай хууль тогтоомжоор тогтоосон байдаг/*
- *Тодорхой объектуудыг /эмнэлэг, сургууль гэх мэт/ нэрлэн зааж, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах цэг нь тухайн объектуудаас тодорхой хэмжээний зайтай байх*
- *Согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг цэгүүд хооронд тодорхой хэмжээний зайтай байх зэрэг байна. Үүнээс гадна үйлчилгээний цэгүүдийн төрлөөс хамааран согтууруулах ундааны хатуулгын хэмжээг тодорхой зааж үйлчилж болон төрөл, хэмжээг тодорхой тогтоох*

6. **Насанд хүрээгүй этгээдийг баар, шөнийн цэнгээний газруудаар үйлчлүүлэхийг хориглох, ингэхдээ ресторан болон бусад нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг**

байгууллагуудыг согтууруулах ундаагаар үйлчилдэг баар, шөнийн цэнгээний газруудаас ялгах үндэслэл, журмыг тодорхой тогтоох;

/АНУ-ын дийлэнхи мужуудын хувьд насанд хүрээгүй этгээдийг баар, цэнгээний газруудад нэвтрүүлэхийг хориглодог бөгөөд тэдгээрийн ажилчдад аливаа хүний насыг тогтоох зорилгоор хувийн бичиг баримтыг нь шалгах эрхийг олгосон байдаг байна.

Энэхүү зохицуулалтыг нэвтрүүлэхэд анхаарах гол асуудал нь нийтийн хоолны газруудыг баар, цэнгээний газраас ялгах ялгаа, заагийг тодорхой, нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байдлаар тогтоох явдал юм.

7. Архи, согтууруулах ундааг гэрийн хаягаар, эсхүл шуудан, илгээмжээр хүргэж өгөх болон интернет сүлжээ ашиглан зарж борлуулах үйл ажиллагааг хориглох, энэ төрлийн үйл ажиллагааг таслан зогсоох;

Архи согтууруулах ундааг интернет ашиглан захиалах, гэр орон байранд, эсхүл бусад газарт захиалгаар хүргэх явдал нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг бууруулах, согтууруулах ундааны эргэлтийг нэмэгдүүлэх хүчин зүйл гарцаагүй мөн бөгөөд үүнийг хориглох нь чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, АНУ-д хийсэн судалгаанаас харахад нийт 12 дугаар ангийн сурагчдын 10 хувь нь, 18-20 насны залуучуудын 7 хувь нь согтууруулах ундааг захиалгын дагуу хаягаар хүргэдэг үйлчилгээний тусламжтайгаар олж авч хэрэглэж байсан гэсэн байна. Үүнээс харахад энэ төрлийн үйлчилгээ нь согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх, тэр дундаа насанд хүрээгүй этгээдүүдийн дундах согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх үндэс суурь болдог нь харагдаж байгаа юм.

8. Архи, согтууруулах ундаагаар хариуцлагатай үйлчлэх хөтөлбөрийг бий болгох, согтууруулах ундаагаар үйлчлэх аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүд болон тэдгээрийн ажилчдыг уг хөтөлбөрт заавал хамрагдсан байх шаардлагыг тавих;

/Орегон муж улсад хийгдсэн судалгаагаар энэ төрлийн хөтөлбөрт хамрагдсан бол насанд хүрээгүй этгээдэд согтууруулах ундаагаар үйлчлэх явдал багассан, төдийгүй үйлчлүүлэгчийн хувийн бичиг баримтыг шалгах, согтуурсан хүнд дахин согтууруулах ундааг худалдаалах, борлуулахаас зайлсхийх зэрэг эерэг нөлөөллийг үзүүлэх үр дүнтэй нь тогтоогдсон байна.

Энэхүү хөтөлбөр нь хуулиар бий болсон заавал биелүүлэх шинжтэй байж болох боловч сайн дурын шинжтэй байж мөн болох юм.

Энэхүү хөтөлбөрийн агуулга нь гол төлөв согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн буюу согтуу хүнд үйлчлэх асуудалд чиглэсэн байдаг хэдий ч мөн насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаагаар үйлчлэхээс сэргийлэх асуудлыг мөн багтаадаг байна. Хөтөлбөрийн нь:

- худалдаалж байгаа болон үйлчилж байгаа хүн нь заавал 21 насанд хүрсэн байх;*
- тэдгээрт хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх шийтгэл, хариуцлагын талаар сануулж, ойлгуулж таниулсан байх;*
- баар, цэнгээний газруудаар үйлчлүүлэх, тэдгээрээс үйлчилгээ авахын өмнө хувийн бичиг баримтыг заавал шалгах;*
- үйлчлүүлэгчийг 30-аас доош настай гэж үзсэн тохиолдолд хувийн бичиг баримтыг заавал шалгах;*
- хувийн бичиг баримт гэж юуг хэлэх, ямар бичиг баримтуудаар хүний насыг тогтоож болох;*
- согтууруулах ундаагаар үйлчлэх дүрэм, журам, стандартыг таниулах*
- согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглосон этгээдийг хэрхэн яаж таних зэрэг агуулгатай байдаг байна.*

Энэ төрлийн хөтөлбөр нь 1980-аад оны сүүл үеээс Хойд Америкаас эхлэлтэй бөгөөд энэ нь архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх буюу үйлчлүүлэгчийг хүнд хэлбэрийн согтолтоос урьдчилан сэргийлэх, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн үйлчлүүлэгчид дахин согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх үндсэн зорилготой.

Дэлхийн улс орнуудын жишгээс харахад энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүргийг төрийн бус байгууллагуудад олгож болох бөгөөд заавал төрийн байгууллагад нэмэлт чиг үүрэг, орон тоо нэмэгдүүлэх шаардлагагүй бөгөөд хөтөлбөрийн хугацаа нь дийлэнхи тохиолдолд зорилтот бүлгээс хамааран 2-4 цагийн хугацаатай байдаг байна.

Жишээлбэл, Австрали улсад энэхүү хөтөлбөр нь хамрагдах шаардлагатай зорилтот бүлгээс хамааран дараахь байдлаар 3 түвшинтэй байдаг бөгөөд сонирхогч этгээд аль тохирох түвшинээ сонгон хамрагдах боломжтой байдаг байна.

Түвшин 1 – Нэг удаагийн шинжтэй буюу тогтмол бус тусгай арга хэмжээнд үйлчлэх

Согтууруулах ундаагаар түр хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, тухайлбал, фестиваль, концерт, тэмцээн уралдаан зэргийн үеэр нэг өдөр, эсхүл тодорхой хугацаанд согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл авсан тохиолдолд согтууруулах ундаагаар үйлчлэх үйлчлэгч нарт зориулсан сургалт байх бөгөөд ердийн байдлаар сургалтыг 1-2 цагийн хугацаанд яуулна.

Түвшин 2 - Мэргэжлийн үйлчлэгч

Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид ажилладаг, үйлчлүүлэгч нартай тогтмол харилцаж үйлчилгээ үзүүлдэг үндсэн ажилтнуудад /хагас болон бүтэн цагаар ажилладаг зөөгч, үйлчлэгч, бармен/ зориулсан сургалтыг 1 дэх хэсэгт зааснаас өөр агуулгаар зохион байгуулах бөгөөд сургалтын хугацаа нь 3-4 цаг байдаг байна.

Түвшин 3- Зохион байгуулагч, менежер

Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид зохион байгуулагч, менежер буюу аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа, үйлчлэгч нарын ажилд хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтнуудад зориулсан сургалт 4 цагийн хугацаатай байх бөгөөд мөн агуулгын хувьд гүйцэтгэх чиг үүргээс нь хамааран харилцан адилгүй байна.

9. Архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол шалгадаг механизмыг бий болгох;

/Архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол шалгах нь хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах маш чухал хэрэгсэл бөгөөд энэхүү шалгах, хууль сахиулах ажиллагаа нь:

- Худалдаа, үйлчилгээ эрхлэгчидэд хууль тогтоомжийг таниулан сурталчилах, хууль тогтоомжийн зорилго, агуулга, журам, хүрэх үр дүнг тайлбарлан хүргэх
- Хэрэгжилтийг нь газар дээр нь хянаж шалгахын өмнө тухайн шалгуулагч этгээдэд хууль тогтоомжийг биелүүлэх, хэрэгжүүлэх хангалттай боломж, нөхцөлийг олгох
- Хууль тогтоомжийг зорилго, агуулгыг таниулах олон нийтэд чиглэсэн мэдээллийг тараах, таниулах зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх
- Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг санамсаргүй байдлаар, эсхүл гомдол, мэдээллийн дагуу сонгох байдлаар шалгах, шалгалтын үр дүнгийн талаар олон нийтэд нээлттэй мэдээллэх
- Худалдаа, үйлчилгээ эрхлэгчидэд хяналт, шалгалтын үйл ажиллагааны талаар тогтмол мэдээллэх зэргээс бүрдэх нь уг үйл ажиллагааг илүү ач холбогдолтой болгодог гэж үзсэн байна./

10. Архи, согтууруулах ундааны эргэлттэй холбоотой зөрчил, хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд тохирох шийтгэлийг оногдуулах, хуулийн хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэх;

Хариуцлагыг захиргааны, эрүүгийн болон иргэний гэж 3 ангилан тогтоож болох бөгөөд захиргааны хариуцлагын хувьд согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийн зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх гэх зэрэг арга хэмжээнээс бүрддэг бөгөөд энэ нь согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах үйл ажиллагааны явцад хууль тогтоомжийг чанд сахин биелүүлдэг дадал, зуршлыг бий болгох зорилготой юм. Эрүүгийн хариуцлагын хувьд торгох, эрх чөлөөг нь хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх гэх зэрэг төрөлтэй байж болох юм. Харин иргэний хариуцлагын хувьд төрийн албадлагын арга хэмжээний нэг хэлбэр биш боловч хууль тогтоомж зөрчиж согтууруулах ундаагаар үйлчилсэн, худалдаасан тохиолдолд түүнийг хэрэглэн хууль бус үйлдэл гаргасны улмаас гуравдагч этгээдэд үүссэн гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээлгэх гэх зэргээр тогтоож болох юм.

Жишээлбэл, АНУ-ын бүх муж улсууд насанд хүрээгүй хүнд архи, согтууруулах ундаа худалдаалсан, түүгээр үйлчсэн тохиолдолд захиргааны болон эрүүгийн хариуцлагыг давхар оногдуулах хуультай байдаг байна.

Харин АНУ, Австрали, Канад зэрэг улсуудад хэрвээ согтууруулах ундаа худалдаалдаг, түүгээр үйлчилдэг этгээд хууль тогтоомж зөрчиж согтуу хүнд, эсхүл насанд хүрээгүй этгээдэд согтууруулах ундаа худалдаалсан, түүгээр үйлчилсэн бөгөөд тухайн этгээд бусдад гэм хор учруулсан тохиолдолд тухай гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээдэг байна. Иргэний хариуцлагын нэг хэлбэрийг бий болгосон энэхүү зохицуулалтын үр дүнд аливаа аж ахуй эрхлэгч бусдад архи, согтууруулах ундааг худалдан борлуулах үедээ илүү хариуцлагатай байх бөгөөд өөрөө хариуцлага хүлээлэхгүйн тулд хуулийг чанд сахин биелүүлэх хөшүүрэг болж өгдөг байна.

11. Архи, согтууруулах ундаанд ногдуулах татварын хэмжээг оновчтой зөв тогтоож, согтууруулах ундааны үнийг хянах замаар согтууруулах ундааны эрэлтийг бууруулах;

12. Насанд хүрэгчдийн зүгээс архи, согтууруулах ундааг насанд хүрээгүй этгээдэд хэрэглэх боломж олгох, түүгээр үйлчлэх, дайлах, бэлэглэх, санал болгох аливаа үйлдлийг хориглох, энэ төрлийн зөрчилд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэх;

АНУ-ын бүхий л муж улсууд насанд хүрээгүй хүн арилжааны бус аргаар /дайлах, бэлэглэх гэх мэт/ согтууруулах ундааг олж авах, хэрэглэх боломжийг хязгаарласан хуультай байна.

13. Насанд хүрээгүй этгээдүүд олноороо цугларсан олон нийтийн арга хэмжээ, гэрийн үдэшлэг зэргийг хориглох, энэ тохиолдолд архи, согтууруулах ундааг хэрэглэх боломж олгосон гэж үзэж тухайн орон байр, барилга байгууламжийн эзэмшигч, өмчлөгчид хариуцлага хүлээлгэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

/Насанд хүрээгүй хүмүүсийн зохион байгуулж буй, эсхүл тэдгээрт зориулсан үдэшлэг, цэнгүүн нь согтууруулах ундааг олж авах, түүнийг хэрэглэх нөхцөл боломжийг бүрдүүлдэг ба эдгээр нь ихэвчлэн насанд хүрэгчдийн хараа хяналтгүйгээр, зөвхөн насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохион байгуулагддаг. /

14. Гудамж талбай, парк, цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн бусад газруудад архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, нийтэд ил тод, нээлттэй барьж явах, лац, ломбо, баглаа, боодлыг нь хөндсөн байдалтай авч явахыг хориглох, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэх;

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд архи, согтууруулах ундааны зүйлийг хэрэглэхийг хориглосон газрын цар хүрээг боломжийн хэмжээнд харьцангуй өргөн хүрээтэй тогтоож өгсөн хэдий ч хориглосон үйлдэл нь **“хэрэглэх,**

худалдах, үйлчлэх” гэсэн нь хууль сахиулах чиг үүрэг бүхий алба хаагч нарт хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа юм. Учир нь худалдан борлуулах, хэрэглэх сонирхол бүхий этгээд, эсхүл бүр хэрэглэж байгаа этгээд тухайн хориглосон газруудад баглаа, лац, ломбыг нь онгойлгосон байдалтай авч яваа тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжгүй, “заавал ууж байгаа” буюу хэрэглэж байгааг нь “харсан, тогтоосон” байхыг шаардаж байгаа юм. Иймд дээрхи хориглосон газруудад **нийтэд ил тод, нээлттэй барьж явах, лац, ломбо, баглаа, боодлыг нь хөндсөн байдалтай авч яваа тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг байх нь тодорхой үр дүнтэй арга хэмжээ болно.**

15. Хуульд заасан согтууруулах ундаа хэрэглэх, худалдан авах насанд хүрээгүй хүмүүсийн хувьд цусан дахь согтууруулах ундааны ямар ч хэмжээг хүлээн зөвшөөрөхгүй байх тухай, ямар ч хэмжээний согтууруулах ундаа илэрсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

16. Архи, согтууруулах ундаа худалдан авах зорилгоор хуурамч бичиг баримт үйлдсэн, хуурамч бичиг баримт ашигласан, ашиглахаар завдсан, эсхүл бусдын бичиг баримтыг ашигласан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг бий болгох;

ΙΑНУ-ын 50 муж улсад энэ төрлийн үйлдлийг хориглосон хуультай боловч зөвхөн 6 муж улсад нь энэ төрлийн зөрчил үйлдсэн тохиолдолд жолоодох эрхийг хүчингүй болгох шийтгэх оногдуулах хариуцлагыг тогтоосон байна!

17. Архи, согтууруулах ундааны эргэлттэй холбоотой зөрчил гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх үндэслэл, журмыг хуульчлан тогтоож, чандлан мөрдүүлэх;

18. Архи, согтууруулах ундааг үнэгүй тараах, дээж, загвар хэлбэрээр бусдыг дайлах, амталгаа хийлгэх зэргийг хориглох;

19. Согтууруулах ундаагаар үйлчилдэг болон худалдаалдаг газруудад зориулсан гарын авлага, сургалтын материалыг бэлтгэж, тараах;

20. Архи, согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх цэгүүдэд тавигдах шаардлага, төлөх тусгай зөвшөөрлийн төлбөр, хураамжийг нэмэгдүүлэх;

21. Архи согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хэрэглээг бууруулах үйл ажиллагааг идэвхитэй, үр дүнтэй болгох зорилгоор уг үйл ажиллагаан дахь төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, олон нийтийн байгууллага, бүх шатны боловсролын байгууллагууд, иргэдийн үүрэг, оролцоог тодорхой болгох;

22. Австрали болон Канад улсын судлаачдын хийсэн судалгаанаас харахад согтууруулах ундаагаар үйлчилдэг цэг болон түүний ойр орчин дахь хүчирхийлэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаархи санал нь нилээн сонирхол татаж байсан бөгөөд манай улсын хувьд согтууруу үйлдэгддэг гэмт хэрэг, ялангуяа бусдын эрүүл мэндэд янз бүрийн хэмжээний гэмтэл учруулах, танхайрах зэрэг гэмт хэрэг, зөрчлүүд түгээмэл гардаг тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор:

- Согтууруулах ундаагаар хариуцлагатай үйлчлэх сургалтад баар, цэнгээний газруудын зохион байгуулагч, бусад ажилчдыг /бармен, үйлчлэгч, зөөгч/ хамруулах
- Хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх сургалтыг баар, цэнгээний газруудын зохион байгуулагч, хамгаалалтын ажилтнуудын дунд зохион байгуулах

- Насанд хүрээгүй хүмүүст согтууруулах ундаагаар үйлчлэх боломжийг хязгаарлах;
- Согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүдэд халуун, хүйтэн зууш, хоолоор үйлчилдэг байх шаардлага зүй ёсоор тавигдах бөгөөд энэ нь согтолтыг бууруулах, согтолтоос үүссэн хүний эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөлийг бууруулах ач холбогдолтой байдаг байна.

/Австрали улсад хийгдсэн судалгаагаар согтууруулах ундааг хоолтой хамт хэрэглэх нь хоолгүй хэрэглэснээс 60 хувиар илүү согтолтын зэргийг бууруулах үр нөлөөтэй бөгөөд Австралийн зарим нутаг дэвсгэрүүдэд согтууруулах ундааг хоолтой хамт захиалсан буюу хоол идэж байгаа үйлчлүүлэгчидэд худалддаг байх зохицуулалтыг дагаж мөрддөг байна.

Ердийн нэгэн жишээ дурдахад, Австрали Улсын зарим баар, цэнгээний газрууд үйлчлүүлэгч нарын орох, гарах хөдөлгөөнийг хянах буюу өөрөөр хэлбэл, гудамжинд нэг зэрэг олон тооны согтуу хүмүүсийг байлгахгүй байх тал дээр анхаарч зохих арга хэмжээг авдаг бөгөөд энэ нь баар, цэнгээний газруудын хувьд нэг гарсан тохиолдолд буцааж оруулахгүй байх, эсхүл гарсаны дараа тодорхой хугацаа өнгөрсөн тохиолдолд буцаан оруулахгүй байх зэрэг арга хэмжээгээр илэрхийлэгдэж болох бөгөөд дэлхийн олон улс орнуудад хэрэглэгдэж, үр нөлөөтэй гэдэг нь нотлогдсон арга хэмжээ гэж үзсэн байна.

23. Боловсролын байгууллагууд, ялангуяа дээд боловсролын болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн боловсролын байгууллагууд оюутан, сурагчдад архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, сургуулийн ойр орчин болон сургууль доторхи согтууруулах ундааны хэрэглээний талаархи дүрэм, журмыг таниулах;

24. Шатахуун түгээс станцуудын дэргэдэх худалдаа эрхэлдэг цэгүүдэд архи, согтууруулах ундааны зүйл худалдаалахыг хориглох;

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн зарим улс, орнууд согтууруулах ундааны хэрэглээг багасгах, тэр дундаа жолооч нарыг согтууруулах ундааны хор хөнөөлөөс сэргийлэх зорилгоор шатахуун түгээх станцуудад согтууруулах ундаа худалдаалахыг хориглож эхэлсэн ба энэхүү зохицуулалт нь 2008-2012 оны хооронд эрчимтэй нэвтэрсэн байна.

Одоогийн байдлаар шар айрагны худалдааны талаар 37 хувь буюу 61 улсад энэ төрлийн хориглолт үйлчилдэг бөгөөд энэ үзүүлэлт 2008 онд 31 хувь буюу 46 улс байсан байна. Дарсыг 64 улс, архины төрлийн согтууруулах ундааг 65 улсад шатахуун түгээх станцын орчим худалдаалахыг хориглосон байна.

25. АНУ-ын зарим муж улсуудын жишгээр хэрэв жолооч архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ авто тээврийн осол гаргасан бол даатгагчийн зүгээс ямар нэгэн нөхөн төлбөр олгохгүй байх зохицуулалтыг тусгах боломжтой эсэхийг судлах;

26. Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг болон худалдаалдаг газрууд болон жирэмсэн эмэгтэйчүүд үйлчлүүлдэг эмнэлгийн байгууллагуудад жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх архины хор хөнөөлийн талаар анхааруулсан тэмдэглэгээг байршуулах;

27. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах болон хамаарахгүй харилцааг хуульд тодорхой тусгах. Тухайлбал, ОХУ-ын жишгээр хувь хүмүүсийн үндэсний уламжлалт аргаар, ашиг олох зорилгогүйгээр, хувийн болон гэр бүлийн хэрэгцээнд ашиглахаар үйлдвэрлэж байгаа этилийн спирт агуулсан бүтээгдэхүүнийг хуулийн үйлчлэлд хамаарахгүй байхаар тусгах;

28. Архи, согтууруулах ундаа маркетингийн үйл ажиллагаанд хяналт тавих;

Архи, согтууруулах ундааны маркетингийн үйл ажиллагаан дахь хязгаарлалт нь шууд болон шууд бус зар сурталчилгаа, зар сурталчилгааны агуулга, аливаа арга хэмжээ, үйл

ажиллагааг ивээн тэтгэх, залуу үеийхэнд чиглэсэн сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа болон шинэ төрлийн маркетингийн үйл ажиллагааг зэргийг хамаардаг байна.

Түүнчлэн аж ахуй эрхлэгч нарын архи, согтууруулах ундааны зүйлд төрөл бүрийн хямдрал, урамшуулал зарлах, үнэгүй согтууруулах ундааны зүйлээр үйлчлэх гэх мэт үйл ажиллагааг хориглодох нь үр дүнтэй алхам болдог байна.

Зар сурталчилгаанаас гадна дэлхийн зарим улс орнууд телевизийн нэвтрүүлэг болон спортын тэмцээн уралдааны үед согтууруулах ундааны маркетингийн үйл ажиллагааг, согтууруулах ундааны реклам, сурталчилгааг байршуулахыг хориглох хэлбэрээр хязгаарладаг байна.

29. Согтууруулах ундааны спиртын агууламжаас шалтгаалан татварыг ялгамжтай ногдуулах, ногдуулах татварын хэмжээг зохистой тогтоох, үүнтэй зэрэгцүүлэн хуулийг зохистой хэмжээнд хэрэгжүүлдэг механизмыг бүрдүүлэх;

30. Согтууруулах ундаа сав, баглаа, боодол дээр төрөл бүрийн анхааруулга, сэрэмжлүүлэг байршуулах;

Нийт 116 улс архи, согтууруулах ундааны сав, баглаа, боодол дээр хатуулгын хэмжээний талаар мэдээллийг байршуулахыг шаардсан зохицуулалттай бөгөөд харин согтууруулах ундааны сурталчилгааны материал дээр согтууруулах ундааг хэтрүүлсэн хэрэглэсний улмаас үүсэх хор хөнөөлийн талаархи сэрэмжлүүлгийг байршуулах шаардлагыг зөвхөн 41 улсад тавьдаг бол 31 улсад согтууруулах ундааны сав боглоо боодол дээр энэ төрлийн сэрэмжлүүлэг, анхааруулгыг байршуулахыг шаарддаг байна.

31. Согтууруулах ундаа сав, баглаа, боодлын стандартыг боловсронгуй болгох, төрөл бүрийн анхааруулга, сэрэмжлүүлэг байршуулах, согтууруулах ундааны сурталчилгааны материал дээр согтууруулах ундааг хэтрүүлсэн хэрэглэсний улмаас үүсэх хор хөнөөлийн талаархи сэрэмжлүүлгийг байршуулах;

32. Согтууруулах ундааны хэрэглээг бууруулах зорилгоор савлагааны хэмжээн дээр анхаарах, тухайбал, 100 грамм, 50 граммаар савалсан буюу жижгээр савалсан согтууруулах ундааг нэг удаагийн хэрэглээгээ хангах зорилгоор хямд, хялбар аргаар худалдан авах боломжийг хаах;

33. Хатуулаг өндөртэй согтууруулах ундааны хувьд 1 литр, эсхүл түүнээс савалгааг хориглох, хатуулах багатай буюу шар айрагны төрлийн согтууруулах ундааг 2 литрээс дээш хэмжээгээр савлахыг хориглох, баар, цэнгээний газруудад шар айргийг 0,33 литрийн савалгаатайгаар худалдан боруулдаг байх, тэдгээрийн үйлчилгээнд хэрэглэх хундага, бусад хэрэгслийн стандартыг тогтоож мөрдүүлэх зэрэг хэрэглээг багасгах талын арга хэмжээний талаар хуульд тусгах;

34. Согтууруулах ундаагаар үйлчлэх болон худалдах эрх бүхий этгээд нь зөвхөн согтууруулах ундааг худалдан авахыг нь хуулиар хориглоогүй этгээдэд үйлчлэх үүрэгтэй тул худалдан авагч, үйлчлүүлэгчийн хууль ёсны бичиг баримтыг заавал шалгадаг байх, шалгаагүй, эсхүл зохих ёсоор шалгаагүйн улмаас үүсэх хариуцлагыг өөрөө хүлээдэг байх, ямар төрлийн бичиг баримтуудыг хууль ёсны гэж тооцох зэрэг зохицуулалтыг хуульд тусгах;

35. Согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэлтэй тэмцэх, хууль бусаар үйлдвэрлэсэн согтууруулах ундааг олж илрүүлэх, устгах талаархи зохицуулалтыг боловсронгуй болгож хуульд тусгах;

36. Согтууруулах ундааны тодорхойлолтыг боловсронгуй болгож, уг тодорхойлолт нь ойлгомжтой, нэг мөр ойлгогдохуйц байх боломжийг хангах;

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн 106 орон энэ төрлийн тодорхойлолтыг хууль тогтоомжиндоо тусгаснаас 45 нь согтууруулах ундааг 0-1 хувь спирт агуулсан бүтээгдэхүүнийг, 1 орон буюу Беларусь улс согтууруулах ундаа гэж 7 хувиас дээш хэмжээний спирт агуулсан бүтээгдэхүүнийг ойлгохоор тодорхойлсон байна. Бусад улс орнуудын хувьд 0.8 хувиас 1.3 хувийн спирт агуулсан бүтээгдэхүүнийг согтууруулах ундаанд тооцохоор харилцан адилгүй зохицуулалттай байна.

37. Согтууруулах ундааны хэрэглээ, түүний хор хөнөөлийг судлах үндэсний хэмжээний мониторинг, хяналтын механизмыг бий болгох;

Судалгаанд оролцсон улс орнуудас 71 нь согтууруулах ундааны хэрэглээ, түүний хор хөнөөлийг судлах үндэсний хэмжээний мониторинг, хяналтын механизмтай гэсэн бөгөөд үүнээс 55 улс нь согтууруулах ундааны хэрэглээний талаархи мэдээллийг цуглуулдаг, 54 улс нь хэрэглээнээс үүсэх үр дагаврын талаар мэдээлэл цуглуулдаг гэсэн бол маш бага буюу 25 улс нь нийгмийн үр дагаврыг, 11 улс нь бодлогын хэмжээний хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийг цуглуулдаг гэсэн байна.

-

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан.

Дээрхи тогтоолын 3 дахь хэсэгт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газар, холбогдох байнгын хороодод даалгажээ. Тогтоолын хавсралтын 133 дахь хэсэгт зааснаар 2017 онд багтаан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хариуцан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгажээ. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлагад “Архи импортлох тусгай зөвшөөрөл олгох журам батлах эрх олгох, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж заасан.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх харилцааг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу зохицуулах бөгөөд мөн хуульд заасны дагуу хууль тогтоомжийн төслийг Засгийн газраас баталсан аргачлалуудын дагуу зохих тандан судалгаа, эсхүл үнэлгээг хийсний үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинэчлэн найруулах эсэхийг шийдвэрлэхээр заасан.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Монгол Улсын Засгийн газраас Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтад заасны дагуу 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.2 дахь заалтад заасны дагуу “хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох” зорилгод үндэслэн хийсэн болно.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Энэхүү үнэлгээ хийх ажлын зорилт нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Хууль тогтоомжийн тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуульд 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг шинээр нэмж, тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалууд хамаарахгүй байх нийт 24 тохиолдлыг тоочин заасан. Мөн аргачлалын 1.3 дахь хэсэгт энэхүү аргачлал хамаарахгүй буюу аргачлалын дагуу үнэлгээ хийх шаардлагагүй 5 тохиолдлыг тоочин заасан бөгөөд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нь дээрхи тохиолдлуудыг алинд ч хамаарахгүй байх тул аргачлалын дараагийн хэсгүүдэд заасны дагуу үнэлгээг үргэлжлүүлэн гүйцэтгэлээ.

--оОо--

ХОЁР. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЕ ШАТ

Аргачлалын 2.1 дэх хэсэгт заасны дагуу үнэлгээ хийх ажиллагаа нь 3 үе шаттай байна:

- 1.төлөвлөх;
- 2.хэрэгжүүлэх;
- 3.үнэлэх.

Мөн аргачлалын 3.1 дэх хэсэгт заасны дагуу дээр заасан төлөвлөх үе шатанд:

- 1.үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 2.үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- 3.шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- 4.харьцуулах хэлбэрийг сонгох;
- 5.шалгуур үзүүлэлтийг томьёолох;

6.мэдээлэл цуглуулах аргыг сонгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэсний дагуу дээр дурьдсан арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн болно.

2.1.ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛТГААНЫГ ТОДОРХОЙЛОХ

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон уг хуулийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлохыг зорилоо.

Шалтгаан 1

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарах, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалтуудтай байсан байна. Энэ нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй байсан тул Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай 151 дугаартай тогтоолыг Монгол Улсын Дээд шүүхээс 2000 онд гаргасан байна.

Энэхүү тогтоолоор Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх нөхцөлийг хангах зорилготой бөгөөд 5 хэсэгтэй байна. Уг тогтоолоор Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн "...2 хувиас дээш этилийн спирт агуулсан дарс", 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн "Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж уул зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно", 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсгийн "зориудаар тохижуулсан", 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн "Согтууруулах ундаа худалдах, борлуулах, хэрэглэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийхийг хориглоно", 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн "Ууж согтууран өөрийнхөө үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон этгээд" гэдгийг тус тус тайлбарласан байна.

Цаашид Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож, зохицуулалтын утга, агуулга, хуульд хэрэглэсэн нэр томьёог тодорхой, ойлгомжтой тодорхойлох шаардлагатай бөгөөд хуулийг хууль тогтоох дээд байгууллагаас тогтоосноор бус харин эрх зүйн хувьд эх сурвалж болох эсэх нь маргаантай Улсын Дээд шүүхийн тайлбараар хуулийг тайлбарлаж, ойлгож хэрэглэх нь цаашид уг хуулиар зохицуулсан харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх эрслэлтэй гэж үзэж байна.

Шалтгаан 2

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гаргасан судалгаагаар олон улсын түвшинд нэг хүнд ногдох согтууруулах ундааг архинд шилжүүлсэн дүнгээр 6.2 литр байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь 8-9 литрт хүрсэн бол тухайн улс, үндэстэн аюулд учирсан гэж үздэг байна. Манай улсын улсын насанд хүрсэн /18-с дээш насны/ нэг хүнд ноогдож байгаа бүх төрлийн согтууруулах ундааг 38 хувийн хатуулаг бүхий архи, согтууруулах ундааны зүйлд шилжүүлэн үйлдвэрлэсэн болон импортолсон согтууруулах ундаанаас экспортолсон хэмжээг нь хасаж тооцоход нэг хүнд ногдох архины хэрэглээ 2002 онд 9,03 литр байсан бол 2011 онд 10.6 литр, 2012 онд 10.8 литр, 2013 онд 8.9 литр, 2014 онд 8.4 литр гэсэн тоон мэдээ байна.

Өөрөөр хэлбэл манай улс 15 ба түүнээс дээш насны нэг хүнд ноогдох согтууруулах ундааны хэмжээгээрээ судалгаанд хамрагдсан 182 орны 76-д жагссан байгааг согтууруулах ундааны хэрэглээ, үйлчигээний зөв дадал, энэ чиглэлийн хууль, эрх зүйн орчны боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Дээрхи тоон үзүүлэлтээс харахад Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдаж, өнөөг хүртэл 17 жил гаруй хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөхдөө нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан хэдий ч нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэмжээ тогтмол өссөн үзүүлэлттэй, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо тогтмол өсч байгаагаас харахад Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зохицуулалт нь:

- бодит байдалтай нийцээгүй,
- нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон,
- зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй,
- эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон гэх үндэслэлтэй байна.

Шалтгаан 3

Зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд 2014 оны байдлаар 3600 гаруй аж ахуйн нэгж архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэг буюу Улаанбаатар хотын 270-280 иргэн тутамд нэг архи, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг байдаг гэсэн судалгааг гаргаж байжээ. Харин улсын хэмжээнд 2016 оны байдлаар спиртийн 9, архины 46, шар айрагны 19, дарсны 10 үйлдвэр байна.

Цагдаагийн байгууллагын зүгээс Цагдаагийн албаны тухай хуульд заасан нийтийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргийн хүрээнд болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт зааснаар согтууруулах ундаа худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэх талаар тогтоосон журмын биелэлтэд хууль, хууль тогтоомжийн бусад актаар олгосон эрх хэмжээний дотор хяналт тавих үндсэн чиг үүргийн хүрээнд хяналт тавин ажилладаг.

Түүнчлэн Монгол Улсад 2016 онд 27167 гэмт хэрэг бүртгэгдсэнээс⁴⁴ 5520 буюу 20.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна. Өөрөөр хэлбэл архидан согтуурах нь гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан нөхцөлийн нэг хэвээр байгааг дээрх тоо статистик харуулж байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэг, зөрчлийн хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд болон эргүүл, хяналтын хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээний үед удаа дараа насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдан борлуулсан, тогтоосон цагийн хязгаарлалтыг хэтрүүлж ажилласан, гэмт хэрэг, зөрчил байнга гардаг аж ахуйн нэгжүүдийн талаархи мэдээллийг тусгай зөвшөөрөл олгох, цуцлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тогтмол хүргүүлдэг хэдий ч эдгээр асуудлууд нь тухай бүр хуулийн дагуу шийдэгддэггүй, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцалсан хэдий ч дахин өөр нэрээр тусгай зөвшөөрөл, үйл ажиллагаа явуулах эрх тухайн объектод, урьд өмнөх тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгодог зэрэг нийтлэг дутагдлууд илэрч байна.

Түүнчлэн Мэргэжлийн хяналтын байгууллагаас архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, гол төлөв үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийж эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцээгүй, зориулалтын тоног төхөөрөмж, бэлтгэгдсэн боловсон хүчингүй ажилладаг, эсхүл зориулалтын байр савгүй, тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь эрүүл мэндэд хортой нөлөө бүхий үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлдэг боловч, Засгийн газраас энэ төрлийн зөвшөөрлийг олгох, цуцлах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг тул тэр бүр мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийн дагуу асуудал шийдэгддэггүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй хэмжээнд байсаар байна.

⁴⁴ Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээ

Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, үндэсний стандартын хэрэгжилтэд МХЕГ, ХХААХҮЯ хамтран хяналт шалгалт хийж, шалгалтад улсын хэмжээнд нийт 71 аж ахуй нэгжийн 83 согтууруулах ундааны үйлдвэрүүд хамрагдсанаас 44 буюу 53 хувь нь нийслэлд, 39 буюу 47 хувь нь орон нутагт бүртгэлтэй байгаагаас 48 буюу 57 хувь нь үйл ажиллагаа нь зогссон байдалтай байсан байна. Тус шалгалтад хамрагдсан нийт 83 согтууруулах ундааны үйлдвэрээс үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа, эрсдэлийн үнэлгээ хийгдсэн 35 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг хэвээр үлдээхээр, согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх гэрчилгээний хугацааг зохих журмын дагуу сунгуулаагүй, тусгай зөвшөөрлөө сунгуулах тухай хүсэлтээ гаргаагүй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогссон, хуулийн этгээд татан буугдсан, үйлдвэрийн байргүй болсон, тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулах тухай хүсэлтээ гаргасан, түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаагүй 28 үйлдвэрийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 11 ААН-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай саналыг МХЕГ-аас ХХААХҮЯ-нд хүргүүлсэн байна. Гэсэн хэдий боловч одоогийн байдлаар эдгээр аж ахуйн нэгжүүдийн талаар ямар арга хэмжээ авсан, мэргэжлийн байгууллагын тавьсан саналын дагуу ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь тодорхойгүй хэвээр байсаар байна.

Дээр дурдсанаас үзэхэд Цагдаагийн байгууллага болон Мэргэжлийн хяналтын байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж шаардлагатай арга хэмжээг авах, цаашилбал Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндсэн чиг үүрэг болох ард иргэдийн амгалан тайван байдал, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хамгаалаг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж байна.

Шалтгаан 4, 5

Судалгаагаар сурагч-өсвөр үеийнхний 29.1 хувь нь согтууруулах ундаа хэрэглэж үзсэн, 12.9 хувь нь согттол хэрэглэж үзсэн төдийгүй тэдний эцэг эхчүүдийн 39.8 хувь нь архи, согтууруулах ундаа хэрэглэдэг, оюутан залуучуудын 38.8 хувь нь хэтрүүлэн хэрэглэдэг, 70.6 хувь нь баар, диско клубт хэрэглэдэг, оюутнуудын сургууль, амьдарч байгаа орчноос 100 метр хүрэхгүй газар яваад архи, согтууруулах ундаа авч болдог гэжээ. Үүнээс гадна архины хэрэглээний талаарх хандлагыг тодорхойлох судалгаанаас харахад 15-24 насны хүүхэд залуучуудын 15-24 насны хүүхэд залуучуудын 56.5 хувь нь сүүлийн 1 сарын хугацаанд архи согтууруулах ундаа хэрэглэсэн гэж хариулж, 40.0 хувь нь монголчууд архи, согтууруулах ундааг нэг дор их хэмжээгээр уудаг гэдэгтэй санал бүрэн нийлж, 52.0% нь санал нийлж байна гэжээ. Энэхүү хандлага эрэгтэй, эмэгтэй, аль ч насны хүмүүст ижил байгаа нь ерөнхийдөө ихэнх хүмүүс Монголчууд архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэдэг дадалтайг хүлээн зөвшөөрч байгаа нь илэрхий байна.

Эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар шар айраг хэрэглэж буй хэрэглэгчдийн 80 орчим хувь 15-25 насны залуучууд болох нь харагдаж байгаа ба нийт хүн амын ихэнх хувийг залуучууд эзэлдэг манай орны хувьд энэ асуудалд онцгой анхаарал хандуулж зохих арга хэмжээ авах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Иймд уг асуудал бүх нийтээрээ анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас үүсэх эрсдлийг бууруулах ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах үүднээс Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл уг хуулийг шинэчлэн найруулах арга хэмжээ үе, үеийн Засгийн газар, Улс төрийн нам, Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагддаг боловч өнөөг хүртэл бодит биелэлээ олоогүй байна. Үүний зэрэгцээгээр Улсын Их Хурлын гишүүдээс уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, санаачлагыг тогтмол гаргадаг хэдий ч үзэл баримтлалын шинжтэй, нийгэмд үүсээд буй өнөөгийн нөхцөл байдалд дорвитой хариу үзүүлж чадахуйц зүйл байхгүй байна. Төрийн бус байгууллагуудын зүгээс ч энэхүү хуулийг өөрчлөх хэрэгцээ, шаардлагын талаар тогтмол ярьж, хэлэлцүүлгийг өрнүүлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 2 дахь заалтад зааснаар Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах,... эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гэж, Хүний

эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах, ...эрхтэй” гэж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 33 дугаар зүйлд “Оролцогч улсууд олон улсын холбогдох гэрээнүүдэд тодорхойлсон мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодисыг хууль бусаар хэрэглэх явдлаас хүүхдийг хамгаалах, эдгээр бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулахад хүүхдийг ашиглахаас сэргийлэх үүднээс хууль тогтоох, захиргаа, нийгэм, боловсролын болон шаардлагатай бусад бүх арга хэмжээг авна.” гэж тус тус заасан хэдий ч төрөөс дээр дурдсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаархи үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байна гэж үзэхээр байна.

Түүнчлэн хуулийн хэрэгжилтийн бодит байдал, архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэн гарч буй сөрөг үзэгдэл, тэдгээрийн цаашид нэмэгдэх чиг хандлага нь нийгмийн бүлэг, төрийн болон төрийн бус байгууллагууд хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор түүнийг өөрчлөх, шинэчлэх үндэслэл бүхий саналууд гаргасаар байна.

2.2.ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх үаалтын дагуу үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо хуулийг бүхэлд нь, эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Гэвч хуулийн зохицуулалтыг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал нь хэт өндөр гардаг бөгөөд зөвхөн энэхүү хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатайг харгалзан үзэж дараахь үнэлгээний хүрээг сонголоо.

Үнэлгээний хүрээ 1

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг:

“Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгоно.

Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хяналт тавих чиг үүргийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.”

Үнэлгээний хүрээ 2

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

“Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.”

Үнэлгээний хүрээ 3

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:

“Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг шугамын оролт, гаралтыг тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжөөр, технологийн горим, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд батлагдсан стандартын дагуу явуулна.”

Үнэлгээний хүрээ 4

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:

“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”

Үнэлгээний хүрээ 5

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:

“Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.”

Үнэлгээний хүрээ 6

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалт:

“21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй газарт хориглоно.”

Үнэлгээний хүрээ 7

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2. дахь заалт:

“Архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг Согтуурах, мансуурах донтой өвчтэй хүмүүсийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулиар зохицуулна.”

Дээр заасан үнэлгээний хүрээг тогтоохдоо аль болох хуулийн тодорхой үр дүн, нөлөөлөл үзүүлэх заалтуудыг сонгон авахыг зорьсон болно.

2.3.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОЖ ТОГТООХ

Аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлт бүр хуулийн хэрэгжилтийг бодит байдлыг тодорхойлоход чиглэсэн байх шаардлагатай бөгөөд аргачлалын 3.4 дэх хэсэгт заасан 6 шалгуур үзүүлэлтээс дээр дурдсан үнэлгээний хүрээн дэх зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байх шаардлагад мөн нийцүүлсэн.

Шалгуур үзүүлэлт 1

Зорилгод хүрсэн түвшин - /тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшх хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх/

Шалгуур үзүүлэлт 2

Хүлээн зөвшөөрөгдсөн байдал /иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгаа байдал буюу хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэх/

Шалгуур үзүүлэлт 3

Практикт нийцэж байгаа байдал /тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх/

Шалгуур үзүүлэлт 4

Бусад үр дагавар /урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болох/.

2.4.ХАРЬЦУУЛАХ ХЭЛБЭРИЙГ СОНГОХ

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад заасны дагуу хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашиглана.

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.5.3 дахь заалтад заасан 4-н төрлийн харьцуулах хэлбэрээс тогтоосон шалгуур үзүүлэлт бүрт харьцуулах хэлбэрийг тохируулж дараахь байдлаар сонголоо:

№	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
1	Зорилгод хүрсэн түвшин	байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. Үнэлгээ хийхээр сонгож авсан хууль тогтоомжид байвал зохих тодорхой үзүүлэлтийг зааж өгсөн бол тэрхүү үзүүлэлтийг одоо байгаа үзүүлэлттэй шууд харьцуулж болно.
2	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.
3	Практикт нийцэж байгаа байдал	тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.
4	Бусад үр дагавар буюу урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагаварууд	тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

2.5.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОМЬЁОЛОХ

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.6.1 дэх заалтад заасны дагуу тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлж, эсхүл асуулт тавьж шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар томъёоллоо.

№	Сонгосон шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал
1	Зорилгод хүрсэн түвшин	Согтууруулах ундааны үйлдвэрлэл багассан эсэх
2	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Иргэд, хуулийн этгээдээс хуулийн зохицуулалтыг бүрэн хүлээн авч хуулийг сайн дураараа хэрэгжүүлж байх
3	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох
4	Бусад үр дагавар буюу урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагаварууд	Хууль тогтоогч урьдчилан тооцоогүй, шинээр гарч ирж болзошгүй үр дагаваруудыг тодорхойлох

2.6.МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГЫГ СОНГОХ

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.7.3.1 дэх дэд заалтад заасны дагуу мэдээллийг цуглуулахдаа тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглана.

Түүнчлэн мэдээллийг аргачлалын 3 дугаар зүйлийн 3.7.3.4 дэх дэд заалтад заасан биечилсэн судалгааг хийж хууль тогтоомж хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж, ажиглалт хийж мэдээлэл цуглуулна.

3.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлгээний хүрээ 1	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг: “Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгоно. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хяналт тавих чиг үүргийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.”
Шалгуур	Зорилгод хүрсэн түвшин - /тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх/
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгосноор согтууруулах ундааны үйлдвэрлэл багассан эсэх?
Үнэлсэн байдал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.11 дэх заалтад: “хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд

зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.” гэж заасан. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн тухайд хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг “согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах /үйлчлэх/, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан буюу өөрөөр хэлбэл энэхүү хуулиар ямар харилцааг зохицуулах талаар тусгасан хэдий ч энэхүү хуулийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, биелэгдэх зорилгыг тусгайлан, шууд заагаагүй байна.

Харин хуулийн 1 дүгээр зүйл дэх томьёоллоос харахад уг хуулийн зорилт нь дээрхи харилцааг зохицуулах замаар /хуульд заасан тусгай зөвшөөрлийн арга хэрэгсэл болон согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, зар сурталчилгаатай холбоотой хязгаарлалт, хориглолт тогтоосон зохицуулалтаар дамжуулан/ **“архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх”** зорилттой байна гэж үзэхээр байна.

Ийнхүү хуулийн зорилтыг тодорхойлсноор сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль нь хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд уг хуульд заасан зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, сонгосон харьцуулах хэлбэрийн дагуу байх ёстой буюу согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэл зохистой хэмжээнд байх болон одоо байгаа буюу хууль хэрэгжиж эхэлснээр хойшхи үр дагаварыг үнэлж, томьёолсон шалгуур үзүүлэлт буюу **“Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгосноор согтууруулах ундааны үйлдвэрлэл багассан эсэх”**-д хариулж, дүгнэлт өглөө.

1. ДЭМБ-ын гаргасан судалгаагаар олон улсын түвшинд нэг хүнд ногдох согтууруулах ундааг архинд шилжүүлсэн дүнгээр 6.2 литр байдаг баманай улсын 18-с дээш насны нэг хүнд ногдох архины хэрэглээ **2002 онд 9,3 литр** байсан бол **2009 онд 9,2 литр, 2011 онд 10.6 литр, 2012 онд 10.8 литр, 2013 онд 8.9 литр, 2014 онд 8.4 литр, 2015 онд 7,2 литр** гэсэн тоон мэдээ байна.
2. Харин улсын хэмжээнд 2016 оны байдлаар спиртийн 9, архины 46, шар айрагны 19, дарсны 10, нийт **84** үйлдвэр байна.
3. 2009 оны байдлаар улсын хэмжээнд спиртийн 16, архины 93, шар айрагны 22, дарсны 14, нийт **145** үйлдвэр байсан байна.

2009 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 20,8 хувь нь согтуугаар, 2010 онд 23,3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байсан бол энэ үзүүлэлт 2016 оны байдлаар ямар нэгэн өөрчлөлтгүй төдийгүй харин ч өсөж улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо сүүлийн 5 жилийн хугацаанд 1.43 дахин өссөн, жилд 5,476 орчим тохиолдол гарч байна. 2011 онд нийт 115 мянган хүн, 2013 онд 123 мянган хүн эрүүлжүүлэгдэж байсан бол, 2017 оны эхний 7 сарын байдлаар 56 мянган хүн эрүүлжүүлэгдсэн байгаа нь согтуурах явдал, гэмт хэрэг үйлдэх явдалд үзүүлэх согтууруулах ундааны нөлөөлөл олон жилийн туршид нэг түвшинд хадгалагдаж байгааг харуулж байна.

Дээрхи байдлаас дүгнээд харахад 2002 онд буюу Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль дөнгөж хэрэгжиж эхэлсний дараа үед нэг хүнд ногдох архины хэрэглээ 9,3 л байсан хэдий ч энэ нь 9 жилийн дараа 1,03 л-ээр

нэмэгдэж 10,6 литрт хүрч энэ нь дараагийн онд мөн өссөн хэдий ч 2013, 2014, 2015 онуудад буурч 2002 оны үзүүлэлтээс ч багассан харагдаж байна. Хэдий багассан харагдаж байгаа боловч манай улсын хувьд олон улсын дундаж гэгдэх нэг хүнд 6,2 литр гэх үзүүлэлтээс хол байгаа бөгөөд энэ үзүүлэлтээрээ дэлхийн 182 орноос 76-д жагссан байна. Нэг хүнд ногдох архины хэрэглээг тооцохдоо **үйлдвэрлэсэн болон** импортлосон архинаас экспортлосныг нь хасаж тооцсон байна. Ингээд дүгнээд үзэхэд сүүлийн жилүүдэд нийгмийн хөгжил, залуучуудын соёлын түвшин ахихтай зэрэгцэн архины хэрэглээ багасаж байгаа мэт харагдаж байгаа боловч үйлдвэрлэлийн хэмжээ багассан гэж үзэх боломжгүй байна.

Харин үйлдвэрлэсэн архи, дарсны үйлдвэрлэлийн талаархи мэдээллийг ХХААХҮЯ-наас ирүүлснээс харахад спирт, шар айраг, дарсны үйлдвэрлэл оноос он дараалан тогтмол нэмэгдэж байгаа харагдаж байна.

	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Архи, дарсны үйлдвэрлэл	3663	3583	4399	4989	5510	6596	8626
Шар айраг	1303	1692	4525	3946	1852	3247	4267

	2002	2003	2004	2005	2006	2007	2008
Архи, дарсны үйлдвэрлэл	9436	8873	9161	7956	10719	12591	15493
Шар айраг	3375	3027	7980	7996	7393	18377	19891

	2009	2010	2011
Архи, дарсны үйлдвэрлэл	17410	20398	25596
Шар айраг	32445	44875	57133

	1995	1996	1997	1998	1999	2000	2001
спиртийн үйлдвэрлэл	2120	2060	2654	2818	3156	3796	3964

	2002	2003	2004	2005	2006	2007	2008
--	------	------	------	------	------	------	------

спиртийн үйлдвэрлэл	4902	2077	2296	3094	4032	5721	6778
------------------------	------	------	------	------	------	------	------

	2009	2010	2011
спиртийн үйлдвэрлэл	3541	3609	3440

Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгосноор үйлдвэрлэх архи, согтууруулах ундааны хэмжээ багасаагүй, харин ч эсрэгээрээ нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь тоон мэдээллээс харагдаж байна.

Хэдийгээр архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрийн тоо багассан хэдий ч үйлдвэрлэсэн согтууруулах ундааны хэмжээ нь үйлдвэрийн тооноос харилцан хамааралгүйгээр нэмэгдэж байгаа нь одоогийн тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрүүдийн хүчин чадал, үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээнд хяналт тавьдаггүйтай холбоотой бөгөөд хууль хэрэгжиж эхэлснээр өөрийн зорилго, зорилтдоо хүрээгүй байна гэж дүгнэхээр байна.

2008 онд Монгол Улсын Засгийн газраас “Хүнсний аюулгүй байдлыг хангах, архидан согтуурахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай” 05 дугаартай тогтоол гарч, уг тогтоолын 4 дэх хэсгээр “Архидан согтуурахтай тэмцэх тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлт батлагдах хүртэлх хугацаанд Архины үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нэмж олгохгүй байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан” байна.

Энэхүү тогтоол хэрэгжиж эхэлснээр хойшхи хугацаанд шинээр согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл Засгийн газраас олгоогүй гэх бөгөөд ХХААХҮЯ-наас өгсөн мэдээллээр **2016 оны байдлаар спиртийн 9, архины 48, шар айрагны 19, нийт 76 үйлдвэр байна.** Эдгээр үйлдвэрүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнээс харахад дээр дурдсан дүгнэлтийн үнэн болохыг дахин батлан харуулж байгаа бөгөөд хэдий үйлдвэрийн тоо буурсан ч үйлдвэрлэсэ бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэж, 2014, 2015 онуудад спиртын үйлдвэрлэл 9,126 мянга, 8,669 мянган литр хүрч өссөн, архины үйлдвэрлэл 24,181, 21,132 мянган литр болсон байгаа нь үйлдвэрийн тоо 2,5 дахин багассан ч бүтээгдэхүүний хэмжээ 2010, 2011 оныхтой ижил түвшинд байгаа нь харагдаж байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт: “...согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг **хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар**

олгож, хүчингүй болгоно.” гэж, “Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг **сунгах, түдгэлзүүлэх, сэргээх**, хяналт тавих чиг үүргийг **хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага** хэрэгжүүлнэ.” гэж, мөн зүйлийн 4.5 дахь хэсэгт: “**Согтууруулах ундааны үйлдвэрлэл шинээр эрхлэх тусгай зөвшөөрлийг төсөл сонгон шалгаруулах үндсэн дээр олгоно.** Төсөл сонгон шалгаруулах болон үйлдвэрлэлд хяналт тавих журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” гэж тус тус заасан.

Хуулийн дээрхи зохицуулалтаас харахад тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгох мэтээр хуульд заасан байгаа боловч Засгийн газар үнэн хэрэгтээ тусгай зөвшөөрлийг олгох, хүчингүй болгуулах талаархи бүрэн эрхийг хууль тогтоогчийн үзэл санаанд нийцэх хэмжээнд хэрэгжүүлж чадахгүй байгаа нь харагдаж байгаа юм.

1-рт, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль тогтоомж, Засгийн газрын хуралдаанаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журмаар бол Засгийн газрын гишүүд тодорхой асуудал хариуцаж, уг асуудлаар шийдвэр гаргах талаархи саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх санал гаргаж, Засгийн газрын хуралдаанаас уг асуудлаар шийдвэр гаргадаг. Энэ тохиолдолд тухайн асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн уг асуудлыг оруулж ирэхээс наана, эсхүл Засгийн газрын хуралдаанаас өгөгдсөн чиглэлгүйгээр тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай асуудлыг шийдвэрлэх боломжгүй нь тодорхой юм.

2-рт, хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт тусгай зөвшөөрлийг олгох эсэх бүрэн эрх нь Засгийн газарт байсаар байтал, хуулийн 4.5 дахь хэсэгт “**сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрлийг олгоно**” гэж заасан нь хоорондоо зохицуулалтын утга, агуулгын хувьд зөрчилтэй байгаа нь харагдаж байгаа бөгөөд хэрэв аливаа аж ахуйн нэгж сонгон шалгаруулалтад орж тэнцсэн гэсэн тохиолдолд Засгийн газар зөвшөөрлийг заавал олгох, эс бөгөөс Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр уг асуудлыг шийдвэрлүүлж, шүүхээс сонгон шалгаруулалтад ялсан этгээдэд тусгай зөвшөөрлийг олгох тухай шийдвэр гаргахыг Засгийн газарт даалгаж болох боломжийг бий болгосон байна. Өөрөөр хэлбэл, хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн зохицуулалт бүрэн хэмжээнд хэрэгжих буюу Засгийн газар тусгай зөвшөөрлийг олгох, эсхүл үл олгох бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад болохоор байна.

3-рт, хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт: “**Төсөл сонгон шалгаруулах болон үйлдвэрлэлд хяналт тавих журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.**” гэж заасан нь дээр дурьдсанчлан Засгийн газрын гаргах шийдвэр, уг шийдвэр гаргах журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу ХХААХҮЯ тогтоох агуулгатай байгаа нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэхээр байна.

Учир нь дээр дурдсанчлан тусгай зөвшөөрөл олгох эсэх нь Засгийн газрын бүрэн эрхийн асуудал байх байтал сонгон шалгаруулалтад ялсан этгээдэд тусгай зөвшөөрлийг заавал олгох болсон, харин ялагчийг хэрхэн тодруулах вэ гэх асуудал нь яамны бүрэн эрхэд хамаарч байгаа нь тусгай зөвшөөрлийг олгох эсэхийг шийдвэрлэх асуудлыг зохицуулсан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг бүхэлдээ хууль тогтоогчоос баталсан үзэл санаанд нийцэн хэрэгжихгүй байна гэх үндэслэлийг бүрдүүлж байна.

Үнэлгээний хүрээ 2 Үнэлгээний хүрээ 4	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг: “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.” Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг: “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”																																																																																																														
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал																																																																																																														
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх																																																																																																														
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох																																																																																																														
Үнэлсэн байдал	Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүд 2010, 2011, 2012 оны байдлаар: <table><tr><td>№</td><td>Аймаг</td><td>2010</td><td>2011</td><td>2012</td></tr><tr><td>1</td><td>Архангай</td><td>304</td><td>312</td><td>253</td></tr><tr><td>2</td><td>Баян-Өлгий</td><td>134</td><td>245</td><td>199</td></tr><tr><td>3</td><td>Баянхонгор</td><td>338</td><td>358</td><td>254</td></tr><tr><td>4</td><td>Булган</td><td>216</td><td>203</td><td>203</td></tr><tr><td>5</td><td>Говь-Алтай</td><td>40</td><td>98</td><td>102</td></tr><tr><td>6</td><td>Говьсүмбэр</td><td>26</td><td>25</td><td>17</td></tr><tr><td>7</td><td>Дархан-Уул</td><td>496</td><td>490</td><td>503</td></tr><tr><td>8</td><td>Дорноговь</td><td>130</td><td>125</td><td>133</td></tr><tr><td>9</td><td>Дорнод</td><td>158</td><td>257</td><td>253</td></tr><tr><td>10</td><td>Дундговь</td><td>101</td><td>102</td><td>93</td></tr><tr><td>11</td><td>Завхан</td><td>206</td><td>206</td><td>206</td></tr><tr><td>12</td><td>Орхон</td><td>394</td><td>394</td><td>392</td></tr><tr><td>13</td><td>Өвөрхангай</td><td>402</td><td>400</td><td>400</td></tr><tr><td>14</td><td>Өмнөговь</td><td>143</td><td>145</td><td>166</td></tr><tr><td>15</td><td>Сүхбаатар</td><td>177</td><td>178</td><td>158</td></tr><tr><td>16</td><td>Сэлэнгэ</td><td>386</td><td>420</td><td>393</td></tr><tr><td>17</td><td>Төв</td><td>666</td><td>656</td><td>553</td></tr><tr><td>18</td><td>Увс</td><td>221</td><td>245</td><td>245</td></tr><tr><td>19</td><td>Ховд</td><td>267</td><td>261</td><td>255</td></tr><tr><td>20</td><td>Хөвсгөл</td><td>473</td><td>478</td><td>478</td></tr><tr><td>21</td><td>Хэнтий</td><td>283</td><td>269</td><td>248</td></tr></table>	№	Аймаг	2010	2011	2012	1	Архангай	304	312	253	2	Баян-Өлгий	134	245	199	3	Баянхонгор	338	358	254	4	Булган	216	203	203	5	Говь-Алтай	40	98	102	6	Говьсүмбэр	26	25	17	7	Дархан-Уул	496	490	503	8	Дорноговь	130	125	133	9	Дорнод	158	257	253	10	Дундговь	101	102	93	11	Завхан	206	206	206	12	Орхон	394	394	392	13	Өвөрхангай	402	400	400	14	Өмнөговь	143	145	166	15	Сүхбаатар	177	178	158	16	Сэлэнгэ	386	420	393	17	Төв	666	656	553	18	Увс	221	245	245	19	Ховд	267	261	255	20	Хөвсгөл	473	478	478	21	Хэнтий	283	269	248
№	Аймаг	2010	2011	2012																																																																																																											
1	Архангай	304	312	253																																																																																																											
2	Баян-Өлгий	134	245	199																																																																																																											
3	Баянхонгор	338	358	254																																																																																																											
4	Булган	216	203	203																																																																																																											
5	Говь-Алтай	40	98	102																																																																																																											
6	Говьсүмбэр	26	25	17																																																																																																											
7	Дархан-Уул	496	490	503																																																																																																											
8	Дорноговь	130	125	133																																																																																																											
9	Дорнод	158	257	253																																																																																																											
10	Дундговь	101	102	93																																																																																																											
11	Завхан	206	206	206																																																																																																											
12	Орхон	394	394	392																																																																																																											
13	Өвөрхангай	402	400	400																																																																																																											
14	Өмнөговь	143	145	166																																																																																																											
15	Сүхбаатар	177	178	158																																																																																																											
16	Сэлэнгэ	386	420	393																																																																																																											
17	Төв	666	656	553																																																																																																											
18	Увс	221	245	245																																																																																																											
19	Ховд	267	261	255																																																																																																											
20	Хөвсгөл	473	478	478																																																																																																											
21	Хэнтий	283	269	248																																																																																																											

22	Улаанбаатар	3314	3491	2881
	Нийт:	8965	9100	8581

Харин 2013 оны байдлаар аймаг, нийслэл дэх архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах эрхтэй аж ахуйн нэгжүүд болон тэдгээрийн тодорхой хүн амд ногдох тоо хэмжээгээр нь харьцуулахад дараахь тоон үзүүлэлт гарч байна:

д/д	Аймаг	Хүн амын тоо /2013 оны эцэс/	Төрөл	Цэгийн Тоо	1 цэгт ногдож буй хүн амын тоо
1.	Архангай	83850	Худалдах	215	390
			Үйлчлэх	38	2206.5
2.	Баян-Өлгий	85948	Худалдах	138	622.8
			Үйлчлэх	23	3736.8
3.	Баянхонгор	76256	Худалдах	284	268.5
			Үйлчлэх	28	2723.4
4.	Булган	53529	Худалдах	169	316.7
			Үйлчлэх	40	1338.2
5.	Говь-Алтай	52602	Худалдах	96	547.9
			Үйлчлэх	28	1878.6
6.	Говьсүмбэр	13701	Худалдах	12	1141.7
			Үйлчлэх	11	1245.5
7.	Дархан-Уул	92053	Худалдах	235	391.7
			Үйлчлэх	138	667.0
8.	Дорноговь	59524	Худалдах	98	607.3
			Үйлчлэх	78	763.1
9.	Дорнод	69535	Худалдах	177	392.8
			Үйлчлэх	71	979.3
10.	Дундговь	37449	Худалдах	83	451.1
			Үйлчлэх	19	1971
11.	Завхан	63667	Худалдах	201	316.7
			Үйлчлэх	31	2053.7
12.	Орхон	87907	Худалдах	281	312.8
			Үйлчлэх	114	771.1
13.	Өмнөговь	62967	Худалдах	192	327.9
			Үйлчлэх	63	999.4
14.	Өвөрхангай	100341	Худалдах	404	248.3
			Үйлчлэх	75	1337.8
15.	Сүхбаатар	51539	Худалдах	179	287.9
			Үйлчлэх	59	873.5
16.	Сэлэнгэ	97460	Худалдах	280	348.0
			Үйлчлэх	111	878.0
17.	Төв	84375	Худалдах	380	222.0
			Үйлчлэх	113	764.6
18.	Увс	72562	Худалдах	278	261.0
			Үйлчлэх	34	2340.7
19.	Ховд	76607	Худалдах	224	341.9
			Үйлчлэх	34	2.253.1
20.	Хэнтий	65971	Худалдах	181	364.4
			Үйлчлэх	61	1081.4
21.	Хөвсгөл	115341	Худалдах	474	243.3
			Үйлчлэх	87	1325.7

	22	Улаанбаатар	1201342	Худалдах	2242	535.8
				Үйлчлэх	1624	739.7
	Нийт		2704526	Худалдах	6823	396.3
				Үйлчлэх	2880	939.0
Дээрхи тоо мэдээны хувьд 2013 оноос хойшхи хугацаанд 2016, 2017 оны байдлаар тоо мэдээтэй ерөнхийдөө ойролцоо байгаа бөгөөд ерөнхий дүр зурагт өөрчлөлт орохоор дорвитой өөрчлөлт гараагүй байна. Тухайлбал, 2016 оны байдлаар Улаанбаатар хотод л гэхэд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг 3951 аж ахуйн нэгж байна. 2008 онд батлагдсан Монгол Улсын Засгийн газрын “Хүнсний аюулгүй байдлыг хангах, архидан согтуурахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай” 05 дугаартай тогтоолын 2 дахь хэсэгт: “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6.4-ийг хэрэгжүүлэх зорилгоор Үйлдвэр, худалдааны яамнаас баталсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тооны нормативийн хэрэгжилтийг хангаж ажиллах” талаар үүрэг болгосон боловч тогтоол болон норматив огт хэрэгжээгүй нь харагдаж байна. Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 1 сарын 10-ны өдрийн “Норматив тогтоох тухай” 05 дугаартай тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог нийслэл, аймгийн төвд 2000 хүн ам тутамд нэгээс хэтрэхгүй байхаар тогтоосон байна. Энэ нормативын дагуу тооцоход зөвхөн нийслэлд архи согтууруулах ундаагаар үйлчлэх цэгийн тоо 6.5 дахин их байгаа бөгөөд харин бусад аймагуудын хувьд дээрхи хүснэгтээс харахад байдал нийслэлээс ч хүнд байгаа нь харагдаж байна. Түүнчлэн нийслэлийн дүүргүүд, тэдгээрийн хороодоор хийсэн судалгаанаас харахад Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 15,6 дахин, Баянзүрх дүүргийн 8-р хороо 37 дахин, Чингэлтэй дүүргийн 12-р хороо 19 дахин их байна. Дээрхи тоо статистикаас дүгнэхэд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг практик огт хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.						

Үнэлгээний хүрээ 3	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг: <i>“Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг шугамын оролт, гаралтыг тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжөөр, технологийн горим, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд батлагдсан стандартын дагуу явуулна.”</i>
Шалгуур	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг	Иргэд, хуулийн этгээдээс хуулийн зохицуулалтыг бүрэн хүлээн авч хуулийг сайн дураараа хэрэгжүүлж байх

томъёолсон байдал	
Үнэлсэн байдал	Хуулийн дээрхи заалт нь согтууруулах ундааны үйлдвэрлэлийг явуулахдаа шугамын оролт гаралтыг заавал зориулалтын төхөөрөмжөөр тоолууржуулсан байх ёстойг хуульчилж өгсөн явдал юм. Тоолуурын сонголт, тоолуур худалдах, суурилуулах, засварлах тусгай зөвшөөрөл Стандартчлал хэмжил зүйн үндэсний төвөөс архи, спиртийн тоолуур суурилуулах аж ахуйн нэгжүүдийг шалгаруулж, архины тоолуур нийлүүлж, суурилуулах эрхийг ОХУ, БНХАУ, ХБНГУ, Дани улсын тоног төхөөрөмжийг ашиглан үйл ажиллагаа явуулах 3 аж ахуйн нэгжид олгосон байна. Хууль батлагдсанаас хойшхи хугацаанд Хүнс, хөдөө, аж ахуйн, Сангийн болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2005 оны хамтарсан шийдвэрийн дагуу архи, спиртийн үйлдвэрүүдийн технологийн дамжлагад хяналтын тоолуур суурилуулах хуваарийг баталж, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж, спиртийн бүр үйлдвэрүүдэд 2005 оны 4 сарын 20-ны дотор, Нийслэл дэх архины үйлдвэрүүдэд мөн оны 3 сарын 30-ны дотор, орон нутаг дахь архины үйлдвэрүүд 3 сарын 31-нээс 8 сарын 24-ний дотор тоолуур суурилуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа архи, спирт, бусад согтууруулах ундаа үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүд 100 хувь тоолууржуулалтад хамрагдан үйл ажиллагаа явуулж байна. Харин хууль, шүүхийн байгууллагад маргаан үүсгэсэн, тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, хөрөнгийн эх үүсвэргүй гэх зэрэг шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжүүд тоолуураа түр хугацаанд буцаан өгсөн гэх мэдээлэл байна. Тоолуурын гэмтлийн талаархи асуулгад давхардсан тоогоор 112 аж ахуйн нэгж хамрагдснаас харахад согтууруулах ундааны үйлдвэрийн технологийн урсгал шугамд суурилуулсан тоолуур нь өрөө тасалгааны халуун хүйтэн, удаан хугацаагаар ажиллуулснаас тогны хэлбэлзэл гарах зэргээс хатуулгын хэмжигч буруу заах, алдаа зааж ажиллахгүй болох зэрэг явдал түгээмэл гардаг; тоолуурыг нийлүүлсэн аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн ажилчид нь гэмтэл гарсан шалтгааныг мэддэггүй, хүний нөөцийн мэдлэг чадвар муу, гэмтлийн шалтгааныг тогтоох, хэвийн үйл ажиллагаанд шилжүүлэхэд цаг хугацаа маш их шаарддаг, технологийн хөгжлийн хувьд хоцрогдсон тоног төхөөрөмж хэрэглэдэг, чанарын хувьд муу гэх зэрэг асуудал, зөрчил дутагдлуудын талаар дурдсан байна. Тоолуурын сэлбэг олдоцын талаар асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдийн хувьд гэвэл “олдоц ховор”, “өртөг өндөртэй”, “сэлбэгийг гадаадаас захиалдгаас шалтгаалан цаг хугацаа маш их шаарддаг” гэсэн байна. Цаашид тоолуурын талаар авах арга хэмжээний тухай санал асуулгад оролцогчид: орчин үеийн шаардлагыг хангасан, ашиглахад энгийн тохиромжтой, өртөг зардлыг хэмнэсэн, найдвартай ажиллагаатай тоног төхөөрөмжийг ашиглах, тоолуурын ашиглалтын талаар сургалт зохион байгуулах, инженер программистуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, хариуцах байгууллага, эзэнтэй болгох гэх зэрэг саналуудыг ирүүлсэн байна. Санал асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдийн 27,8 хувь нь тоолуурыг цаашид ашиглах боломжгүй гэж хариулсан байна.

Үнэлгээний хүрээ 5	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг: <i>“Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.”</i>
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох
Үнэлсэн байдал	Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах цагийн хуваарийг тогтоох эрх мэдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгсөн нь нэг талаас харахад тухайн орон нутагт өөрийн хэрэглээг хянах боломж олгосон мэт харагдаж байгаа боловч тухайн шатны Засаг дарга нь улс төрийн албан тушаалтан бөгөөд цагийн хязгаарыг өөрийн үзэмжээр тогтоох, улс төр, авилга, хээл хахуулийн нөлөөнд автахгүй гэх үндэслэл байхгүй байна. Аливаа хориглолт, хязгаарлалт тогтоосон зохицуулалтыг хуулиар тодорхой, ойлгомжтой, улсын хэмжээнд нэг мөр, ойлгогдож, хэрэглэгдэхүйц тогтоож өгөх шаардлагатай бөгөөд холбооны бус нэгдмэл улс төрийн зохион байгуулалттай манай улсын хувьд нэг аймагт хууль буст тооцогдон зөрчил гэж үзэн торгох, тусгайлан олгогдсон эрх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийтгэл хүлээх зэргээр аж ахуй эрхлэгч нарын эрх ашигт хүндээр нөлөөлж болохуйц байхад яг ижил төрлийн үйлдэл нь хэдхэн км-ийн цаана байх нөгөө аймаг, сумын нутаг дэвсгэрт хууль ёсны үйлдэл гэж үзэгдэх нь төрөөс иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэдээ алагчлахгүй байх, нэгдмэл зарчмыг алдагдуулж байна гэж үзэхээр байна. 2013 онд Нийслэлийн Засаг даргаас захирамж /2013 оны 5 сарын 30-ны өдрийн а/548 дугаар захирамж/ гаргаж шөнийн цэнгээний газруудыг Пүрэв, Баасан, Бямба гарагуудад “согтууруулах ундаа худалдаалахгүйгээр” шөнийн 00,00 цагаас хойш 03,00 цаг хүртэл үйл ажиллагаа явуулж болно гэж заасан байдаг. Цагдаагийн байгууллагаас Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнд илрүүлсэн зөрчил, авсан арга хэмжээний мөнгөн дүн харьцангуй их байгаа ч зөрчил таслан зогсоогдохгүй, хяналт шалгалтын дүр дүн муу байгаа нь согтууруулах ундаатай их тэмцэлд нутгийн захиргааны байгууллагын зүгээс хангалттай сайн оролцохгүй байгаатай шууд холбоотой юм. Нийслэлийн Засаг даргын дээрхи шийдвэртэй холбоотойгоор цагдаагийн байгууллагаас дүгнэхдээ уг шийдвэр нь хуулийг хэрэгжүүлэхэд, гудамж, талбай, олон нийтийн газарт хэв журам сахиулахад сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн гаралтыг ихэсгэсэн гэж дүгнэсэн байна. Түүнчлэн Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд зааснаар хуульд зөвхөн архи, согтууруулах ундааг худалдаалахыг хориглосон байдаг ч

	тэдгээрээр үйлчилдэг, худалдаалдаг газруудын ажиллах цагийн хуваарийг зааж өгөөгүйгээс хууль зөрчигдөх явдал их гардаг төдийгүй, цагдаагийн байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд зөвхөн торгуулийн арга хэмжээ авдаг ч энэ нь хангалттай нөлөөллийн арга хэмжээ болж чаддаггүй, цаашид тусгай зөвшөөрлийг нь цуцлах хүртэл арга хэмжээ авах гэхэд нутгийн захиргааны байгууллагуудаас энэ тал дээр хамтарч ажилладаггүй гэсэн байна.

Үнэлгээний хүрээ 6	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалт: “21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй газарт хориглоно.”
Шалгуур	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Иргэд, хуулийн этгээдээс хуулийн зохицуулалтыг бүрэн хүлээн авч хуулийг сайн дураараа хэрэгжүүлж байх
Үнэлсэн байдал	Архины хэрэглээ нь 20 хүртэлх болон 25-44 хүртэлх насныхны дунд өндөр байна. Жишээ нь: өсвөр насны охид, хөвгүүдийн хувьд 15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа уусан хувь 0.8 ба 3.6 бөгөөд аль аль нь бусад насны бүлгийн дунд өндөр байна. Мөн аймгуудад жилд дунджаар 472 (336-645 орчим), дүүргүүдэд 569 (337-770 орчим) 18 хүртэлх насны хүүхдүүд эрүүлжүүлэгдэж байна. Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээллээр улсын хэмжээнд 2016 онд согтуурах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдон 87 мянга орчим хүн саатуулагдсан байх ба үүний 279 буюу 0.3 хувь 18 хүртэлх насны хүн байсан байна. Судалгаагаар сурагч-өсвөр үеийнхний 29.1 хувь нь согтууруулах ундаа хэрэглэж үзсэн, 12.9 хувь нь согтгол хэрэглэж үзсэн төдийгүй тэдний эцэг эхчүүдийн 39.8 хувь нь архи, согтууруулах ундаа хэрэглэдэг, оюутан залуучуудын 38.8 хувь нь хэтрүүлэн хэрэглэдэг, 70.6 хувь нь баар, диско клубт хэрэглэдэг, оюутнуудын сургууль, амьдарч байгаа орчноос 100 метр хүрэхгүй газар яваад архи, согтууруулах ундаа авч болдог гэжээ. Үүнээс гадна архины хэрэглээний талаарх хандлагыг тодорхойлох судалгаанаас харахад 15-24 насны хүүхэд залуучуудын 56.5 хувь нь сүүлийн 1 сарын хугацаанд архи согтууруулах ундаа хэрэглэсэн гэж хариулж, 40.0 хувь нь монголчууд архи, согтууруулах ундааг нэг дор их хэмжээгээр уудаг гэдэгтэй санал бүрэн нийлж, 52.0% нь санал нийлж байна гэжээ. Энэхүү хандлага эрэгтэй, эмэгтэй, аль ч насны хүмүүст ижил байгаа нь ерөнхийдөө ихэнх хүмүүс Монголчууд архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэдэг дадалтайг хүлээн зөвшөөрч байгаа нь илэрхий байна.

	Эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар шар айраг хэрэглэж буй хэрэглэгчдийн 80 орчим хувь 15-25 насны залуучууд болох нь тогтоогдсон нь хуулийн энэхүү зохицуулалт амьдрал дээр хэрэгжихгүй байгаа нь илт харагдаж байна.
	Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээс харахад: Цагдаагийн байгууллагаас явуулж байгаа хяналт шалгалтын хүрээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг зарим томоохон аж ахуйн нэгж байгууллагуудаас хуульд заасан цагийн хязгаарлалтыг зөрчих, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлгүй, эсвэл тусгай зөвшөөрөл цуцлагдсан хугацаанд үйл ажиллагаа явуулах, 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, 18 насанд хүрээгүй хүнийг авч ажиллуулах зэрэг зөрчлийг удаа дараа гаргаж байна. Согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаа эрхэлдэг газруудаас гаргасан зөрчлийн мэдээнээс авч үзэхэд нийт зөрчлийн 6 хувь нь 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаагаар үйлчилсэн зөрчил эзэлсэн нь харьцангуй бага мэт харагдаж байгаа боловч энэ нь зөвхөн илрүүлсэн, хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэсэн зөрчил гэдгийг анхаарах шаардлагатай.

Үнэлгээний хүрээ 7	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2. дахь заалт: <i>“Архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг Согтуурах, мансуурах донтой өвчтэй хүмүүсийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулиар зохицуулна.”</i> Дээр заасан үнэлгээний хүрээг тогтоохдоо аль болох хуулийн тодорхой үр дүн, нөлөөлөл үзүүлэх заалтуудыг сонгон авахыг зорьсон болно.
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох
Үнэлсэн байдал	Улсын хэмжээнд архинд донтох өвчтэй архины эсрэг эмчилгээ шаардлагатай 12,000 хүн7 байгаагаас 20 орчим хувь нь хамрагдаж байна. Хүн амын дунд архийг хэтрүүлсэн хэрэглэгч болон АДЭ-тэй хүний тоо нэмэгдсээр байхад мэргэжлийн тусламж үйлчилгээний хамралт муу, ялангуяа аймгуудад эмчилгээнд хамрагдагсдын тоо эрс бууралттай байна. Энэ байдал нь орон нутгийн наркологи,

	сэтгэл зүйн чиглэлээр ажиллаж буй боловсон хүчний хангалт, шатлал хоорондын шилжүүлэг болон хяналтын системтэй холбоотой байх магадлалтай. Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг хангах зорилгын хүрээнд 2000 оны 1 сарын 28-ны өдөр Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх харилцааг хуульчилсан байна. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2000 оны 9 сарын 27-ны өдрийн 148 дугаар тогтоол гарч, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа Багахангай дүүрэг дэх Архинд донтох өвчтөн албадан эмчлэх эмнэлгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд шилжүүлж Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар болгон зохион байгуулсан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын хувьд хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд олон хүндрэл гардаг байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагад 20169 оны байдлаар бүртгэгдсэн архаг архичин 3621, үүнээс гэр оронгүй 341, архинд донтох өвчтэй 2198, үүнээс нийслэлд 896, орон нутагт 2725 хүн байна гэсэн тоо үзүүлэлттэй байсан. Сүүлийн 15 жилийн байдлаар нэг жилд тус газарт эмчлүүлэгсдийн тоо 295-1050 хүртэл хэлбэлзэж, жилд дунджаар 500-600 хүн эмчлүүлж байгаа нь тус байгууллагын ачаалалаа дийлэхгүй байх, эмчилгээний чанарт нөлөөлөхүйц нөхцөл байдлыг бий болгосон байна. Түүнчлэн хуульд зааснаар анх удаа албадан эмчилгээ хийлгэхээр ирж байгаа хүн 3-6 сар хүртэл хугацаатай, харин давтан эмчилгээнд ирж байгаа хүнийг 6 сараас 1 жил хүртэл хугацаанд эмчлэх ёстой байдаг хэдий ч эмчилгээ нь дийлэнхидээ 3 сараас хэтэрдэггүй. Шүүхийн шийдвэр гарсан тул албадан эмчилгээнд хамрагдах ёстой дараагийн ээлжийн хүмүүс хүргэгдэж ирэх, албадан эмчлэгдсэн боловч гэр оронгүй, хүлээж авах төрөл садан байхгүй, гэр бүлийн гишүүд нь хүлээж авахаас татгалзсан зэрэг шалтгааны улмаас дахин архинд донтох зэргээр эмчилгээний дараа авах арга хэмжээ, нийгэмшүүлэх, ажилтай орлоготой болгох, архинаас хамааралтай байдлыг арилгах зэрэг тэдгээр хүмүүст үзүүлэх нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээ байдаггүй гэсэн байна. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу захиргааны арга хэмжээ авах “донтой өвчтөн” гэдэгт согтуурах болон мансуурах донтой өвчтөн хамаарч байна. Тухайн этгээдийг донтой өвчтөн гэдгийг эмнэлгийн байгууллагаас сэтгэцийн эмгэг, наркологийн эмч, дотрын эмч, сүрээгийн эмч, арьс ба өнгөний гурваас доошгүй эмчийн бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж тогтооно. Уг комиссоос өвчтэй гэж дүгнэсэн бөгөөд нийгмийн хэв журмыг зөрчсөн, сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн буюу эмчлүүлсний дараа согтуурах, мансуурах бодис дахин хэрэглэсэн гэсэн 3 нөхцөлийг зэрэг, нэг дор хангасан бол албадан эмчилнэ. Архинд донтсон хүнийг хэдэн удаа эрүүлжүүлэхэд орсон, донтсон байна уу үгүй юу, нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийж байгаа эсэхийг тогтоох шалгуур тодорхойгүй байна. Энэ мэтчлэн шалтгаануудаас улбаалан иргэд төрөөс хүртээмжтэй, чанартай үйлчилгээг шуурхай хүртэж чадахгүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн мэдээлээс харахад уг байгууллагад нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд, мөн эмнэлгийн стандартад нийцсэн лаборатори, өрөө тасалгаа, тоног
--	---

	төхөөрөмж байхгүйгээс өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байна гэжээ.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх журмыг хуульд нарийвчлан зохицуулах, үнэлгээний хүрээ 1-ийн хэмжээнд заасан хуулийн хийдлийг арилгах, сонгон шалгаруулалт явуулах журмыг Засгийн газар батлахаар хуульчлах;
- Тусгай зөвшөөрлийг тухайн тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа хуулийн этгээдийн хувьцааг шилжүүлэх арга замаар шилжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, уг үйл ажиллагаанаас тодорхой хэмжээний татвар, хураамж авах зохицуулалтыг бий болгох;
- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг нэгдмэл байдлаар Засгийн газар баталдаг байхаар хуульд тусгах;
- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх цэгийн тоо, нормативыг хуульчлан тогтоох, орон нутагт энэ талаархи тодорхой эрхийг олгох эсэх асуудлыг судлаж шийдвэрлэх;
- Архи, согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглаж байгаа тоолуурын талаархи хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн байгууллагын үүрэг, оролцоог тодорхой болгох;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тоолууруудын үзлэг, шалгалтыг улсын хэмжээнд шалгаж түүний ашиглалт, үр дүнг дүгнэх;
- Орчин үеийн шаардлагад нийцсэн боловсронгуй, ашиглахад хялбар, найдвартай, өртөг зардал багатай, өдөр тутмын үйлдвэрлэл, борлуулалтын мэдээллийг эрх бүхий байгууллагад онлайн хэлбэрээр дамжуулах, үйлдвэрлэлт зайнаас хяналт тавих боломж бүхий нэгдсэн сүлжээ, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн зэрэглэлийг тогтоож, үйлчилгээний стандарт зэргээс шалтгаалан ажиллах цагийг ялгамжтайгаар тогтоох;
- Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг газрууд, тэдгээрийн хамгаалалтын ажилчид болон барменуудад үйлчлүүлэгчийн бичиг баримтыг шалгаж байх, 21 насанд хүрсэн эсэхийг заавал тогтоож байх эрх, үүргийг олгох, хэрэв тухайн баар, цэнгээний газарт байгаа үйлчлүүлэгч 21 насанд хүрээгүй этгээд согтууруулах ундаа хэрэглэсэн бол үүнийг мэдсэн эсэхээс үл шалтгаалан тухайн газарт хариуцлага хүлээлгэдэг байх;
- Баар, цэнгээний газруудаар үйлчлүүлж болох, нэвтэрч болох насны хязгаарыг 21 нас болгон тогтоох;
- Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах тусгай зөвшөөрлийг цуцлах зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, тодорхой төрлийн зөрчлүүдээс хамааран анх удаа, эсхүл давтан гаргаж байгаа тохиолдолд хариуцлагын хөнгөн хэлбэрээс нь эхлэн хамгийн хүнд хэлбэр хүртэл авдаг байх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлдэг байх зэрэг шинэлэг зохицуулалтуудыг хуульчлах;
- Архи, согтууруулах ундаанд донтсон этгээдийг олж илрүүлэх, эмчлэх болон эмчилгээний арга ажиллагааны талаар нэгдсэн стандартыг боловсруулж, мөрдүүлэх;
- Албадан эмчилгээнд хамрагдаад гарч байгаа этгээдэд бүх талын дэмжлэг, тусалцаа үзүүлэх талаар буюу түүнийг дахин хорт зуршилдаа эргэн автахгүй байх талаар авч болох арга хэмжээний талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх

арга хэмжээ авах, энэ талаар шаардлагатай бол хуульд тодорхой зохицуулалтыг оруулах;

- Албадан эмчилгээний байгууллагын бүтэц, орон тоон дээр анхаарч, зохион байгуулалтын оновчтой хэлбэрт шилжүүлэх /эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, шаардлагатай тохиолдолд аймаг, орон нутаг, эсхүл бүс нутаг хариуцсан хэлбэрээр байгуулах, эрүүл мэндийн байгууллагын удирдлагад шилжүүлж болох эсэх асуудлыг судлах/.

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЛИЙГ ОЛЖ ИЛРҮҮЛЭХ, ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБООНЫ ТАЛААР

Нэг. Ажлыг гүйцэтгэсэн үе шат

- Архидан согтуурахтай тэмцэх тухай хуультай холбоотой хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах, түүнд ангилал хийх;
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг цуглуулан нэгтгэсэн хууль эрх зүйн акттай харьцуулж уг хуульд давхардал, зөрчил, хийдэл байгаа эсэхийг тогтоох;
- Илэрсэн давхардал, зөрчил, хийдлийг хуулийн зүйл, заалт тус бүрээр гарган санал боловсруулах.

Хоёр.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль батлагдсан нөхцөл байдал

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулж, тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд заасан журмын дагуу Монгол улсын Засгийн газрын санал, дүгнэлтийг авч тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулсан байдаг.

Урьд өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуультай харьцуулбал шинэчлэн найруулсан хуульд дараахь нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгасан байна:

1. Согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон мэргэжлийн хяналтын байгууллагуудын санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар олгодогтой уялдуулан хэд хэдэн тохиолдолд зөвшөөрлийг цуцалж байхаар тусгасан.

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг даргын санал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга олгож байхаар өөрчилсөн.
3. Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газруудыг тодорхой зааж, хуулинд нэмж оруулсан.
4. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, борлуулалт, импортод хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтан нэн даруй биелүүлэх, импортолж болох согтууруулах ундааны жагсаалтыг эрх бүхий байгууллагаас баталж, хэрэгжилтийг хянах зэрэг заалтуудыг шинээр нэмсэн. Мөн согтууруулах ундааг улсын хилээр оруулахад тавих хяналтыг үр дүнтэй болгох зорилгоор согтууруулах ундааг зөвхөн нэр заасан хилийн боомтоор оруулж байх, гадаадын дээд ангиллын архи, дарсыг дуурайлган хийсэн бүтээгдэхүүн оруулж ирэхтэй тэмцэх зорилгоор гадаадаас оруулж ирсэн бүх согтууруулах ундаанд шинжилгээ хийлгэж баталгаажуулсан байх шаардлагыг тусгасан.
5. Архидан согтуурахтай тэмцэх арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор архидан согтуурахтай тэмцэх сан байгуулах асуудлыг бие даасан бүлэг болгон шинээр нэмсэн. Сангийн эх үүсвэр, хураамж төлөгч этгээд, хураамж ногдуулах согтууруулах ундаа, хураамж тооцох үнэлгээ, сангийн орлогыг төвлөрүүлж хяналт тавих, зарцуулах, сангийн зөвлөлийн талаар тусгасан.
6. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр согтууруулах ундааг хэрэглэх, дэмжин дэлгэрүүлэхийг уриалсан зар сурталчилгаа явуулахыг хориглож, стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны талаархи мэдээллийг хэвлэл, мэдээллийн байгууллагууд саадгүй хүлээн авч, нийтэд түгээж байхаар тусгасан.
7. Согтууран хэвийн бус байдал гаргасан этгээдийг эрүүлжүүлэх хуулийн заалтыг тодотгож, “ууж согтууран өөрийнхөө үйлдлийг хянах чадваргүй болсон этгээдийг шаардлагатай гэж үзвэл” эрүүлжүүлж байхаар тусгасан.
8. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээ зэргийг тус тус тусгасан.

Гурав.Илрүүлсэн давхардал, зөрчил, хийдэл

Давхардал	
тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан	4
Зөрчил	
хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдсөн	9
тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан	1
тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдсөн	2
Хийдэл	
тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бөгөөд уг нарийвчилсан зохицуулалт батлагдаагүй	12

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн холбогдох бусад хуультай давхардсан

зохицуулалтыг дараахь байдлаар тогтоолоо:

Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль/2001.02.01/
1	5.4. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж уул зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, үйлдвэрийн байршлыг өөрчлөхийг хориглоно.	5.1.Тусгай зөвшөөрөл шаардах аж ахуйн үйл ажиллагааг хэрэв тусгайлан заасан бол тухайн нутаг дэвсгэрт явуулна.
2	6.3.Согтууруулах ундаа, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, мөн зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулах байршлаа өөрчлөхийг хориглоно.	5.3.Тусгай зөвшөөрлийг хууль зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

Дүгнэлт: Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5.4, 6.3 дахь заалтуудад тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байхыг зохицуулж өгсөн байх бөгөөд энэ зохицуулалт нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасантай агуулгын хувьд давхардсан байна.

Санал: Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5.4, 6.3-т давхардуулан хуульчилсан хэсгийг хасаж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг эшлэл хэлбэрээр оруулах нь зүйтэй.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/	Орон сууцны тухай хууль/1999.04.22/
3	5.5.Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр, орон сууц, түүний орц, хонгилд явуулахыг хориглоно.	17.1.Нийтийн зориулалттай орон сууцны байшинд барилгын төлөвлөлт, эрүүл ахуй, аюулгүй байдлын норм зөрчсөн, мөн дор дурдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно: 17.1.8.Согтууруулах ундаа үйлдвэрлэх;

Дүгнэлт: Орон сууцанд согтууруулах ундаа үйлдвэрлэхийг хориглоно гэж хоёр хуулинд агуулгын хувьд ижил байдлаар заасан байна.

Санал: Орон сууцны тухай хуульд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиас ишлэх.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль/2001.02.01/
4	4.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг даргын санал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал,	16.2.Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно: 16.2.5.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.

	дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.	
--	--	--

Дүгнэлт: Дээрхи хоёр хуульд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн засаг дарга олгоно гэж заасан нь давхардаж байна. Мөн тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгай зөвшөөрөл гэж томъёолж бичсэн. Гэтэл Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд зөвхөн зөвшөөрөл гэж бичсэн нь нэр томъёоны хувьд зөрчилтэй байна.

Санал: Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиас хасаж, Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулиас ишлэх.

Хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдсөн эсэх

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль/2001.02.01/
5	4.2.Зөвшөөрөлд согтууруулах ундааны нэр төрөл, үйлдвэрлэх арга хэрэгсэл, түүхий эд, үйлдвэрийн байршлыг болон хүчин чадлыг заана.	3.1.1.” аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ - гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг;
6	4.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.	
7	5.1.Хүнсний зориулалтын бус түүхий эдээр болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр согтууруулах ундаа үйлдвэрлэхийг хориглоно.	
8	5.4.Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж уул зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, үйлдвэрийн байршлыг өөрчлөхийг хориглоно.	
9	6.1.Аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд зааснаас бусад газарт болон гар дээрээс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.	
10	6.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, мөн зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулах байршлаа өөрчлөхийг хориглоно.	

11	7.1.Дараахь газарт согтууруулах ундаа хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно: 7.1.2.согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгжийн албан болон үйлдвэрлэлийн байр;	
12	7.2.Согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй газарт дараахь зүйлийг хориглоно:	
13	7.7.Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй зоогийн болон шөнийн цэнгээний газрыг хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр, орон сууц, түүний суурийн давхар /зориудаар тохижуулснаас бусад/-т ажиллуулахыг хориглоно.	

Дүгнэлт: Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан үйл ажиллагааг гагцхvv тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд тэдгээрт хамаарагдах үйл ажиллагааг бусад нарийвчилсан хуулиудад “тусгай зөвшөөрөл” гэсэн томъёоллоор тусгах нь зүйтэй юм.

Санал: Иймд “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн холбогдох заалтуудыг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасны дагуу өөрчлөх.

Тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
14	4.1.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, <u>нийслэлийн Засаг дарга олгож, сунгаж, хүчингүй болгоно.</u>

Дүгнэлт: Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.11.2-т сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохоор заасан. Харин Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэхэд мөн тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгагдаагүй “гагцхүү уг хуульд заасан үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох” тухай зохицуулалттай зөрчилдөж байна.

Санал: Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэхэд олгох тусгай зөвшөөрөл гэх заалтыг хасах эсвэл Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгохыг тусгах.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /2017.05.18/
15	13 ¹ дугаар зүйл. Хураагдсан спирт, согтууруулах ундаанд шинжилгээ хийх, түүнийг борлуулах, устгах	11.Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс

13^{1.1}. Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан гэмт хэрэг, зөрчлийн улмаас цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, гааль болон мэргэжлийн хяналтын байгууллага, татварын албаны эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураагдсан буюу шүүхийн шийдвэрээр хураахаар эцэслэн шийдвэрлэгдсэн согтууруулах ундааг улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж, дараахь дүгнэлтийн аль нэгийг гаргана: <i>/Энэ хэсэгт 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i> 13^{1.1.1}. эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, стандартын шаардлага хангасан тул хүнсэнд хэрэглэж болох; 13^{1.1.2}. техникийн болон хүнсний бус бусад зориулалтаар ашиглах; 13^{1.1.3}. энэ хуулийн 13^{1.1.1}, 13^{1.1.2}-т заасан зориулалтаар ашиглах шаардлага хангахгүй. 13^{1.2}. Согтууруулах ундааг хураах, шинжилгээ хийх, улсын орлого болгож борлуулах журмыг Засгийн газар батална. 13^{1.3}. Энэ хуулийн 13^{1.1.3}-д заасан согтууруулах ундааг устгах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон Улсын ерөнхий прокурор хамтран батална.	хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журмыг Засгийн газар батална.
--	---

Дүгнэлт: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоол батлагдсан бөгөөд агуулгын хувьд дээрхи хуулиудын зохицуулалт, батлагдсан Засгийн газрын шийдвэрийн агуулга давхардаж байна.

Тухайн хуулийн зүйл, заалт уг хуулийн болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
16	7.3. Дараахь хүмүүст согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно: 7.3.2. 21 нас хүрээгүй хүн.	8.1. Сургуулийн сурагч, 18 нас хүрээгүй хүмүүст согтууруулах ундаа хэрэглэх боломж олгохыг санаачлан зохион байгуулах, энэ зорилгоор орон байр ашиглуулах, мөнгөн туслалцаа үзүүлэхийг тэдгээрийн эцэг, эх, төрөл садан, асран хамгаалагчид болон багш нарт хориглоно.

Дүгнэлт: Хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх хэсэгт 21 нас хүрээгүй хүн архи хэрэглэхийг хориглосон атлаа 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт 18 нас хүрээгүй хүмүүст гэж заасан нь зөрчилтэй байна.

Санал: Иймд 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “18 нас” гэснийг “21 нас” гэж өөрчлөх.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
17	4.6. Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа

	үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан баримт бичгээс гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ: 4.6.4. татварын албаны санал, тодорхойлолт.
--	--

Дүгнэлт: Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "... тусгай зөвшөөрлийг **хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагын санал, ...**" - ийг үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгохоор буюу хоёр байгууллагын саналыг үндэслэхээр заасан хэдий ч уг зүйлд татварын албаны санал гэж нэмж тусгасан нь хуулийн дээрхи зохицуулалтуудын хооронд зөрчил үүсгэж байна.

Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
18	1.1.Энэ хуулийн зорилт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах /үйлчлэх/, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Дүгнэлт: Хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар уг хуулиар согтууруулах ундааг импортлох харилцааг зохицуулах нь хуулийн зорилт байхаар заасан боловч **импортлох асуудлыг** зохистой хэмжээнд зохицуулаагүй байна.Түүнчлэн хуульд хамрах хүрээ, болон нэр томъёоны тодорхойлолт байхгүй байгаа нь хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх хүндрэл учруулахаар байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
19	4.1. Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгоно.

Дүгнэлт: Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дүгээр зүйлд хоёр өөр субъектын саналыг үндэслэн зөвшөөрлийг олгож, хүчингүй болгож байхаар заасан боловч уг субъектүүд нь харилцан эсрэг саналтай байгаа тохиолдолд зөвшөөрөл олгож, цуцалж болох эсэх, уг санал нь ямар утга, агуулгатай байх, эсрэг саналыг хэрхэн шийдвэрлэх талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
20	4.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.

Дүгнэлт: Аймаг, нийслэл тус тусын бүрэн эрхийн хүрээнд журам батлах, уг журмын дагуу зөвшөөрөл олгохоор заасан байх бөгөөд хуулиар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох нийтлэг журам, эсхүл зарчмыг тусгаж өгөөгүй нь 21 аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт 22 өөр зохицуулалттай журам үйлчлэх нөхцөл боломжийг бий болгож байна. Энэ нь хууль нэг мөр үйлчлэх, хууль ёсны зарчим хэрэгжихэд хүндрэл үүсгэж, аж ахуй эрхлэгч, үйлчлүүлэгч нарын эрх зүйн байдлыг харилцан ялгавартайгаар тогтоох боломжийг бий болгож, согтууруулах ундааны хэрэглээтэй тэмцэх нэгдсэн бодлогын мөр чанарыг алдагдуулж байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
21	5.11. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь согтууруулах ундааны нэр, савлалтын хэмжээг татварын албанд мэдэгдэнэ.

Дүгнэлт: Хуулийн дээрхи зүйлд заасан мэдэгдэх үүргийг хэрхэн ямар журмаар биелүүлэх тухай зохицуулалт байхгүй байгаа нь хийдэл үүсгэсэн байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
22	5.9. Импортлолж болох согтууруулах ундааны жагсаалтад ороогүй согтууруулах ундааг улсын хилээр оруулах, худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

Дүгнэлт: Хуулийн дээрхи зүйлд заасан жагсаалтыг одоог хүртэл батлаагүй байна. Түүчнлэн зүйлийн гарчиг нь “Үйлдвэрлэх, импортлох” харилцаатай холбоотой байхад уг хэсэгт “худалдах, үйлчлэх” –тэй холбоотой зохицуулалтыг тусгасан нь зүйлийн гарчигтай нийцэхгүй байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
23	6.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.

Дүгнэлт: Аливаа хориглолт, хязгаарлалт тогтоосон зохицуулалтыг хуулиар тодорхой, ойлгомжтой, улсын хэмжээнд нэг мөр, ойлгогдож, хэрэглэгдэхүйц тогтоож өгөх шаардлагатай бөгөөд холбооны бус нэгдмэл улс төрийн зохион байгуулалттай манай улсын хувьд нэг аймагт хууль буст тооцогдон зөрчил гэж үзэн торгох, тусгайлан олгогдсон эрх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийтгэл хүлээх зэргээр аж ахуй эрхлэгч нарын эрх ашигт хүндээр нөлөөлж болохуйц байхад яг ижил төрлийн үйлдэл нь хэдхэн км-ийн цаана байх нөгөө аймаг, сумын нутаг дэвсгэрт хууль ёсны үйлдэл гэж үзэгдэх нь төрөөс иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэдээ алагчлахгүй байх, нэгдмэл зарчмыг алдагдуулж байна гэж үзэхээр байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
24	9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.

Дүгнэлт: Хуулийн дээрхи үүрэгжүүлсэн зохицуулалт нь хэт ерөнхий агуулгатайгаас гадна уг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хэрхэн хяналт тавих нь тодорхойгүй байгаа нь хуулийн зохицуулалтын үр нөлөөг бууруулж байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
25	9.2. Дараахь хэлбэрээр согтууруулах ундаа сурталчлахыг хориглоно: 9.2.3.согтууруулах ундаа үйлдвэрлэгч нь өөрийн аж ахуйн нэгжийн нэртэй ижил нэрээр нэрлэсэн согтууруулах ундаа үйлдвэрлэх;

Дүгнэлт: Бусдын аж ахуйн нэгжийн нэртэй ижил нэрээр нэрлэж болох эсэх нь тодорхойгүй буюу энэ тохиолдлыг хориглоогүй үлдээсэн нь хийдэл үүсгэж байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
26	9.3. Согтууруулах ундааны зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

Дүгнэлт: Согтууруулах ундаа зураг, хаяг, шошго бүхий хөргөгч, аяга гэх мэт ахуйн хэрэглээний зүйлс нь зар сурталчилгааны материалд орох эсэх, тэдгээрийг улсын хилээр нэвтрүүлэх асуудал тодорхойгүй байна.

Д/д	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
27	13 ² .3. Сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Монгол Улсын Засгийн газар батална.

Дүгнэлт: Сангийн бүрэлдэхүүн тодорхой бус байна. Бүрэлдэхүүний ерөнхий бүтэц, дүрмээр зохицуулах харилцааны ерөнхий агуулгыг хуулиар тодорхойлоогүй.